

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН ДҮГНЭЛТ:

“Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд урьдчилсан гүйцэтгэлээр 442.3 мянган иргэнийг хамруулж, нийт 18,4 тэрбум төгрөгийн зардал гаргаж, анхны шинжилгээгээр халдварын 56 голомтыг илрүүлсэн байна.

**АУДИТЫН СЭДЭВ: ГАМШГААС ХАМГААЛАХ
БҮХ НИЙТИЙН БЭЛЭН БАЙДЛЫН ЗЭРЭГТ
ШИЛЖҮҮЛСЭН 2021 ОНЫ 2 ДУГААР САРЫН 11-
23-НЫ ӨДРҮҮДЭД УЛСЫН ОНЦГОЙ
КОМИССООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН “НЭГ
ХААЛГА-НЭГ ШИНЖИЛГЭЭ” АРГА ХЭМЖЭЭНИЙ
ҮР ДҮН**

АУДИТЫН КОД: АДГ-2021/01-ШТА-ТБА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч О.Тэнгис

Утас: 261885, цахим хаяг: tengiso@audit.gov.mn

Дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням

Утас: 261885, цахим хаяг: sambuunyamya@audit.gov.mn

Улаанбаатар хот
2021 он

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	4
Зураг, дүрслэлийн жагсаалт	6
Хүснэгтийн жагсаалт	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл	7
Ерөнхий мэдээлэл.....	10

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ГАРГАСАН ШИЙДВЭР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИНЖЛЭХ УХААНЧААР БОЛОН ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ..... 11

1.1 Засгийн газар, УОК-ын холбогдох шийдвэрт салбар дундын эрсдэлийн үнэлгээний тайлангаас гаргасан саналуудыг тусгасан хэдий ч Эрдэмтдийн зөвлөлийн зөвлөмжийг бүрэн тусгаагүй байна;..... 11

1.2 “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулсан төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангагдаагүйгээс Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу өмнө хийгдсэн байх ёстой судалгаа, мэдээллийг дахин гаргах чиг үүргийг бий болгож холбогдох төрийн байгууллагуудын ажлын ачаалал нэмэгдүүлэх, тус арга хэмжээний зохион байгуулалтад оролцож байгаа төрийн албан хаагчид, шинжилгээ авч байгаа эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд хүндрэлийг үүсгэжээ;..... 12

1.3 Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор байгуулсан “Эрсдэлийн мэдээлэл харилцааны Түр хороо”-ны үйл ажиллагааны чиглэл, ажил үүргийн хуваарь, Ажлын шуурхай хэсгийн ажиллах журмыг батлан гаргаагүй, Түр хорооны үйл ажиллагаа эхлэлгүй хоног хугацаа алдсанаас МУ-ын Засгийн газар болон УОК-оос гаргасан шийдвэр, “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний цаг үеийн мэдээллийг иргэд олон нийтэд түгээх ажил хангалтгүй хэрэгжсэн байна;..... 14

1.4 УОК, НОК болон холбогдох төрийн байгууллагуудын батлан гаргасан төлөвлөгөөнүүдэд “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах хариуцан, зохион байгуулах ажлын хэсэг, байгууллага нэгжийг томилохдоо Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлагын зохицуулалт, чиг үүрэгтэй уялдуулаагүй, хуулийн этгээд, иргэний оролцоог тусгаагүй, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд суурилаагүйгээс уг арга хэмжээний хэрэгжилт доод болон дунд шатанд хэрэгжүүлэх, биелэлтийг тооцоход хүндрэлтэй байдлыг үүсгэсэн байна;..... 16

1.5 УОК-ын ажлын алба батлагдсан орон тоогоор ажиллаагүйгээс холбогдох байгууллагуудаас ирүүлж буй тайлан мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үүрэг даалгаврын биелэлт бодитой эсэхийг хянах боломж бүрдээгүй байна;..... 17

1.6 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хэрэгжилтэд МХЕГ, ЭМЯ, НЗДТГ-ын ХШҮХ-ээс хяналт тавьж, тодорхой зөрчлүүдийг арилгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна;..... 18

1.7 Хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах үйл ажиллагааг тогтоосон хугацаанд зохион байгуулсан боловч төлөвлөлт, бэлтгэл ажлыг сайжруулахад анхаарах шаардлагатай байна;..... 20

1.8 “Нэг хаалга - Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэн үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 94.5%, нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон иргэдийн хөдөлгөөнийг 96.5% хүртэл хязгаарлан дэглэмийг сахиулж ажилласан байна;..... 21

1.9 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах үед дайчлан ажиллуулах албан хаагчдыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн хуваарилсан ч цагдаа хүчний байгууллагаас бусад төрийн албан хаагчдын нэгдсэн мэдээллийн сан шинэчлэгдээгүйгээс зохион байгуулалт нь төлөвлөлтийн дагуу хэрэгжээгүй байна;..... 25

1.10 2021 оны 2 дугаар сарын 11-ээс 19-ний өдрийн хооронд иргэд олон нийтээс ирүүлсэн 34435 удаагийн дуудлага, санал хүсэлтийн 99.8%-ийг шуурхай шийдвэрлэн хариуг нь тухай бүр өгч ажиллажээ;..... 26

1.11 Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлэхээс өмнө хязгаарлалт тогтоох, шинжилгээ авахтай холбоотой ерөнхий мэдээллийг иргэдэд өгсөн ч зохион байгуулалтын талаарх нарийвчилсан, системтэй мэдээллээр бүрэн хангаагүй байна;.....	28
1.12 Цагдаагийн байгууллагаас хөл хорио, хязгаарлалтын үед гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, хэв журам сахиулах үүргээ хэрэгжүүлэн ажиллажээ;.....	31
1.13 Халдвар авсан иргэд, ойрын хавьтлыг олж тогтоох ажлыг хэрэгжүүлж ажилласан байна;.....	32

БҮЛЭГ 2. ДЭЭРХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ САНХҮҮ, ХӨРӨНГӨ, НӨӨЦИЙГ ЗОХИХ ЁСООР ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ҮР АШИГТАЙ УДИРДАЖ БАЙГАА ЭСЭХ.....34

2.1 Төлөвлөсөн арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг улсын нөөцөөс болон байгууллагын нөөцөөс гарган зарцуулсан байна;	34
2.2 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна;.....	34
2.3 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд Улсын төсвөөс санхүүжилт олгогдоогүй, Нийслэл, дүүргийн Засаг даргын нөөц сангаас зарцуулсан байна;	36
2.4 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд үйл ажиллагаанд бусад орлого, хандив, тусламжийг хэрхэн бүрдүүлж зарцуулах талаар зохицуулаагүй байна;	38
2.5 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд зориулан 296.0 сая төгрөгийн ПОС машиныг шууд худалдан авсан байна;.....	39
2.6 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Улсын нөөц, хандив, тусламжийн хөрөнгө, байгууллагын нөөцийн үлдэгдлээс зарцуулсан байна;	39
2.7 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд нийгмийн халамж үйлчилгээ шаардлагатай айл өрхүүдэд тусламж үзүүлэх ажиллагаа үндэслэлтэй төлөвлөгдөөгүй, урсгалаараа явагдсан байна;.....	40
2.8 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний шийдвэр, хөрөнгө санхүүжилтийн мэдээлэл, олон нийтэд ил тод байдлыг бүрэн хангаагүй байна;.....	42

БҮЛЭГ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНТЭЙ ОНОВЧТОЙ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ЭСЭХ44

3.1 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөөтэй нийслэл, дүүргийн онцгой комиссын төлөвлөгөөг уялдуулан төлөвлөөгүй байна;.....	44
3.2 Шинжилгээнд хамруулах зорилтот бүлгийг оновчтой тодорхойлсон байна;.....	45
3.3 Шинжилгээ авах байнгын цэг, явуулын баг төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулсан боловч цэгүүдийн ажлын ачааллыг жигд зохион байгуулаагүй байна;	46
3.4 Шинжилгээ авах үйл ажиллагаанд түр оршин суугч болон бүртгэлгүй өрхийг хамруулсан боловч нэгдсэн тоо мэдээ гаргаагүй, 355 орон гэрэгүй, тэнэмэл иргэнийг хамруулсан байна; .	49
3.5 Улсын болон Нийслэлийн онцгой комиссын удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс дүүргийн онцгой комисс шинжилгээ авах үйл ажиллагааг бодит тооцоо судалгаанд үндэслэхгүйгээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна;.....	51

ДҮГНЭЛТ58

ЗӨВЛӨМЖ..... 61

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал 63

Ирүүлсэн саналд өгөх тайлбар.....**Error! Bookmark not defined.**

ХАВСРАЛТУУД..... 64

Хавсралт 1. 64

Хавсралт 2. 66

Хавсралт 3..... 67

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт

ЗГ	Засгийн газар
УОК	Улсын Онцгой комисс
НОК	Нийслэлийн Онцгой комисс
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЗД	Засаг дарга
ЦЕГ	Цагдаагийн Ерөнхий газар
ДОК	Дүүргийн Онцгой комисс
ЗДТГ	Засаг Даргын тамгын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ХӨСҮТ	Халдварт өвчин судлалын үндэсний төв
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ТББ	Төрийн Бус Байгууллага
ХШҮХ	Хяналт Шалгалт Үнэлгээний хэлтэс
ЗТХЯ	Зам Тээвэр Хөгжлийн Яам
ХХААХҮЯ	Хүнс Хөдөө Аж Ахуйн Хөнгөн Үйлдвэрийн Яам
ХХЕГ	Хил Хамгаалах Ерөнхий газар
МХЕГ	Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газар
ЗӨСҮТ	Зоонозын Өвчин судлалын үндэсний төв
ТЕГ	Татварын Ерөнхий газар
НОБГ	Нийслэлийн Онцгой байдлын газар
НЭМГ	Нийгмийн Эрүүл мэндийн газар
УБТЗ	Улаанбаатар Төмөр зам
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
НЗД	Нийслэлийн Засаг дарга
НЗДТГ	Нийслэлийн Засаг Даргын тамгын газар
ХШҮГ	Хяналт Шалгалт Үнэлгээний газар
НШШ	Нийслэлийн Шуурхай Штаб
МХГ	Мэргэжлийн Хяналтын Газар
УБЗАА	Улаанбаатар хотын захирагчийн ажлын алба
УНТЭ	Улсын нэгдүгээр төв эмнэлэг
УХТЭ	Улсын хоёрдугаар төв эмнэлэг
НЭМҮТ	Нийгмийн Эрүүл Мэндийн Үндэсний Төв
МУЗН	Монголын Улаан Загалмайн Нийгэмлэг
НТТТ	Нийслэлийн Түргэн Тусламжийн төв
ХХМТГ	Харилцаа Холбоо Мэдээллийн Технологийн газар
НМТГ	Нийслэлийн Мэдээлэл Технологийн газар
ЗГХЭГ	Засгийн Газрын Хэрэг Эрхлэх газар
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын Их Хурал
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Зураг, дүрслэлийн жагсаалт

Зураг 1	20
Зураг 2	23
Зураг 3	24
Зураг 4	26
Зураг 5	27
Зураг 6	30
Зураг 7	31

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1 Нарийвчилсан ажлын төлөвлөгөө	13
Хүснэгт 2 Шийдвэр, чиглэлийн агуулга	22
Хүснэгт 3 Чиглэлд оруулсан өөрчлөлт, нэмэлт зохицуулалт	24
Хүснэгт 4 Төрийн албан хаагчдын судалгаа	25
Хүснэгт 5 Мэдээллийн сурвалж	29
Хүснэгт 6 Халдварын тохиолдол	33
Хүснэгт 7 "Нэг хаалга-нэг шинжилгээ" арга хэмжээний зарцуулах	35
Хүснэгт 8 Захирамжийн судалгаа (сая төгрөгөөр)	36
Хүснэгт 9 Дүүргийн Засаг даргын захирамжаар олгогдсон санхүүжилтийн гүйцэтгэлийн судалгаа (сая төгрөгөөр)	37
Хүснэгт 10 Захирамжийн судалгаа (сая төгрөгөөр)	37
Хүснэгт 11 Захирамжийн судалгаа (сая төгрөгөөр)	37
Хүснэгт 12 Захирамжийн судалгаа (сая төгрөгөөр)	38
Хүснэгт 13 Худалдан авалтын судалгаа (сая төгрөгөөр)	39
Хүснэгт 14 Нөөц бүрдүүлэлтийн судалгаа (сая төгрөгөөр)	40
Хүснэгт 15 Нөөц хөрөнгийн зарцуулалтын судалгаа (сая төгрөгөөр)	40
Хүснэгт 16 Шинжилгээнд хамруулах өрхийн тоо, шинжилгээ авах цэгийн судалгаа	46
Хүснэгт 17 Шинжилгээ авсан цэг, ажилласан хүний судалгаа	47
Хүснэгт 18 "Нэг хаалга - нэг шинжилгээ" арга хэмжээний хангалтгүй хэрэгжсэн заалтын судалгаа	48
Хүснэгт 19 Орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдардаг иргэдийн судалгаа	50
Хүснэгт 20 Нийгмийн хамгааллын тусгай төв болон Түр хоноглох үйлчилгээ үзүүлдэг ТББ-д 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр байрлуулсан иргэдийн судалгаа	50
Хүснэгт 21 Covid19.gerege.mn сайтад бүртгэгдсэн шинжилгээ өгсөн иргэдийн тоог нийт өрхийн тоотой харьцуулсан судалгаа (2021.02.24-ний өдрийн байдлаар)	51

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийх үндэслэл:

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.3-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн 2021 оны 2 дугаар сарын 11-23-ны өдрүүдэд Улсын Онцгой Комиссоос авч хэрэгжүүлэх “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний үр дүнд /бодит цагийн/ аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулах, үүсэж буй асуудлыг залруулах талаар завсар үеийн зөвлөмж өгөхөд аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газар болон Улсын онцгой комиссын гаргасан шийдвэр үйл ажиллагааг хуульд нийцүүлэн, үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх;
- Энэ үйл ажиллагаанд шаардагдах санхүү, хөрөнгө, нөөцийг зохих ёсоор төлөвлөж, бүрдүүлж, үр ашигтай удирдаж байгаа эсэх;
- Эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлж байгаа оношилгоо, шинжилгээний үйл ажиллагаа үр дүнтэй оновчтой хэрэгжиж байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ:

Аудитад цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд оролцож байгаа Улсын онцгой комисс, Цагдаагийн ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн яам, Нийслэлийн онцгой комисс болон нийслэл, дүүргийн холбогдох байгууллагуудын үйл ажиллагааг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитын явцад холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх, талбар байршлаар ажиглалт хийх зэрэг аудитын арга зүйг ашиглахаас гадна Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 5500-5599, гүйцэтгэлийн аудитын журамд дурдсан аудитын арга зүйг мөрдөн аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулж ажиллалаа. Хэрэгжилтийн байдлыг тогтоохдоо дараах арга зүйг ашигласан.

Нийслэл, дүүргийн хэмжээнд бодит цагаар /тухайн цаг үе, өдрийн байдлаарх/ талбар дээр хэрэгжиж буй үйл ажиллагааны үр дүнд үүссэн бодит нөхцөл байдлыг тогтоож, мониторинг хийж ажилласан. Үүнд:

- ✓ Гар утасны аппликэйшн ашиглаж, нийгмийн сүлжээ, фэйсбүүк, Твиттерүүд дээр форум санал асуулга явуулж, газар дээрх хэрэгжилтийн байдлыг иргэдээс санал, гомдол, үнэлгээг авах байдлаар ямар ажиллагааг хаана хэн хэрхэн гүйцэтгэж байна, юуг яаж сайжруулах шаардлагатай байгааг тогтоож, мониторинг хийж ажилласан.
- ✓ Энэхүү гар утасны цахим технологийн шийдэл ашиглаж гүйцэтгэсэн форум, санал асуулгыг 4 өөр төрлийн сэдвийг хамруулж гүйцэтгэсэн ба асуулгын сэдэв болон зорилтоосоо хамаарч нийтийг хамарсан эсхүл зорилтот бүлэгт чиглэсэн байдлаар боловсруулж хэрэгжүүлсэн.
- ✓ Үндэсний аудитын газар дээр эдгээр өдрүүдийн турш хэвлэлийн мониторингийг хийж тэдгээрээс үйл ажиллагааны алдаа, дутагдал, анхаарах асуудлуудыг илрүүлж ажилласан.

✓ Санал асуулга болон хэвлэлийн мониторингийг Нэг хаалга-Нэг шинжилгээ арга хэмжээг хэрэгжүүлсэн 2021 оны 2 дугаар сарын 11-23-ны өдрүүдийн турш бодит цагаар гүйцэтгэж, судалгааны үр дүнд өдөр бүр шинжилгээ, анализ хийж ажилласан.

✓ Дээрх ажиллагаануудаас нийслэл, дүүргүүдийн хэмжээнд эсхүл УОК, НОК, ЭМЯ гэх мэт холбогдох бусад байгууллагууд дээр аудитууд болон эрдэмтдийн баг нь хэрэгжүүлэхээр төлөвлөсөн үндсэн хөтөлбөр, горимоосоо гадна эрсдэлийн нэмэлт горимыг хэрэгжүүлэхээ тодорхойлж ажилласан.

✓ Нийслэлийн 6 дүүрэг дээр өдөр бүр аудитын багууд гарч хаана аль хороо, хэсэгт шинжилгээ авах үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгааг суурин, явуулын цэгүүд дээр болон хорооны хэсгийн ахлагчийн зүгээс бүртгэлтэй өрхүүдтэйгээ ажиллаж байгаа түвшинд тодорхойлж ажилласан.

✓ УОК, НОК, ДОК, ЭМЯ, ЦЕГ, Нийслэл, дүүргийн Засаг дарга, шуурхай штабаас Нэг хаалга-Нэг шинжилгээний үеэр 2021 оны 2 дугаар сарын 11-23-ны өдрүүдэд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнд татан төвлөрүүлэх хөрөнгө, санхүүг бэлдсэн болон зарцуулж буй байдал зэрэгт тэдгээрээс боловсруулсан баримт бичиг, материалд судалгаа хийж, ажил хариуцсан мэргэжилтэн, албан хаагч нартай ярилцлага уулзалтыг хийх, талбар дээрх тулган баталгаажуулалт хийж, холбогдох нотлох баримтыг цуглуулж ажилласан.

Нөхцөл байдал дахь хэрэгжилтийг тухайн өдрийн байдлаар бодит цагаар тогтоосноор эрсдэлийг удирдах зөвлөгөө, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд гаргаж ажилласан. Үүнд:

✓ Цаг үеийн нөхцөл байдлаар дараагийн өдөрт Нэг хаалга-Нэг шинжилгээ ажиллагааг хэрэгжүүлэхэд юунд анхаарах шаардлагатай байгааг тодорхойлж УОК, НОК-т “Завсар үеийн зөвлөмж”-ийг өдөр бүр хүргүүлж ажилласан.

✓ Нийслэл, Дүүргийн Засаг дарга, Онцгой комисс, шуурхай штабтай биечлэн уулзаж тухайн газар нутаг, нийслэл, дүүргийн хэмжээнд тэр цаг үеийн байдлаар эрсдэлийг удирдах талаар зөвлөгөөг өгч ажилласан.

✓

Аудитын бүрэлдэхүүн

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн А/13 дугаар тушаалаар байгуулагдсан Үндэсний аудитын газар болон Нийслэл дэх төрийн аудитын газрын 39 албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсэг, 12 хүний бүрэлдэхүүнтэй эрдэмтэд, шинжээчдийн баг гүйцэтгэлээ. Эдгээрийн 20 хувь нь эрдмийн зэрэг цол бүхий судлаачид оролцсон.

Аудитад ашигласан шалгуур, үзүүлэлт:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Гамшгийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 5500-5599,
- Засгийн газрын 2021 оны 27 дугаар тогтоол,
- Улсын онцгой комиссын даргын 2021 оны 12 дугаар тушаал
- бусад холбогдох эрх зүйн актууд, тайлан мэдээнүүд.

Хүндрэл бэрхшээл:

Төрийн аудитын байгууллага УОК-ийн хүсэлтээр анх удаа гамшгийн үеийн нөхцөлд, “бодит цаг”-ийн аудитыг хэрэгжүүлснээр аудитын стандартын дагуу үе шатуудыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байдлыг үүсгэсэн.

“Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хэмжээ, зохицуулалт, хариуцлагын талаар шийдвэр гараагүйгээс тус арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө, төсвийн зарцуулалтын нэгтгэл тайланг хариуцах үүрэгтэн тодорхой бус, аудитад ашиглах тоо, мэдээ, дүнг олж авахад аудитын багт хүндрэл үүсэж байлаа.

Аудитын дүн:

Аудитын хугацаанд буюу 2021 оны 2 дугаар сарын 11-ээс 23-ны хооронд аудитаар илэрсэн асуудлуудад өдөр бүр завсар үеийн зөвлөмжийг УОК, Шадар сайдын ажлын алба, НОК-т хүргүүлж ажилласан бөгөөд аудитын эцсийн үр дүн, дүгнэлтэд үндэслэн зөрчлийг арилгуулах, цаашид анхаарч ажиллахаар Монгол Улсын Ерөнхий сайдад 2, Монгол Улсын Шадар сайдад 10, Эрүүл мэндийн сайдад 7, Нийслэлийн онцгой комисст 1 нийт 20 зөвлөмжийг тус тус хүргүүлэв.

Ерөнхий мэдээлэл

БНХАУ-ын Хубэй мужийн Ухань хотод 2019 оны 12 дугаар сард шалтгаан тодорхойгүй уушгины хатгалгаа өвчний дэгдэлт бүртгэгдсэн нь шинэ төрлийн короновирусээр үүсгэгдсэн халдвар болохыг тогтоож дэлхий дахинд нийт 218 улс оронд тархаж, хүн амын эрүүл мэнд, нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учруулж байна.

Монгол улсад короновируст халдварын зөөвөрлөгдсөн тохиолдол анх 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдөр бүртгэгдсэн цагаас эхлэн манай улс Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллаж, Засгийн газар, Улсын онцгой комиссын зүгээс халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар нутаг дэвсгэрийн хэмжээнд олон арга хэмжээг зохион байгуулсан.

Короновируст халдварын батлагдсан тохиолдол манай улсад 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар дотоодын халдвар 1663, батлагдсан тохиолдол нийт 2174 болж бүртгэгдсэн байна.

Нийслэлийн хүн амын дунд тархсан халдварын тохиолдол өдөр ирэх тусам нэмэгдэж иргэдийн эрүүл мэндэд аюул занал учруулсан, Үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн нөхцөл байдал бий болж буйтай холбогдож энэхүү цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг оновчтой зохион байгуулах шаардлага үүсэж байна. Энэхүү шаардлагыг биелүүлэх үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 27 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тогтоол гарч хөл хорио тогтоон энэ хугацаанд Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн 2021 оны 2 дугаар сарын 11-23-ны өдрүүдэд Улсын Онцгой Комиссоос авч хэрэгжүүлэх “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулсан.

Үүнтэй уялдаж Төрийн аудитын байгууллага нь Улсын Онцгой Комиссоос гарсан бодлого, шийдвэр нь засаг захиргааны нутаг дэвсгэрийн нэгжид, төрийн захиргааны байгууллагын дунд болон анхан шатанд зөв зүйтэй хэрэгжиж буй эсэх, хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд нь арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй байдалд Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хөндлөнгийн хараат бус аудитыг гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР БОЛОН УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ГАРГАСАН ШИЙДВЭР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ШИНЖЛЭХ УХААНЧААР БОЛОН ХУУЛЬД НИЙЦҮҮЛЭН ҮР ДҮНТЭЙ ХЭРЭГЖҮҮЛСЭН ЭСЭХ

1.1 Засгийн газар, УОК-ын холбогдох шийдвэрт салбар дундын эрсдэлийн үнэлгээний тайлангаас гаргасан саналуудыг тусгасан хэдий ч Эрдэмтдийн зөвлөлийн зөвлөмжийг бүрэн тусгаагүй байна;

Коронавируст халдвар тархалтын үед УОК-оос авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, бодлого, шийдвэрт шинжлэх ухааны үндэслэл, нотолгоотой зөвлөмж боловсруулж, дэмжлэг үзүүлэх зорилго бүхий УОК-ын дэргэдэх эрдэмтдийн зөвлөлийг УОК-ын даргын 2020 оны 32 дугаар тушаалаар байгуулж, бүрэлдэхүүнийг 2021 оны 10 дугаар тушаалаар шинэчлэн баталж, эрдэмтдийн санал, дүгнэлтийг УОК-ын шийдвэрт тусгаж ажиллахыг УОК-ын нарийн бичгийн даргад даалгасан байна.

Тус зөвлөл нь 2021 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар нийт 70 санал бүхий 9 зөвлөмжийг УОК-т хүргүүлж ажилласан байна. Үүнээс 2021 оны 2 дугаар сарын 01, 02-ны өдрийн нийт 13 зөвлөмжөөс дараах зөвлөмжийг Засгийн газрын тогтоол, УОК-ын даргын баталсан тушаал, төлөвлөгөөнд тусгаагүй нь УОК-ын даргын 2021 оны 10 дугаар тушаалын 21-т заасантай нийцэхгүй байна. Үүнд: 2021.02.02-ны өдрийн Зөвлөмж №8

Вакцинжуулалт хийх бэлтгэл хангах хүрээнд коронавируст халдвараар өвчилж эдгэрсэн тохиолдлыг тогтоох зорилгоор ийлдсэнд эсрэг бие (SARS-Cov-2 Ab) тодорхойлох оношлуурыг оруулж ирэх, шинжилгээ хийх ажлыг эхлүүлэх гэж тусгагдсан боловч ЭМЯ-аас уг ажлын явцын талаар холбогдох баримт материал ирүүлээгүй.

УОК-ын дэргэдэх Эрдэмтдийн зөвлөлөөс “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг хэрэгжүүлэх талаар зөвлөмж гаргаагүй бөгөөд “Хөгжлийн төлөө-оном сан” ТББ-аас Монгол Улсын Ерөнхий сайдад 2021 оны 1 дүгээр сарын 05-ны өдрийн 1/87 албан бичгээр уг арга хэмжээг хэрэгжүүлэх тухай 5 саналыг анх хүргүүлсэн байна. Уг саналуудаас дараах 3 санал Засгийн газрын тогтоол, УОК-ын даргын баталсан тушаал, төлөвлөгөөнд тусгагдаагүй байна. Үүнд:

Буянт-Ухаа спорт цогцолборт төвлөрүүлэн зохион байгуулж нуклейн хүчил ялгах 20 аппарат, 40 ширхэг ПГУ шинжилгээ хийх машин, бусад техник хэрэгслээр тоноглогдсон, 150 мэргэжлийн хүмүүстэй 20 шинжилгээний нэгжээс бүрдсэн, өдөрт дор хаяж 25 мянган ПГУ шинжилгээ хийх хүчин чадалтай нэгдсэн түр төв байгуулах;

Төрөөс хамааралгүй хөндлөнгийн эрдэмтдийн төлөөлөл болсон 3-аас доошгүй тооны эрдэмтдийг Улсын Онцгой Комиссын бүрэлдэхүүнд оруулж, гаргаж буй шийдвэр бүхэн шинжлэх ухааны үндэслэлтэй стратеги төлөвлөгөө, аргачлал зөвлөмжид үндэслэсэн шинжлэх ухаанч байхад онцгой анхаарах;

Нэг өрх - Нэг иргэн шинжилгээг эрчтэй, үр дүнтэй зохион байгуулж дотоодод тархсан эх үүсвэр нь тодорхой бус халдваруудыг нэн даруй илрүүлэх, халдварын голомтыг түргэн хугацаанд хумьж хатуу хөл хорионы дэглэмийг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр сулруулах бодит нөхцөлийг бүрдүүлэх энэ ажилд Оном сангийн Эрдэмтдийн баг гар бие оролцох.

Ковид-19 цар тахлын үед хийгдэж буй эрсдэлийн үнэлгээ нь Монгол Улсын Шадар сайд, Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын

¹ УОК-ын даргын 2021 оны 10 дугаар тушаалын 2. Эрдэмтдийн зөвлөлийн санал, дүгнэлтийг УОК-ыг шийдвэрт тусгаж ажиллах

ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаалаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”, “Эрсдэлийн үнэлгээний аргачлал”-ын дагуу хийгдэж байна.

Дээрх журмын 4.1-д заасны дагуу 2020 оны 1 дүгээр сараас 2021 оны 2 дугаар сар хүртэл хугацаанд ХӨСҮТ нь дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах чиг үүрэг бүхий УОК, ЭМЯ, ЗТХЯ, ХХААХҮЯ, ОБЕГ, ХХЕГ, МХЕГ, ХӨСҮТ, ЗӨСҮТ, ЦЕГ, ТЕГ, НОК, НОБГ, НЭМГ, УБТЗ, ДЭМБ зэрэг байгууллагуудтай хамтран нийт 21 удаа үйл явдлын эрсдэлийн үнэлгээ хийхэд 2 удаа “Дунд эрсдэлтэй”, 17 удаа “Өндөр эрсдэлтэй”, 2 удаа “Маш өндөр эрсдэлтэй” гэж гарсан байна.

“Нэг хаалга – нэг шинжилгээ” арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн өмнө буюу 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр хийгдсэн 21 дэх эрсдэлийн үнэлгээгээр Улсын хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 5, Нийслэл орон нутгийн хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний 6, Хилийн боомтод авч хэрэгжүүлэх арга хэмжээний 2, нийт 13 санал гаргасан байна.

Дээрх саналууд нь Засгийн газрын 2021 оны 27 дугаар тогтоол, УОК-ын даргын баталсан төлөвлөгөө, УОК-ын хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгавар, гаргасан шийдвэр, “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө болон хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах төлөвлөгөө, хангалт зохион байгуулалт хариуцсан ажлын хэсгээс хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагджээ.

Харин УОК, НОК-ын зүгээс “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбоотой төлөвлөлтийн өмнөх үе шатанд хүний нөөц, төсөв санхүү, зохион байгуулалттай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй байна.

1.2 “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулсан төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангагдаагүйгээс Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу өмнө хийгдсэн байх ёстой судалгаа, мэдээллийг дахин гаргах чиг үүргийг бий болгож холбогдох төрийн байгууллагуудын ажлын ачаалал нэмэгдүүлэх, тус арга хэмжээний зохион байгуулалтад оролцож байгаа төрийн албан хаагчид, шинжилгээ авч байгаа эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд хүндрэлийг үүсгэжээ;

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 27 дугаар тогтоолоор нийслэл хотын нутагт дэвсгэрт 02 дугаар сарын 11-ний өдрөөс 23-ны өдөр хүртэлх хугацаанд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсний дагуу Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7-д “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед энэ хуулийн 10.3, 10.4-т заасан арга хэмжээг бүхэлд нь хэрэгжүүлнэ.” гэж заасныг бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдлөг болгох зохицуулалттай.

Үүний хүрээнд тухайн нутаг дэвсгэрт байрлах бүх “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд гамшгаас хамгаалах төлөвлөгөөндөө тодотгол хийж, хэрэгжүүлэх” үүрэгтэй. Гэтэл нийслэлийн хэмжээнд “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөг Гамшгаас хамгаалах тухай хуулийн дээрх зохицуулалттай уялдуулан төлөвлөөгүй, байгууллагуудын гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд суурилсан судалгаа, мэдээллийн сан бүрдүүлээгүй байна.

Байгууллагын гамшгаас хамгаалах төлөвлөгөө бүрт хийсэн тодотгол, түүнчлэн мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дайчлагдах хүн

хүч, авто машин, техник хэрэгслийн мэдээллийн талаарх нэгдсэн цахим санг улсын хэмжээнд бүрдүүлэх шаардлагатай.

Монгол Улсын Засгийн газар болон УОК-с гаргасан шийдвэр, төлөвлөгөөнд тусгаснаар “Нэг хаалга - нэг шинжилгээ” арга хэмжээг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах үйл ажиллагаанд давхардсан тоогоор 80 гаруй байгууллага, засаг захиргааны нэгж оролцон зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

Мөн тухайн үйл ажиллагааг зохион байгуулах чиглэлээр дараах байгууллага, албан тушаалтнууд нарийвчилсан ажлын төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлжээ. Үүнд:

Хүснэгт 1 Нарийвчилсан ажлын төлөвлөгөө

№	Төлөвлөгөөний огноо, баталсан албан тушаалтан	Төлөвлөгөөний	
		нэр, агуулга	заалтын тоо
1.	2021.02.08 Эрүүл мэндийн сайд	Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөө	15 /ЭМЯ-ны харьяа 15 байгууллага, нэгж хариуцан хэрэгжүүлэх/
2.	2021.02.08 ЦЕГ-ын даргын тушаал	Нийслэлийн хэмжээнд хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах ажлын төлөвлөгөө	
3.	2021.02.08 НЗД	Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөө	62 /НЗД-ын харьяа 35 байгууллага, нэгж хариуцан хэрэгжүүлэх/
4.	2021.02.09 НЗД	Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед 100.000 иргэнийг шинжилгээнд хамруулах арга хэмжээний төлөвлөгөө	46 /НОК, НЗД-ын харьяа 32 байгууллага, нэгж хариуцан хэрэгжүүлэх/
5.	Мөн БГД-ын Засаг даргын 2021 оны А/61, БЗД-ын Засаг даргын 2021 оны А/59, СХД-ын Засаг даргын 2021 оны А/113, СБД Засаг даргын 2021 оны А/43, ХУД-ын Засаг даргын 2021 оны А/70, ЧД-ийн Засаг даргын 2021 оны А/70 дугаар захирамжуудаар тус тус нутаг дэвсгэрийн хэмжээнд “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталсан.		

Дээрх байгууллагуудын батлан гаргасан төлөвлөгөөнүүдэд “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах хугацаа болон шинжилгээнд хамруулах иргэний тоон мэдээлэл зөрүүтэй, утга агуулгын давхардалтай төдийгүй арга хэмжээ тус бүрийг хариуцан, зохион байгуулалт хийх ажлын хэсэг, байгууллагыг томилохдоо Гамшгаас хамгаалах тухай хуулийн зохицуулалттай уялдуулж үүрэг өгөөгүй, судалгаа, тооцооллыг гаргаж хүргүүлэх, нэгтгэн хянаж хүлээж авах албан тушаалтныг тодорхой тусгаагүй байна.

Тухайлбал, ХУД-ээс бусад дүүргийн Засаг даргын захирамжид “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг 2021.02.11-13 хүртэлх 3 хоногийн хугацаанд зохион байгуулахаар тусгасан.

Мөн МУ-ын Шадар сайдын 2021.02.10-ны өдөр баталсан “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөөнд зөвхөн нийслэлийн төвийн 6-н дүүргийн 100,000 иргэдийг шинжилгээнд хамруулахаар, НЗД-ын 2021.02.10-ны өдрийн А/85 дугаар тушаалаар 119,000 иргэнийг шинжилгээнд хамруулахаар тус тус заасан. Гэтэл хэрэгжилтийн явцад 411,210 өрхийн иргэдийг шинжилгээнд хамруулах гэнэтийн өөрчлөлт хийгдсэн байна.

Дээрх байдлаар төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангагдаагүйгээс холбогдох төрийн байгууллагуудын ажлын ачаалал нэмэгдэх, тус арга хэмжээний зохион байгуулалтад оролцож байгаа төрийн албан хаагчид, шинжилгээ авч байгаа эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд хүндрэл үүсгэжээ.

1.3 Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор байгуулсан “Эрсдэлийн мэдээлэл харилцааны Түр хороо”-ны үйл ажиллагааны чиглэл, ажил үүргийн хуваарь, Ажлын шуурхай хэсгийн ажиллах журмыг батлан гаргаагүй, Түр хорооны үйл ажиллагаа эхлэлгүй хоног хугацаа алдсанаас МУ-ын Засгийн газар болон УОК-оос гаргасан шийдвэр, “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний цаг үеийн мэдээллийг иргэд олон нийтэд түгээх ажил хангалтгүй хэрэгжсэн байна;

А. Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар тогтоолоор Цагаан сарын баярын өдрийг улсын хэмжээнд тэмдэглэхгүй тухай, 2021 оны 27 дугаар тогтоолоор нийслэл хотын нутагт дэвсгэрт 02 дугаар сарын 11-ний өдрөөс 23-ны өдөр хүртэлх хугацаанд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай шийдвэрүүдийг гаргасан байна. Эдгээр шийдвэрүүд бүрэн хэрэгжиж, улсын хэмжээнд Цагаан сарын баярын өдрийг тэмдэглээгүй, нийслэлийн нутаг дэвсгэрт гурав дахь удаагаа хөл хориог заасан хугацаанд авч хэрэгжүүлсэн.

Засгийн газрын 2021 оны 29 дүгээр тогтоолоор дараах үүргийг холбогдох байгууллага, албан тушаалтанд өгсөн боловч эдгээрээс заримыг хугацаа алдаж хэрэгжүүлсэн, заримыг огт хэрэгжүүлээгүй байна.

“...үнэн зөв, бодит мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, ухуулан таниулах үүрэг бүхий “Эрсдэлийн мэдээлэл харилцааны Түр хороо”-ны бүрэлдэхүүн, хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Ажлын шуурхай хэсгийг УОК-ын дэргэд 5 хүнтэй ажиллуулах”,

“Мэдээллийг зөвхөн нэг сувгаар, түр хорооноос өгөгдсөн чиглэлийн дагуу мэдээлж байх”, “Ковид-19 холбоотой мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, ...мэдээ, мэдээллээр тогтмол, жигд хангах арга хэмжээг авах”,

“Түр хорооны үйл ажиллагааны чиглэл, ажил үүргийн хуваарь, Ажлын шуурхай хэсгийн ажиллах журмыг батлах, удирдлага, зохион байгуулалтаар хангах”

Дээрх шийдвэр, түүний хэрэгжилтээс хамааран “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний талаарх “мэдээллийг зөвхөн нэг сувгаар... мэдээлж байх” чиглэлийг дунд, доод шатанд өгсөн, уг Түр хорооны үйл ажиллагаа эхлэлгүй хугацаа алдсанаас үүдэн уг арга хэмжээний талаарх мэдээллийг 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн Засгийн газрын 2021 оны 39 дүгээр тогтоолоор Түр хорооны бүрэлдэхүүнийг өөрчлөн батлах хүртэлх 7 хоногийн хугацаанд олон нийтэд хүргэх ажлыг дээд, дунд, доод шатанд бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Тухайн нөхцөлөөс шалтгаалан “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний холбогдох мэдээ, мэдээллийг иргэд, олон нийтэд түгээх ажлыг хариуцан зохион байгуулах албан тушаалтнуудын үйл ажиллагаанд тодорхойгүй байдал үүсч, иргэд, олон нийт мэдээ, мэдээллээр бүрэн хангагдахгүй байх сөрөг үр дагавар бий болгосныг нийслэлийн Лавлагаа, мэдээллийн төвийн “1800-1200 тусгай дугаар”-ын утсанд 2021 оны 02 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд нийт 3515 дуудлага ирсний 2088 нь буюу 59.4 хувь, өдөрт ирсэн дуудлагын дунджаар 58.9

хувийг “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээтэй холбоотой асуудал эзэлж байснаас харж болно.

Иймд Засгийн газрын 2021 оны 29 дүгээр тогтоолын 6-д заасны дагуу Эрсдэлийн мэдээлэл харилцааны Түр хорооны үйл ажиллагааны чиглэл, ажил үүргийн хуваарь, Ажлын шуурхай хэсгийн ажиллах журмыг яаралтай батлан мөрдүүлэх, тухайн баримт бичгүүдийг боловсруулан гаргахдаа Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.12, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.13-д заасантай уялдуулан шийдвэрлэх шаардлагатай.

Монгол Улсын Засгийн газраас Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх шийдвэр гаргасан хэдий ч “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар тодорхой зохицуулалтыг тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2, 27, 29 дүгээр тогтоолууд болон 2021.02.03-ны өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэлд коронавируст халдвар /Covid-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний талаар ерөнхий шийдвэрийг гаргасан боловч “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг дурдаагүй байна.

Б. УОК-ын шийдвэрийн хэрэгжилтийн талаар:

УОК-ын 2021.02.03-ны өдрийн хуралдаанаар нийслэлийн хэмжээнд 2021.02.11-ний өдрөөс 2021.02.23-ны өдрийг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай асуудлыг хэлэлцэн, уг асуудлыг Засгийн газраар шийдвэрлүүлэх чиг үүргийг хуралдааны 4-р тэмдэглэлийн 1.1-д үүрэг болгосны дагуу Засгийн газрын 2021 оны 27 дугаар тогтоолыг батлуулж шийдвэрлүүлсэн байна. Мөн УОК-ын даргын 2021.02.06-ны өдрийн 12 дугаар тушаалаар нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайдаар, хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах ажлын хэсгийг ЦЕГ-ын дэд даргаар, хангалт, зохион байгуулалт хариуцсан ажлын хэсгийг НЗД-аар тус тус ахлуулж ажиллуулах шийдвэр гаргажээ.

Гэтэл УОК-ын 2021 оны 4-р тэмдэглэлийн 2.3-т “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Эрүүл мэндийн яам, Шуурхай штаб, НОК хамтран боловсруулж батлуулах” үүргийг, УОК-ын даргын 12 дугаар тушаалын 2-т уг арга хэмжээг боловсруулсан төлөвлөгөөний дагуу өндөр түвшинд зохион байгуулах үүргийг тус тус УОК гишүүдэд даалгасныг бүрэн хэрэгжүүлээгүй, уг төлөвлөгөөг тухайн байгууллагууд хамтран боловсруулаагүй байна. Улмаар Эрүүл мэндийн яам дангаар Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөөг, ЦЕГ дангаар Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед нийслэл хотын нутаг дэвсгэрт хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах нэгдсэн төлөвлөгөөг, НЗД-ын Тамгын газар дангаар “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд хангалт, зохион байгуулалт хариуцсан ажлын хэсгээс хийж

² 11.1.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас гаргах шийдвэр, арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан иргэний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарлах тохиолдолд дараах шаардлагыг нэг мөр хангана.

³ 14.1.Тохиолдсон гамшиг, аюулт үзэгдэл, ослын дүн мэдээг ... мэдээлэх, нийтийн хүртээл болгох, гамшгийн мэдээллийн санг бүрдүүлэх ажлыг улсын хэмжээнд онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулж, УОК-ын даргаар 2021.02.10-ны өдөр батлуулсан байна.

Дээрх 3 төлөвлөгөөнд “Нэг хаалга–нэг шинжилгээ” арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, хамтран зохион байгуулах байгууллага, нэгжүүдийг тусгаж үүрэг өгөхдөө Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлагын зохицуулалт, чиг үүрэгтэй уялдуулаагүй, хуулийн этгээд, иргэний оролцоог тусгаагүй, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд суурилаагүйгээс уг арга хэмжээний хэрэгжилт доод болон дунд шатанд хэрэгжүүлэх, биелэлтийг тооцоход хүндрэлтэй байдлыг үүсгэсэн байна.

УОК-ын даргын 2021 оны 14 дүгээр тушаалаар “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хүнс, ус, түлш, эм эмнэлгийн хэрэгслийн худалдаа эрхлэх байгууллагаар үйлчлүүлэх, зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ыг батлан гаргасан байна. Уг тушаалын 3-т Түр журам түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ, зохион байгуулалтын талаар олон нийт, иргэдэд сурталчлан таниулж ажиллахыг Соёлын сайдад даалгасан нь МУ-ын Засгийн газрын 2021 оны 29 дүгээр тогтоол /2021 оны 39 дүгээр тогтоолоор Түр хорооны бүрэлдэхүүнийг өөрчилсөн/-оор байгуулсан Эрсдэлийн мэдээлэл харилцааны Түр хорооны чиг үүрэгтэй давхцсан байна.

Үүнээс шалтгаалан дээрх түр журмаар зохицуулсан бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед “иргэн үйлчилгээ авахад хүлээх үүрэг”, “аж ахуйн нэгжийн иргэнд үйлчилгээ үзүүлэхэд хүлээх үүрэг”, “эрх бүхий байгууллагаас үйл ажиллагааг нь хориглоогүй албан байгууллагын ажилтны зорчих хөдөлгөөнд тавигдах шаардлага, хүлээх үүрэг” зэрэг иргэд олон нийтэд түгээж, мэдээлэх чиг үүргийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.

Иймд цаашид ковид-19 цар тахалтай холбогдуулан МУ-ын Засгийн газар болон УОК-оос гаргах шийдвэр, цаг үеийн мэдээлэл, мөн иргэд олон нийтэд хүргэх шаардлагатай заавар, зөвлөмж, уриалга зэргийг түгээх асуудлыг агуулгаар нь ангилан авч үзэх, хариуцан хэрэгжүүлэх байгууллага албан тушаалтны чиг үүргийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлж нарийвчлан журамлах шаардлагатай. Тухайлбал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн дүгээр зүйлийн, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дүгээр зүйлийн ...-д заасан зохицуулалтыг хэрэгжүүлэх асуудлаар “Хэвлэл мэдээллээр цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлийн заавар, зөвлөмж, уриалгыг тогтмол түгээх хариуцлагын гэрээ” байгуулж үүргийн хэрэгжилтийг хангуулах боломжтой.

1.4 УОК, НОК болон холбогдох төрийн байгууллагуудын батлан гаргасан төлөвлөгөөнүүдэд “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах хариуцан, зохион байгуулах ажлын хэсэг, байгууллага нэгжийг томилохдоо Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлагын зохицуулалт, чиг үүрэгтэй уялдуулаагүй, хуулийн этгээд, иргэний оролцоог тусгаагүй, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд суурилаагүйгээс уг арга хэмжээний хэрэгжилт доод болон дунд шатанд хэрэгжүүлэх, биелэлтийг тооцоход хүндрэлтэй байдлыг үүсгэсэн байна;

“Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах чиглэлээр УОК-оос гаргасан шийдвэр, үйл ажиллагааны төлөвлөгөөнд МУ-ын Шадар сайдын 2020 оны 137 дугаар тушаалаар баталсан “Коронавируст

халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед гамшгаас хамгаалах эрүүл мэндийн улсын албаны Шуурхай штаб”-ыг оролцуулах талаар тусгаагүйгээс уг Шуурхай штабын зүгээс “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний зохион байгуулалтын үйл ажиллагаанд оролцоогүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэлээр Шадар сайд (ОБЕГ)-д “УОК-ын Шуурхай штабын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, уг штабыг яаралтай шинэчлэн зохион байгуулах...” үүрэг болгосон боловч хэрэгжүүлээгүй байна.

Мөн НОК-ын даргын 2021.02.10-ны өдрийн А/05 дугаар тушаалаар НОК-ын Шуурхай штабын бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан байна. Нийслэлийн хэмжээнд “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулахдаа уг Шуурхай штабын үйл ажиллагааг түшиглэн, НЗДТГ-ын холбогдох нэгжүүд болон дүүргүүдийн онцгой комиссоос ирүүлсэн тайлан мэдээ, судалгааг нэгтгэн боловсруулж, УОК-т өдөр бүр и-мэйлээр явцын мэдээллийг гарган хүргүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэж байна.

Цаашид УОК болон УОК, НОК-ын дэргэдэх Шуурхай штаб хооронд мэдээлэл солилцох, холбогдох дата, мэдээллийн санг нэгтгэн зохион байгуулах үйл ажиллагааг цахим системийн тусламжтай уялдуулан, сайжруулах шаардлагатай байна.

1.5 УОК-ын ажлын алба батлагдсан орон тоогоор ажиллаагүйгээс холбогдох байгууллагуудаас ирүүлж буй тайлан мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үүрэг даалгаврын биелэлт бодитой эсэхийг хянах боломж бүрдээгүй байна;

УОК-ын ажиллах журмыг Засгийн газрын 2008 оны 11 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд тус журмын 1.9-д “Комиссын ажлын албаны үүргийг Онцгой байдлын ерөнхий газар гүйцэтгэнэ”, 1.11-д “Комиссын ажлын алба нь орон тооны 5 гишүүнтэй байх бөгөөд энэ нь Онцгой байдлын ерөнхий газрын орон тооны хязгаарт багтана” гэж тус тус заасан хэдий ч аудитын хамарсан хугацаанд Ажлын алба 3 орон тоотойгоор хэт их ажлын ачаалалтай ажиллаж байгаа нь ажлын чанар, бүтээмжид сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй байх тул ажлын албыг батлагдсан орон тоогоор ажиллуулах нь зохистой байна.

УОК-ын ажлын алба нь УОК-ын үүрэг даалгавар, албан бичиг, мэдээллийг ОБЕГ-ын Гамшгийн шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төвөөр дамжуулан түгээдэг хэдий ч “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулж буй төрийн байгууллагын албан хаагчид албан цахим шуудангийн багтаамж багатай, цахим шуудан солилцох хурд удаан зэргээс шалтгаалан Gmail, Yahoo mail хаяг, Viber, Telegram зэрэг гар утасны програмыг албан ажилд ашиглаж буй байдал нийтлэг ажиглагдаж байгаа нь Засгийн газрын 2018 оны 138 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт⁴ заасантай нийцээгүй, төрийн байгууллагуудын мэдээллийн аюулгүй байдал алдагдах эрсдэлийг үүсгэж байна.

УОК-ын ажлын албаны зүгээс ЭМЯ, МХЕГ, ЦЕГ, НОК-ын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээний өдөр тутмын тайлан, мэдээ, хурлын тэмдэглэлээр өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хүлээн авч нэгтгэн, танилцуулж буй хэдий ч үүрэг даалгаврын биелэлт бодитой эсэхэд хяналт тавих цаг хугацаа, хүний нөөц хангалтгүй байна.

⁴ Засгийн газрын 2018 оны “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” 138 дугаар тогтоолын 2. Төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийн ... албан бичиг, баримтыг олон нийтийн сүлжээгээр дамжуулах болон тусгай программ хангамж ашиглан олон нийтийн сүлжээнд хандахыг хориглох чиглэлээр зохион байгуулалтын арга хэмжээ авч, мэдээллийн аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн өмчит хуулийн этгээдийн дарга нарт үүрэг болгож, холбогдох бусад төрийн байгууллага, албан тушаалтнуудад зөвлөсүгэй.

Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр 9 дүгээр зүйлийн 9.23-т “Цар тахлын үед Засгийн газар, төрийн бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй цар тахлын хүрээг тогтоохтой холбоотой тоон мэдээ, мэдээллийг шуурхай солилцох журмыг Цагдаагийн төв байгууллага, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана” гэж нэмсэн бөгөөд уг журам одоогоор батлагдаагүй байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 271 дүгээр зүйлийн 271.5.”Улсын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ” гэж заасан бөгөөд УОК-ын даргын тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ОБЕГ-ын дарга, УОК-ын орлогч даргад үүрэг болгосон 2021 оны 14, 15 дугаар тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж буй байдал хангалтгүй байна. Тухайлбал,

УОК-ын даргын 2021.02.10-ны өдрийн 14 дүгээр тушаал:

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг авах, хүнс, ус, түлш, эм эмнэлгийн хэрэгслийн худалдаа эрхлэх байгууллагаар үйлчлүүлэх, зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журмыг баталж, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг НЗД, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлж ажиллахыг ЦЕГ, МХЕГ, УОК-ын Шуурхай штабын дарга нарт, түр журам, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ, зохион байгуулалтын талаар олон нийт, иргэдэд сурталчлан таниулж ажиллахыг Соёлын сайдад үүрэг болгож, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

УОК-ын даргын 2021.02.11-ний өдрийн 15 дугаар тушаал:

Хамтын ажиллагааг зохицуулах, үйл ажиллагааны уялдааг хангах, удирдлага, зохион байгуулалтад мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагаанд зөвлөмж өгөх үүрэг бүхий яамдын дэд сайд нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг байгуулж, ажлын явц, санал дүгнэлтээ тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /С.Баатаржав/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

УОК-ын ажлын албаны зүгээс 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Соёлын яам, Цагдаагийн ерөнхий газарт УОК-ын даргын 14 , 15 дугаар тушаалын хэрэгжилтийг ирүүлэх талаар цахимаар мэдэгдсэн боловч биелэлтийг ирүүлээгүй байна.

Иймд Гамшгаас хамгаалах тухай хуулийн 271 дүгээр зүйлийн 271.1.3-д “Гамшгаас хамгаалах алба, орон нутгийн онцгой комисс, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн гамшгаас хамгаалах асуудлаар хүлээсэн эрх, үүргийн хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох” гэж заасныг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

1.6 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хэрэгжилтэд МХЕГ, ЭМЯ, НЗДТГ-ын ХШҮХ-ээс хяналт тавьж, тодорхой зөрчлүүдийг арилгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна;

Засгийн газрын 2021 оны 27 дугаар тогтоолоор “2 дугаар сарын 11-23 өдрүүдэд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагааны жагсаалтыг баталж, хэрэгжилтийг хангаж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг НЗД-д, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах”-ыг Шадар сайд, УОК-ын даргад үүрэг болгосон байна.

Хяналтын чиглэлээр “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөөний 2.1-т 2 арга хэмжээ, “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний Хангалт, зохион байгуулалт хариуцсан ажлын хэсгээс хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2.11-т 5 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан байна.

“Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөөнд:

- ЭМС-ын 2021 оны А/46 дугаар тушаалын дагуу коронавируст халдвар илрүүлэх шинжилгээ хийх цэгүүдийн бэлэн байдлыг хангах үйл ажиллагаа,
- Тусгай дугаарын 119, 1800-0119 утас, цахим, албан бичгээр иргэдээс ирж байгаа санал, гомдлын шийдвэрлэлтийн байдалд ЭМЯ-ны ХШҮГ хяналт, үнэлгээ хийх,

Хангалт, зохион байгуулалт хариуцсан ажлын хэсгээс хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд:

- Бүх нийтийн бэлэн байдлын үед ажиллаж байгаа ААНБ-ын хүнс, бараа бүтээгдэхүүн, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдал,
- Урьдчилан сэргийлэх, голомтын эцсийн халдваргүйтэл хийх үйл ажиллагаа,
- Батлагдсан болон сэжигтэй тохиолдлын хавьтлыг тусгаарлах, эмчлэх, эмнэлгийн бэлэн байдал, халдвараас сэргийлэх дэглэмийн хэрэгжилт,
- “Түргэвчилсэн болон PCR оношилгоо хийх цэг”-ийн үйл ажиллагааны халдвар хамгааллын дэглэмийн мөрдөлтөд Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар хяналт тавих,
- Нэг хаалга-нэг шинжилгээ арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд НЗДТГ-ын Хяналт, шалгалт үнэлгээний хэлтэс хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,

ЭМЯ-ны ХШҮГ нь УОК-ын даргын 2021 оны 12 дугаар тушаал, ЭМС-ын 2021 оны А/46 дугаар тушаалын дагуу “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хэрэгжилтэд өдөр тутам мониторинг хийж, “Эрүүл мэндийн тусгай дугаар 1800-0119, 119”-ын үйл ажиллагаа болон нөхцөл байдалтай танилцан, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэн, санал зөвлөмжийг хүргүүлж ажилласан талаар тайлан мэдээ ирүүлсэн.

Суурин болон явуулын цэгт хийсэн хяналт

- Сонгинохайрхан дүүргийн 18 цэг, Баянгол дүүргийн 11 цэг, Хан-Уул дүүргийн 12 цэг, Чингэлтэй дүүргийн 12 цэг, Сүхбаатар дүүргийн 16 цэг, Баянзүрх дүүргийн 8 цэг, Найлах дүүргийн 1 цэг, нийт 78 суурин цэг болон явуулын багийн үйл ажиллагаанд 2021 оны 02 дугаар сарын 11-21-ний өдрүүдэд, дараах төрлийн зөрчлийг илрүүлэн газар дээр нь арилгуулах, зарим асуудлыг ЭМЯ, НЭМГ болон дүүргийн ЭМТ-ийн удирдлага, албан хаагчдад уламжилж ажилласан байна.
 - ПОС машин, хүний нөөцийн хувьд дутагдалтайгаас хүлээгдэл ихтэй байх,
 - Бамбар болон сорьц багцлах уут дутуу ирэх,
 - Байнгын цэгт аюултай хог хаягдал хадгалах хэсгийг шар бүсээс тусгаарлалт хийгээгүй, эмнэлгийн хог хаягдлыг түр хадгалахдаа тусгаарлалт хийгээгүй, хүний зам дээр тавьсан,
 - Явуулын цэгийн халдвар хамгааллын дэглэм зөрчигдөж, урсгал холилдсон зөрчил,
 - Иргэдийн бүртгэл хийж байгаа албан хаагч хамгаалалтын хувцасгүй,
 - Сорьц тээвэрлэх савны термометргүй, мөс нь хайлсан зэрэг зөрчлүүдийг илрүүлж,

Эрүүл мэндийн тусгай дугаарын /1800-0118, 119/


- Нийт 286 санал, гомдол ирснээс ПГУ шинжилгээний хариу удаашралтай гарч байгаа талаар 114 (39.3%), шинжилгээний цэг, явуулын багийн үйл ажиллагаатай холбоотой 89 (30.7%), УОК, НШШ, зорчих хөдөлгөөний хязгаарлалттай холбоотой 34 (11.7%), тусгаарлалт болон коронавируст халдвар батлагдсан тохиолдолтой холбоотой 28 (9.7%), коронавируст халдварын эсрэг вакцинтай холбоотой 6 (2.1%), эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой санал, гомдол 17 (5.9%) байна, 8 талархал бүртгэгдсэн байна,

Мэргэжлийн хяналтын байгууллагаас “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд 176 улсын /ахлах/ байцаагч 2021 оны 2 дугаар сарын 11-ний өдрөөс өдөр бүр шинжилгээний суурин болон явуулын цэгт шинжилгээ авч буй үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлж, нийт 418 зөрчил, дутагдал илрүүлж 259 зөрчил, дутагдлыг арилгуулж, шинжилгээ авч буй үйл ажиллагаатай холбоотой 870 мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна. Тухайлбал.

- Шинжилгээ авах цэгийн урсгал, зохион байгуулалтыг буруу бэлтгэсэн, Цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийг зааврын дагуу хугацаанд нь хийгээгүй, аюултай хог хаягдлыг түр хадгалах өрөөгүй, хүйтэн хэлхээ хөлдүү төлөвөө алдсан, температур хэмжигч байхгүй, сорьцыг тушаалын дагуу тээвэрлээгүй, явуулын багийн сорьц зөөвөрлөх саванд температур

хэмжигч байхгүй, Энгийн хог хаягдал, аюултай хог хаягдлыг ангилан ялгаагүй зэрэг зөрчлүүд нийтлэг илэрсэн байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын шалгалтын дүн, мэдээ



Зураг 1

НОК-ын “Шуурхай штаб”-ын бүрэлдэхүүнд ажиллаж буй Эрсдэлийн үнэлгээ, хяналт шинжилгээ, судалгааны баг “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний явцад хяналт шинжилгээ, эрсдэлийн үнэлгээ хийж, шуурхай штабт нэгтгэгдэж буй салбар бүрийн мэдээ, тайланд үндэслэн эрсдэлийн хяналтын матриц боловсруулж, эрсдэл бүхий чиглэл, үйл ажиллагаа, анхаарах асуудлаар зөвлөмж, танилцуулж ажиллаж байна.

НОК-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/05 дугаар тушаалаар тус багийг байгуулсан, ажлын төлөвлөгөөг 2 дугаар сарын 14-ний өдөр баталсан зэргээс “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээ хэрэгжих хугацааны эхний 4 хоногт эрсдэлийн үнэлгээ, хяналт шинжилгээ, судалгааны багийн хяналт хэрэгжээгүй байна.

УОК-оос гаргасан шийдвэрт ОБЕГ-аас хяналт тавьж ажиллах талаар 4.7-д тусгасан.

1.7 Хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах үйл ажиллагааг тогтоосон хугацаанд зохион байгуулсан боловч төлөвлөлт, бэлтгэл ажлыг сайжруулахад анхаарах шаардлагатай байна;

Ерөнхий мэдээлэл

“Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд ЗГ-аас нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2021 оны 2 дугаар сарын 11-ний өглөөний 6 цагаас 23-ны өглөөний 6 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх бэлтгэл ажил, зохион байгуулалттай холбоотой ЗГ, УОК, НОК-ийн төлөвлөгөө, шийдвэрийг хугацааны дарааллын хувьд авч үзвэл дараах байдлаар гарчээ. Үүнд:



1.8 “Нэг хаалга - Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэн үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 94.5%, нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон иргэдийн хөдөлгөөнийг 96.5% хүртэл хязгаарлан дэглэмийг сахиулж ажилласан байна;

Нийслэлийн Засаг даргын баталсан төлөвлөгөөний хүрээнд Тээврийн цагдаагийн албанаас нийслэлийн нутаг дэвсгэрт хязгаарлалтын дэглэм тогтоож, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах ажлын нарийвчилсан төлөвлөгөө, хуваарь гарган баталжээ.

Хязгаарлалтын дэглэм тогтоох хугацаанд 70 байршилд 179 ширхэг блок, хаалт байрлуулж Тээврийн цагдаагийн газрын 653 алба хаагч болон 61 сонсогчийг шалган нэвтрүүлэх 6 товчоо, өдрийн цагт 140, шөнийн цагт 55 хяналтын цэгт ажиллуулахаар төлөвлөжээ.

Төлөвлөсний дагуу хяналтын болон хязгаарлалтын цэг, хаалтуудыг байгуулж, байрлуулж ажилласан боловч Дотоод хэргийн их сургуулийн 61 сонсогчийг татан оролцуулах асуудал шийдвэрлэгдээгүйн улмаас шөнийн цагт цагдаагийн алба хаагч бүртэй хамт 1 сонсогч ажиллуулахаар төлөвлөсөн хэрэгжээгүй байна. Энэ нь шөнийн цагаар хяналтын цэгт дангаараа үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг дагуулж байна.

Бэлтгэл ажлын хүрээнд Тээврийн цагдаагийн албанаас бүх нийтийн хөл хорио тогтоох үед зорчих хөдөлгөөнийг 100 хувь хяналтад авах, хязгаарлалт тогтоогоогүй 14 ААНБ-ын албан хаагчид хөдөлгөөнд оролцох үед 5.0 мянга орчим тээврийн хэрэгслийг хөдөлгөөнд оролцуулан зорчих хөдөлгөөний 93 хүртэл хувийг, томоохон хүнсний худалдааны төвүүд нээх үед 150.0-200.0 мянга орчим буюу 50 хүртэл хувийг хязгаарлах, өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг буурах үед ердийн горимд шилжүүлэн ажиллуулахаар эрсдэлийг төлөвлөж тооцоолжээ.

Гэтэл бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлэх тухай Засгийн газрын 27 дугаар тогтоол, зорчих хөдөлгөөнийг зохицуулах тухай УОК-ын 14 тушаалаар баталсан түр журам нь 2 дугаар сарын 10-нд буюу хязгаарлалтын дэглэм тогтоохын өмнөх өдөр гарч 14 чиглэлийн байгууллага, хуулийн этгээдийг үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрч, үүнээс 2 чиглэлийн байгууллагын ажилтан, албан хаагчдын 10 хүртэл хувийг, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтнуудыг тооны хязгаартайгаар иргэний үнэмлэх, ажлын үнэмлэх, коронавирусын халдварын PCR шинжилгээний хариутай зорчуулахаар шийдвэрлэсэн байна.

Дээрх байдлаар шийдвэрүүд нь хязгаарлалтын дэглэм эхлэхийн өмнөх өдөр гарсан, зорчих тээврийн хэрэгслийг хэрхэн зохицуулах талаар тодорхой төлөвлөж тусгаагүйн улмаас бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах, хэрэгжүүлэхэд хүндрэл учирч үйл ажиллагаа нь зөвшөөрөгдсөн 14 чиглэлийн байгууллагаас тогтоосон хязгаарт багтаан зайлшгүй ажиллуулах шаардлагатай ажилтан, албан хаагчид, зорчих тээврийн хэрэгслийн судалгаа, мэдээллийг гаргуулах, хянах, шинжилгээнд урьдчилан хамруулах зайлшгүй шаардлагатай талаар мэдээлэл түгээх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломжгүйд хүрчээ.

Энэ нь хяналт, хязгаарлалтын цэгүүд дээр ажиллаж байсан цагдаагийн байгууллагын албан хаагчид, иргэд, олон нийтийн дунд үл ойлголцлыг бий болгосон байна.

Нийслэлийн онцгой комиссоос нутгийн захиргааны байгууллагуудад хандан хязгаарлалтын хугацаанд ажиллах 10 хүртэлх хувьд багтах албан хаагчдын нэрс, хувийн тээврийн хэрэгслийн марк, улсын дугаарыг ирүүлэх талаар 2 дугаар сарын 11-нд 48 тоот албан бичгийг хүргүүлсэн боловч хорио цээрийн дэглэм нэгэнт хэрэгжиж эхэлсэн байсан тул бүрэн хэмжээнд мэдээлэл цуглуулах, мөн хувийн хэвшлийн ААНБ-аас авах ямар ч боломжгүй байжээ.

Мөн хязгаарлалтын дэглэм тогтоох үед үйл ажиллагааг нь хориглоогүй ААНБ-ын ажилтан, албан хаагчдын хэдэн хувийг хөдөлгөөнд оролцуулах, ямар ямар төрлийн бичиг баримт шаардах талаар 2 дугаар сарын 08-аас 15-н хүртэлх 7 хоногийн хугацаанд гаргасан шийдвэр, чиглэлүүд нь харилцан уялдаагүй, тодорхой бус, байнга өөрчлөгдөж байсныг хүснэгтээр харьцуулан харуулав.


Хүснэгт 2 Шийдвэр, чиглэлийн агуулга

№	Шийдвэрийн огноо дугаар	Шийдвэрийн товч агуулга	Ажилтан албан хаагч	Шаардах баримт бичиг			
				Иргэний үнэмлэх	Ажлын үнэмлэх	PCR шинжилгээний хариу	Албан газрын тодорхойлолт
1	2021.02.08 Нийслэлийн ЗД, Зохион байгуулах төлөвлөгөө	- Хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээд - Дайчлан ажиллах ажилтан, албан хаагчид (26 дахь заалт)	-	✗	✓	✗	✓
2	2021.02.10 УОК-ын даргын 14 тоот тушаал, Хөдөлгөөн зохицуулах түр журам	- Үйл ажиллагааг нь хориглоогүй албан байгууллагын ажилтан, албан хаагч нь тогтоосон цагийн хуваарийн дагуу (4.1 дэх заалт) - Шинжилгээнд хамрагдаагүй ажилтан, албан хаагчийг ажилдаа явахыг хориглоно. (4.3 дахь заалт)	10%	✓	✓	✓	✗

3	2021.02.10 Нийслэлийн ЗД-ын А/87 дугаар захирамж	- Хязгаарлалт тогтоогоогүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, албан хаагчид - Хувийн болон албаны тээврийн хэрэгслээр	10-15%	✗	✓	✗	✓
4	2021.02.14 УОК-ын даргын 787 тоот албан бичиг	- Яам, агентлаг, төрийн болон нутгийн захиргааны ажилтан, албан хаагчид - Хувийн болон албаны нэгдсэн унаагаар	5 хүртэл %	✗	✓	✗	✓
5	2021.02.15 НОК-ийн 55 тоот албан бичиг	- 2021.02.08-ны өдрөөс хойш шинжилгээ өгсөн бол - Нэг хаалга нэг шинжилгээний хүрээнд гэр бүлийн нэг гишүүн хамрагдсан бол	-	✓	✗	✓	✗

Хоорондоо уялдаагүй, төлөвлөлтгүй шийдвэрүүд гарах, өөрчлөгдөх зэргээр хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэж байсан боловч НОК-ын Шуурхай штаб, Тээврийн цагдаагийн алба нь цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг нэгтгэн танилцуулах, шуурхай шийдвэрлэх, гаргасан шийдвэр, чиглэлүүдийг холбогдох нэгжүүд, гудамж замын хяналт, хязгаарлалтын цэгүүдэд ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдад богино долгионы станц, Viber, Telegram application ашиглан түгээх зэргээр нэгдсэн удирдлагаар хангаж ажиллажээ.

Үүний үр дүнд зорчигч болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлахаар төлөвлөснийг хэрэгжүүлж, хязгаарлалт тогтоосон 12 хоногийн эхний 3 өдөрт нийслэлд бүртгэлтэй 410.0 мянга орчим тээврийн хэрэгслийн 6.5, дараагийн 4 өдөрт 18.7 хүртэл хувь нь хөдөлгөөнд оролцсон мэдээтэй байна.



Зураг 2

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим 2 дугаар сарын 14-өөс эхлэн нэмэгдсэн нь хүнсний үйлдвэрлэл, тээвэрлэлт түгээлт, худалдааны байгууллагууд үйл ажиллагаатай холбоотой байна.

Зорчигч болон тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хязгаарлалтын дэглэмтэй холбоотойгоор Нийтийн тээврийн үйлчилгээний газарт нийтийн тээврийн хөдөлгөөнийг тусгай горимд шилжүүлж, төрийн байгууллагын ажилтан, албан хаагчдыг тээвэрлэх ажлыг зохион байгуулах ажлыг хариуцуулжээ.

Төрийн албан хаагчдад үйлчлэх тусгай үйлчилгээнд 2 дугаар сарын 11-ээс 23-ны хооронд 6 чиглэлд 140 автобусыг өглөө 05:30-09:30, өдөр 13:30-15:30, орой 19:00-22:30 гэсэн цагийн хуваариар ажиллуулахаар төлөвлөж, үйлчилгээний чиглэл, зураглал, ажлын даалгаврыг баталж, албан хаагчдын ажлын үнэмлэхийг шалгаж үйлчилгээ үзүүлэх чиглэлийг тээврийн үйлчилгээний аж ахуйн нэгж байгууллагуудад өгчээ.

Тусгай үйлчилгээний батлагдсан чиглэл, зураглал, ажлын даалгаврыг хэрэгжүүлэх явцад НОК-оос өөрчлөлт оруулах чиглэл өгснөөр тээврийн

хэрэгслийн тоо, ажиллах цагийн хуваарь, үйлчилгээний чиглэлд 2 дугаар сарын 11-ээс хойш 6 өдрийн дотор 4 удаа өөрчлөлт, нэмэлт зохицуулалт хийсэн байна.


Хүснэгт 3 Чиглэлд оруулсан өөрчлөлт, нэмэлт зохицуулалт

Д/д	Огноо	Оруулсан өөрчлөлт, нэмэлт зохицуулалт		
		Чиглэлийн тоо	Тээврийн хэрэгслийн тоо	Ажиллах цагийн хуваарь
1	2021.02.11			
2	2021.02.12	+5	+40	
3	2021.02.13	-5	-40	
4	2021.02.14			
5	2021.02.15	+5	+59	Өглөөний эхлэх цаг, өдрийн эхлэх, дуусах цаг, оройны эхлэх цагт өөрчлөлт орсон.
6	2021.02.16	+1	+83	Өглөөний эхлэх цагт өөрчлөлт орсон.

Дээрх байдлаар богино хугацаанд байнга өөрчлөлт оруулж байгаа нь шийдвэрийг хэрэгжүүлэх, зохион байгуулах Нийтийн тээврийн үйлчилгээний газарт тээврийн зохицуулалт, төлөвлөлт хийх, цагийн хуваарийг боловсруулах, цахим системд ажлын даалгаврын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг бэлтгэж оруулах, шуурхай зохицуулалтыг үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж байгууллагуудад мэдэгдэж, тээврийн хэрэгслийн бэлэн байдал, халдвар хамгааллын дэглэмийг хангуулах, жолоочийн хуваарь хийх зэрэг бэлтгэл ажлыг хангахад цаг хугацааны хувьд хүндрэл үүсгэсэн байна.

Мөн нийтийн тээврийн уг тусгай үйлчилгээг зөвхөн төрийн албан хаагчдыг тээвэрлэхээр Нийслэлийн ЗД-ын баталсан төлөвлөгөөнд тусгасан ч үйл ажиллагааг хориглоогүй 14 чиглэлийн байгууллага, хуулийн этгээдийн ажилтан албан хаагчдад үйлчлэхээр шийдвэрлэсэн боловч бодит нөхцөл байдалд тэдгээр чиг үүрэгт хамаарахгүй байгууллагын албан хаагчид, иргэд зорчжээ.

Өдөрт дунджаар нийтийн тээврийн хэрэгслээр 341.0 мянган иргэн үйлчлүүлдэг бол хязгаарлалтын дэглэмийн үед 6.0-79.1 мянган иргэн зорчсон байна.



Зураг 3

Хязгаарлалтын дэглэм тогтоосон эхний өдөр 5 бүсэд хөдөлгөөнт болон суурин 16 байршилд авто тээврийн 14 улсын байцаагч ажиллаж байсныг 2 дугаар сарын 12-оос улсын байцаагч 16, шалгагч 30, Нийтийн тээврийн газрын 43 ажилтан, албан хаагч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр, 2 дугаар сарын 14-ний өдрөөс

шалгагчийн тоог 140, мөн 16-ны өдрөөс 180 болгож нэмэгдүүлэх байдлаар хяналт шалгалтад ажиллах хүчийг нэмэгдүүлэн зохион байгуулснаар зорчигчийн хөдөлгөөнийг 96.5 хүртэл хувийг хязгаарласан байна.

"Нэг хаалга-нэг шинжилгээ" арга хэмжээний хүрээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэн үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 94.5%, нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон иргэдийн хөдөлгөөнийг 96.5% хүртэл хязгаарлан дэглэмийг сахиулж ажилласан байна.

1.9 Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах үед дайчлан ажиллуулах албан хаагчдыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн хуваарилсан ч цагдаа хүчний байгууллагаас бусад төрийн албан хаагчдын нэгдсэн мэдээллийн сан шинэчлэгдээгүйгээс зохион байгуулалт нь төлөвлөлтийн дагуу хэрэгжээгүй байна;

УОК-оос 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 730 дугаар албан бичгээр төрийн болон нутгийн захиргааны байгууллагуудад төрийн албан хаагчдыг эргүүлийн чиглэлд ажиллуулах, хөл хорионы дэглэмийн үед хэв журам сахиулах ажилтан, албан хаагчдын тооцоог цагдаагийн байгууллага гаргаж оршин суугаа газрын ойролцоо үүрэг гүйцэтгүүлэх чиглэл өгчээ.

Хяналт тавих зорилгоор цагдаа, дотоодын цэргийн байгууллагын алба хаагчдаас гадна төр захиргааны байгууллагаас 26298 албан хаагчдыг нэмэгдлээр эргүүл, хяналт тавих үйл ажиллагаанд татан ажиллуулах тооцоо судалгаа гаргаж УОК-т хүргүүлжээ. Гэтэл УОК-оос 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдөр яам, агентлаг, төр захиргааны байгууллагын 13000 гаруй албан хаагчийн нэрсийн жагсаалт ирүүлжээ.

ЦЕГ дээрх мэдээлэлд тулгуурлан 1 цагдаагийн албан хаагчид 10 төрийн албан хаагчийн бүрэлдэхүүнтэй байхаар 1300 гаруй баг ажиллуулахаар төлөвлөжээ.

Хүснэгт 4 Төрийн албан хаагчдын судалгаа

"Нэг хаалга нэг шинжилгээ" арга хэмжээний хүрээнд эргүүлд ажилласан төрийн албан хаагчдын тоон судалгаа

№	Дүүрэг	Эргүүлийн байршил, цэгийн тоо		Эргүүлд ажилласан багийн тоо /1 цагдаагийн алба хаагч, 20-35 төрийн албан хаагч/			Эргүүлд ажилласан төрийн албан хаагчийн тоо	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хариуцсан	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баянгол	1,554	994	199	56	1,990	1,990	1,630
2	Баянзүрх	1,642	1,039	196	87	1,960	1,960	1,689
3	Сүхбаатар	1,638	404	230	49	2,300	2,300	749
4	Сонгино хайрхан	1,748	484	221	71	2,210	2,210	880
5	Хан-Уул	1,365	691	172	58	1,720	1,720	1,432
6	Чингэлтэй	1,604	365	219	44	2,190	2,190	534
7	Багануур	135	45	21	4	210	210	24
8	Налайх	220	29	39	10	390	390	72
9	Багахангай	75	11	13	4	130	130	28
Нийт		9,981	4,062	1,310	383	14	13,100	7,039

Гүйцэтгэлээр 7039 албан хаагч буюу 53.7% нь үүрэг гүйцэтгэсэн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Төрийн албан хаагчдын оршин суугаа болон бүртгэлтэй хаяг зөрүүтэй, нэр давхардах, өвчтэй, тусгаарлалтад байсан, ажлаас чөлөөлөгдсөн байх;
- Зарим төрийн албан хаагчдын утасны дугаар нь өөрчлөгдөх, холбогдохгүй байх зэргээр эргүүлд ажиллах талаар мэдэгдэх боломжгүйд хүрэх;

- Байгууллагын удирдлага нь төрийн албан хаагчдын ажлын ачаалал, хуваарилалтыг оновчтой зохион байгуулаагүйгээс ажил үүрэг нь давхардах;
- 2 дугаар сарын 12-ны өдрөөс 5451 эмэгтэй төрийн албан хаагчдыг эргүүлд ажиллах үүргээс чөлөөлөх чиглэл өгснөөр албан хаагчдын тоо буурсан.

Мөн явган эргүүлд ажиллах албан хаагчдын тооцоо судалгааг гаргахад төрийн байгууллагуудын хүний нөөцийн шинэчлэгдээгүй мэдээллийн баазыг ашигласан, төрийн албан хаагчдыг ажиллуулах тооцоолол, хуваарь хийх, нягтлах цаг хугацаа бага байсан зэрэг хүндрэлүүд гарсан байна.

Гэвч цагдаагийн байгууллагын зүгээс тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан хуваарилалтыг хийж хяналт тавин ажиллажээ.

Эргүүлд ажиллаж байгаа төрийн албан хаагчдаас ажиллах нөхцөл, тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар тодруулахад зарим албан хаагчийн хувьд оршин суугаа хаягаасаа хол газар эргүүлд гарах тохиолдолд хоол, унаа, бие засах газрын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай, оройн цагаар ээлжээс буухад нийтийн тээврийн хэрэгсэл зогссон байх үед алхаж харих зэрэг хүндрэлүүд байгаа талаар дурдаж байсан.


Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах нөхцөл үүссэн үед дайчлан ажиллуулах төрийн албан хаагчдын судалгаа, дэлгэрэнгүй мэдээлэл бүхий санг бүрдүүлэх шаардлагатай байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах үед дайчлан ажиллуулах албан хаагчдыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн хуваарилсан ч цагдаа хүчний байгууллагаас бусад төрийн албан хаагчдын нэгдсэн мэдээллийн сан шинэчлэгдээгүйгээс зохион байгуулалт нь төлөвлөлтийн дагуу хэрэгжээгүй байна.

1.10 2021 оны 2 дугаар сарын 11-ээс 19-ний өдрийн хооронд иргэд олон нийтээс ирүүлсэн 34435 удаагийн дуудлага, санал хүсэлтийн 99.8%-ийг шуурхай шийдвэрлэн хариуг нь тухай бүр өгч ажиллажээ;

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөөний 2.1.3-т “Тусгай дугаарын 119, 1800-0119 утас, цахим, албан бичгээр иргэдээс ирж байгаа санал, гомдлын шийдвэрлэлтэд хяналт хийх”, 2.2.6-д “...Эрүүл мэндийн байгууллагуудад лавлагаа, мэдээллийн утас ажиллуулах, иргэдээс ирсэн санал хүсэлтийг шуурхай шийдвэрлэх” ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан.


Бүх нийтийн бэлэн байдлын үед Нийгмийн Эрүүл мэндийн үндэсний төвийн мэдээллийн “119”, Эрүүл Мэндийн хөгжлийн төвийн “1800-0119”, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн CallCenter-ийн “1800-1200” тусгай дугаар, дүүргүүдийн лавлагаа мэдээллийн утаснуудад иргэд, олон нийтээс зөвлөгөө мэдээлэл авах, санал хүсэлт гаргах зэргээр нийт 34435 удаа хандсан байна.



Иргэдээс тусгай дугааруудад ирүүлсэн дуудлагын мэдээлэлд судалгаа хийхэд хязгаарлалтын дэглэм тогтоосон эхний 4 хоногт дунджаар 2700 орчим дуудлага ирж байсан бол 2 дугаар сарын 15, 16-ны өдрүүдэд 2 дахин өсөж 5100-д хүрсэн нь хязгаарлалт хамаарахгүй 14 чиглэлийн байгууллагууд үйл ажиллагаагаа эхлүүлэх, халдварын идэвхгүй бүсэд хамаарах өрхийн иргэд шинжилгээ хаана хэрхэн өгөх талаар лавлах, мэдээлэл авах нь ихэссэнтэй холбоотой байна.

Тусгай дугаарын болон дүүргүүдийн лавлагаа мэдээллийн утаснуудад ирсэн нийт дуудлагын 34379 буюу 99.8%-ийг нь тухай бүр шийдвэрлэж хариуг шуурхай өгч ажиллажээ.

Иргэдийн хандсан дуудлагыг ангилж үзвэл 45.0% нь “Нэг хаалга – Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд хийгдэх шинжилгээ, зохион байгуулалттай холбоотой асуудлаар хандсан байна.




Зураг 5

Аудит хийх явцад 119, 1800-0119, 1800-1200 тусгай дугаарын утсанд санал хүсэлт ирүүлсэн иргэдээс 46 иргэнийг түүвэрлэн утсаар холбогдож тодруулахад 26 буюу 56.6% нь шийдвэрлэгдсэн, 20 буюу 43.4% нь шийдвэрлээгүй гэсэн хариултыг өгсөн. Үүнд:

- 119 тусгай дугаарын утсанд холбогдон санал хүсэлт ирүүлсэн 16 иргэнээс 11 нь шийдвэрлүүлсэн, 5 нь шийдвэрлүүлээгүй;
- 1800-0119 дугаарын утсанд холбогдон санал хүсэлт ирүүлсэн 14 иргэнээс 5 нь шийдвэрлүүлсэн, 9 нь шийдвэрлүүлээгүй;
- 1800-1200 дугаарын утсанд холбогдон санал хүсэлт ирүүлсэн 16 иргэнээс 10 нь шийдвэрлүүлсэн, 6 нь шийдвэрлүүлээгүй.

Энэ нь санал хүсэлт ирүүлсэн иргэдэд шийдвэрлэсэн байдлаа эргэж мэдээлээгүй, зөвлөгөө мэдээллээр бүрэн хангаагүйтэй холбоотой байна.

Өргөдөл гомдлын агуулгыг судлахад хөл хорио тогтоох шаардлага, бодит нөхцөл байдал дахин үүссэн тохиолдолд хязгаарлалтын дэглэм тогтоосон үед иргэдэд тулгамдсан дараах асуудлуудад анхаарал хандуулах шаардлагатай.



2021 оны 2 дугаар сарын 11-ээс 19-ний өдрийн хооронд иргэд олон нийтээс ирүүлсэн 34435 удаагийн дуудлага, санал хүсэлтийн 99.8%-ийг шуурхай шийдвэрлэн хариуг нь тухай бүр өгч ажиллажээ.

1.11 Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлэхээс өмнө хязгаарлалт тогтоох, шинжилгээ авахтай холбоотой ерөнхий мэдээллийг иргэдэд өгсөн ч зохион байгуулалтын талаарх нарийвчилсан, системтэй мэдээллээр бүрэн хангаагүй байна;

ОБЕГ-ын даргын 2020 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/306 дугаар тушаалаар баталсан Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний төлөвлөгөөний 3.2⁵, 7.4.2.3⁶, 7.4.2.4⁷, 7.4.2.5⁸ дахь хэсгүүдэд холбогдох байгууллагуудаас мэдээллийг олон нийтэд ил тод, шуурхай хүргэх хэлбэр, эх үүсвэр зэргийг тусгажээ.

УОК-ын 2021 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр хуралдааны тэмдэглэлийн 2.2⁹-д бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн хугацаанд авах арга хэмжээг аж ахуйн нэгж байгууллага, айл өрх, иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх, хязгаарлалтын дэглэм тогтоох үеийн ач холбогдлыг мэдээлж ойлгуулах талаар улсын онцгой комиссын гишүүдэд даалгасан байна.

Бүх нийтийн бэлэн байдлын зэргийн үед иргэд бэлтгэл, бэлэн байдлаа хэрхэн хангах талаарх зөвлөмж, мэдээллийг ЗГ-ын www.zasag.mn, www.e-mongolia.mn цахим хуудас, “Монгол Улсын Засгийн газар”, “УОК-ын Шуурхай штаб” фейсбүүк хуудсанд байршуулан дараах агуулгын хүрээнд олон нийтэд мэдээлэл өгч ажилласан байна.


⁵ 3.2. Цар тахалтай тэмцэх үеийн мэдээ, мэдээлэл, урьдчилан сэргийлэх сурталчилгааг аймаг, нийслэлийн хэмжээнд бүх төрлийн хэвлэл мэдээлэл, олон нийтийн цахим сүлжээ, үүрэн телефоны оператор, харилцаа холбооны сүлжээг ашиглан иргэд, олон нийтэд ил тод, шуурхай, хүртээмжтэй байдлаар хүргэнэ.

⁶ Иргэд олон нийтэд коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх талаар зөвлөмж, тараах материалыг хэвлэх, байгууллагын цахим хуудсанд байршуулах.

⁷ Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх шторк бэлтгэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд түгээх.

⁸ Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комисс, Шуурхай штаб болон мэргэжлийн байгууллагуудаас гарсан, тогтоол, тушаал, удирдамжийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, иргэдэд хүргэх.

⁹ Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн хугацаанд авах арга хэмжээг аж ахуйн нэгж байгууллага, айл өрх, иргэд, олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх, хязгаарлалтын дэглэм тогтоох үеийн ач холбогдлыг мэдээлж ойлгуулах.



Иргэдэд хөл хорио тогтоохоос өмнө бэлтгэл ажлаа хангах нөхцлийг бүрдүүлэхийн тулд 2 дугаар сарын 11-ний өдөр хүртэлх хугацаанд шаардлагатай мэдээ, мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй хүргэсэн эсэхийг судлах зорилгоор хандалт ихтэй хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд тавигдсан мэдээллүүдээс хязгаарлалт тогтоохтой холбоотой мэдээллүүдийг түүвэрлэн авч үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:


- “Монгол Улсын Засгийн газар”, “УОК-ын Шуурхай штаб”, “Улаанбаатар Эрүүл мэндийн газар” фейсбүүк хуудас, “25 дугаар суваг телевиз”, “Ийглийн мэдээ”, “lkon.mn”, “Zarig.mn” зэрэг цахим хуудсанд 55 удаагийн мэдээлэл байршиж, 2690 удаа олон нийт хуваалцан санал сэтгэгдэл үлдээсэн,
- Нийслэл, дүүргийн ЗДТГ, Онцгой комиссоос цахим болон фейсбүүк хуудас, бусад хэлбэрээр 2329 удаагийн мэдээлэл хүргэжээ.

Хүснэгт 5 Мэдээллийн сурвалж

Мэдээлэл хүргэсэн байдал /2021 оны 2 дугаар сарын 11-ний өдөр хүртэл хугацаанд/

	Мэдээллийн эх үүсвэр	Тоо	Мэдээллийн эх үүсвэр	Тоо
Нийслэл	http://ulaanbaatar.mn/	14	Нийслэлийн мэдээ facebook хуудас болон бусад эх үүсвэр	40
БГД	http://www.bgd.mn/	7	Дүүрэг, хороодын facebook хуудас болон бусад эх үүсвэр	1185
БЗД	http://bzd.ub.gov.mn/	6	Дүүрэг, хороодын facebook хуудас болон бусад эх үүсвэр	11
БНД	http://bnd.ub.gov.mn/	7		
БХД	http://bagakhangai.ub.gov.mn/	1		
НД	http://nad.ub.gov.mn/	14		
СХД	http://shd.mn/mn/	9	Дүүрэг, хороодын facebook хуудас болон бусад эх үүсвэр	412
СБД	http://sbd.gov.mn/	10	Дүүрэг, хороодын facebook хуудас болон бусад эх үүсвэр	88
ХУД	http://www.khanuul.mn/	20	Дүүрэг, хороодын facebook хуудас болон бусад эх үүсвэр	382
ЧД	http://www.chingeltei.gov.mn/	2	Дүүрэг, хороодын facebook хуудас болон бусад эх үүсвэр	121
		90		2239

Аудит хийх явцад “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд хязгаарлалт тогтоохоос өмнө иргэд бэлтгэл ажлаа хангахад шаардлагатай мэдээллээр хангагдсан эсэх талаар санал асуулгыг авахад судалгаанд оролцогчдын 50-аас дээш хувь нь өрхөөс ирж авах эсэх, шинжилгээний цэгийн байршил, хугацаа, анхаарах зүйлс, үйлчилгээ авах, хөдөлгөөнд оролцоход шаардлагатай бичиг баримтын талаарх мэдээллийг 2 дугаар сарын 11-ний өдрөөс өмнө авч чадаагүй гэсэн хариултыг өгсөн байна.



Зураг 6

Мөн олон нийтэд хүрч буй мэдээлэл нь зөрүү, хүртээмж нь дутмагаас “Нэг хаалга - Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжүүлэхэд дараах хүндрэлтэй болон эрсдэлтэй асуудлууд үүсэж байжээ. Үүнд:

- УОК-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 14 дүгээр тушаалаар баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед иргэдийн эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах, хүнс, ус, түлш, эм эмнэлгийн хэрэгслийн худалдаа эрхлэх байгууллагаар үйлчлүүлэх, зорчих хөдөлгөөнийг зохицуулах түр журам”-ыг иргэд олон нийтэд сурталчлах, таниулах мэдээлэх ажил хийгдээгүй, албан ёсны цахим хуудсанд байршуулаагүй байх
- Хөл хорионы үед иргэд эдлэх эрх, хүлээх үүргээ мэдэхгүй байх.
- Хязгаарлалт тогтоогоогүй 4 чиглэлийн байгууллагын үйл ажиллагаа 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэхтэй холбоотойгоор ажилтан, албан хаагчид PCR шинжилгээнд заавал хамрагдах шаардлагатай эсэх талаар нэгдсэн мэдээлэл хангалтгүйгээс шинжилгээний цэгийн ачаалал ихсэх, дараалал үүсэх.
- Зорчих хөдөлгөөнд оролцоход биедээ авч явах бичиг баримттай холбоотойгоор цагдаагийн алба хаагч, иргэдийн дунд үл ойлголцол үүсэх.
- Өрхийн аль 1 иргэн заавал шинжилгээ өгөх талаарх мэдээлэл дутмаг байснаас шалтгаалан шинжилгээ авахаар төлөвлөсөн өрхийн иргэд шинжилгээнд сайн дураар хамрагдахгүй байх.
- Өрхийн бүх гишүүд шинжилгээнд хамрагдахаар хүсэлт гаргах.
- Халдварын идэвхтэй бүсийн өрхийг эхний ээлжид шинжилгээнд хамруулах талаарх мэдээлэл дутмагаас халдваргүй бүсийн иргэд халдварын идэвхтэй бүсэд шинжилгээ өгөхөөр очих.

Мэдээллийн зөрүүтэй байдлаас шалтгаалан 2021 оны 2 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд шинжилгээ авах цэгүүдийн ачаалал өмнөх өдрүүдээс эрс ихэссэн байна.

Чингэлтэй дүүрэг. 117-р сургууль
2021.02.14-ний өдөр. 16:26 цаг



Баянзүрх дүүрэг. 69-р сургууль
2021.02.14-ний өдөр. 13:30 цаг



Сүхбаатар дүүрэг. 58-р сургууль
2021.02.14-ний өдөр. 11:41 цаг



Баянгол дүүрэг. 47-р сургууль
2021.02.15-ны өдөр. 14:00 цаг



Зураг 7

Зөвлөгөө мэдээлэл, санал хүсэлт авах тусгай дугаарын утаснуудад 2021 оны 2 дугаар сарын 11-ээс 19-ний өдрийг дуустал хугацаанд ирсэн дуудлага, санал хүсэлтийн 45.0% нь “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээнд хамаарч байгаа нь нэг талаас өмнөх хугацаанд иргэдэд шаардлагатай мэдээллийг хүргээгүйтэй холбоотой байна.

Хязгаарлалт тогтоохоос өмнө иргэдийн зүгээс бэлтгэл, бэлэн байдлаа хангах талаар нэн шаардлагатай мэдээ, мэдээллийг хүргэх, батлагдсан дүрэм, журмыг сурталчлан таниулах ажил дутуу хийгдсэн, холбогдох мэдээллийг зөвхөн Онцгой комисс, төрийн байгууллагуудын түвшинд ашиглах төдийгөөр мэдээллийн урсгал хязгаарлагдсан байна.

Иргэдэд мэдээлэл дутмаг хүрсэн нь 2021 оны 2 дугаар сарын 14-15-ны өдрүүдэд үл ойлголцол бий болох, шинжилгээ авах цэгүүдийн ачаалал ихсэх, дараалал үүсэж олон нийтийг бухимдуулах нэг шалтгаан болжээ.

Энэ нь Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 5.1.2-т заасан шуурхай, ил тод, хариуцлагатай байх зарчим, 7.1.11¹⁰ -т заасан үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах үүргээ шат шатанд хэрэгжүүлээгүйг харуулж байна.

Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлэхээс өмнө хязгаарлалт тогтоох, шинжилгээ авахтай холбоотой ерөнхий мэдээллийг иргэдэд өгсөн ч зохион байгуулалтын талаарх нарийвчилсан, системтэй мэдээллээр бүрэн хангаагүй байна.

1.12 Цагдаагийн байгууллагаас хөл хорио, хязгаарлалтын үед гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, хэв журам сахиулах үүргээ хэрэгжүүлэн ажиллажээ;

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед нийслэлийн нутаг дэвсгэрт хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах нэгдсэн төлөвлөгөөний 1.3- тусгагдсаны дагуу төлөвлөгөө, зураглал, хуваарь гарган нийт

¹⁰ 7.1.11. цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүл мэндээ хамгаалах арга замын талаар үнэн зөв, бодит мэдээллээр иргэдийг тогтмол, шуурхай, хүртээмжтэй хангах;

8937 ажилтан албан хаагчийг 3 ээлжээр томилон үүрэг гүйцэтгүүлжээ.

Хэв журам сахиулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ

- 4292 хүнсний дэлгүүр, 163 ресторан, кафе, 156 зах худалдааны төвийг шалгасан.
- Онцын шаардлагагүй гэрээсээ гарсан, амны хаалт зүүгээгүй 21172 иргэнд шаардлага тавьсан.
- Баталгаат бус замын хяналтын цэгт ирсэн 1686 авто машин, 2483 иргэний буцаасан. Цахимаар 487 удаа, хэвлэл мэдээллийн хэрэгслээр 36 удаа, чанга яригчаар 6793 удаа сэрэмжлүүлэг мэдээлсэн.

2021 оны 2 дугаар сарын 11-ээс 18-ны өдрийг хүртэл цагдаагийн байгууллагад гэмт хэргийн шинжтэй 357, зөрчлийн шинжтэй 4319, зам тээврийн ослын 232, бусад төрлийн 4249, нийт 9157 дуудлага, мэдээлэл бүртгэгдсэн байна.

Гэмт хэргийн нөхцөл байдлыг хөл хорионы өмнөх долоо хоногтой харьцуулахад гэр бүлийн хүчирхийлэл 33.0%, ахуйн хүрээнд үйлдэгддэг гэмт хэргүүд 280.0%, эрүүлжүүлэгдсэн хүн 7.0%-иар өсөж гудамж талбайд үйлдэгдэх гэмт хэргүүд 70.0%-иар буурчээ.

Зөрчлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1311 дахь заалтыг зөрчсөн 5051 иргэн, ААНБ-д 230.8 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авсан байна.

Цагдаагийн байгууллагаас хөл хорио, хязгаарлалтын үед гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, хэв журам сахиулах үүргээ хэрэгжүүлэн ажиллажээ.

1.13 Халдвар авсан иргэд, ойрын хавьтлыг олж тогтоох ажлыг хэрэгжүүлж ажилласан байна;

Эрүүл мэндийн сайдын баталсан 2020 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн коронавируст халдварын цар тахлын үед эрүүл мэндийн улсын алба-тохиолдлын удирдлагын тогтолцооны хариу арга хэмжээний тодотгосон дэлгэрэнгүй төлөвлөгөөнд үүссэн нөхцөл байдал, сэжигтэй болон халдвартай тохиолдлын талаар яаралтай мэдээлэх, голомтын хүрээ тогтоох, хамгаалалтад авах арга хэмжээг ХӨСҮТ, УОК-ийн шуурхай штаб, тандалтын багт хариуцуулсан байна.

Мөн МУ-ын Шадар сайдын 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 155 дугаар тушаалаар баталсан “Тусгаарлан ажиглалт болон гэрийн ажиглалтыг зохицуулах түр журам”-ын 16.2-т “Сэжигтэй тохиолдлын тодорхойлолтод тохирч байгаа иргэнийг өрөөнд нь, ажилтан, албан хаагчдыг урьдчилан бэлтгэсэн түр тусгаарлах өрөөнд тусгаарлаж, нийслэлд ХӨСҮТ-ийн 119, 100, 80086829 дугаарын утсанд мэдэгдэж, шилжүүлнэ” гэж заажээ.

НОК-ийн даргын 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдөр баталсан Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах төлөвлөгөөний 37 дахь хэсэгт батлагдсан тохиолдол, ойрын болон дам хавьтлыг тогтоож, тусгаарлах, гэрийн ажиглалтад шилжүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээг ХӨСҮТ хариуцахаар тусгажээ.

“Нэг хаалга нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд хийгдсэн шинжилгээгээр 2021 оны 2 дугаар сарын 23-ны 09:00 цагийн байдлаар анхны шинжилгээгээр халдварын 56 тохиолдол батлагдсан байна.

¹¹ 5.13 дугаар зүйл. Гамшгаас хамгаалах тухай хууль зөрчих

Хүснэгт 6 Халдварын тохиолдол

№	Халдвар илэрсэн дүүрэг	Батлагдсан халдварын тоо		
		Анхны шинжилгээгээр батлагдсан	Батлагдсан тохиолдлын ойрын хавьтлаас илрүүлсэн	Нийт
1	Баянгол	11	12	23
2	Баянзүрх	2	6	8
3	Сонгинохайрхан	8	11	19
4	Сүхбаатар	4	6	10
5	Хан –Уул	14	23	37
6	Чингэлтэй	17	8	25
Нийт		56	66	122

Коронавирусын халдвар авсан тэдгээр иргэдийн гэр бүл, найз нөхөд зэрэг ойрын хавьтлыг олж тогтоох, шинжилгээнд хамруулах ажлыг ХӨСҮТ-ээс холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулж хэрэгжүүлснээр батлагдсан тохиолдлын ойрын хавьтлаас халдварын 66 тохиолдлыг илрүүлсэн байна.

Халдвар авсан иргэд, ойрын хавьтлыг олж тогтоох ажлыг хэрэгжүүлж ажилласан байна.

БҮЛЭГ 2. ЭНЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ САНХҮҮ, ХӨРӨНГӨ, НӨӨЦИЙГ ЗОХИХ ЁСООР ТӨЛӨВЛӨЖ, БҮРДҮҮЛЖ, ҮР АШИГТАЙ УДИРДАЖ БАЙГАА ЭСЭХ

2.1 Төлөвлөсөн арга хэмжээнд шаардлагатай хөрөнгийг улсын нөөцөөс болон байгууллагын нөөцөөс гарган зарцуулсан байна;

МУ-ын Шадар сайд, УОК-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 12 дугаар тушаалд арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнүүдийг баталжээ. Уг арга хэмжээтэй холбоотой зарим санхүү, хөрөнгө, нөөц, хангалтын талаар тодорхой шийдвэр гараагүй байна.

Мөн МУ-ын Шадар сайд, УОК-ын даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө”-г баталсан бөгөөд баталсан тогтоол, албан даалгавар, тушаал гараагүй байгаа нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.4-д. “гамшгаас хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх асуудлаар тогтоол, албан даалгавар, тушаал гаргах;” заалттай нийцэхгүй байна.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дугаар зүйлийн 27¹.1.6-д “шаардлагатай тохиолдолд гамшгаас хамгаалах арга хэмжээг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах шуурхай штабыг, орон нутагт шуурхай бүлгийг байгуулж, ажиллуулах”, 27¹.2-д “Орон нутгийн онцгой комисс нь энэ хуулийн 27¹.1.1, 27¹.1.2, 27¹.1.3, 27¹.1.4, 27¹.1.5, 27¹.1.6, 27¹.1.7-д заасан бүрэн эрхээс өөрийн эрх хэмжээний хүрээнд хамаарах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.”, 27¹.4-д “Шуурхай штаб, шуурхай бүлгийн үйл ажиллагааны зардлыг Засгийн газрын, орон нутагт Засаг даргын нөөц хөрөнгөөс тус тус санхүүжүүлнэ.” 27¹.5-д “Улсын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.” заалтуудтай бүрэн нийцэхгүй байна.

“Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд нийт 411 мянган иргэнийг хамруулан, 30,661.8 сая төгрөгийн зардал гаргахаар төсөвлөснөөс урьдчилсан гүйцэтгэлээр 442.3 мянган иргэнийг хамруулж, нийт 18,413.2 сая төгрөгийн зардал гаргаж, 12,248.6 сая төгрөгөөр бага буюу 65.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Арга хэмжээний нэг иргэнийг шинжилгээнд хамруулахад дунджаар 41.6 мянган төгрөгийн зардал гарсан байна.

2.2 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг хууль, журмын дагуу үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлээгүй байна;

Арга хэмжээтэй холбоотой төсвийн тооцооллын талаар:

Нийслэлийн онцгой комиссын Санхүүгийн алба “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд зарцуулах төсвийн тооцооллыг хийж УОК-т хүргүүлсэн боловч шийдвэр гарч албан ёсоор баталгаажуулаагүй байна.

НОК-оос төсвийг тооцохдоо 2020.02.11-ны өдрөөс 2020.02.23-ны өдөр хүртэл 411000 шинжилгээнд хамруулна гэж төлөвлөн ЦЕГ, ДОК, НЭМГ-аас судалгаанууд авч дараах байдлаар зардлын төсөв хийсэн байна. Үүнд:

Хүснэгт 7 "Нэг хаалга-нэг шинжилгээ" арга хэмжээний зарцуулах зардлын төсвийн төсөл (сая төгрөгөөр)

№	Зардлын зүйл	Дүн
1	Шинжилгээний зардалд	23,199.1
2	Үйл ажиллагааны зардалд	1,999.4
3	Ажиллах бүрэлдэхүүний хоолны зардалд	3,140.4
4	Орлого тасарсан иргэдэд хүнсний хангамжийн зардалд	2,322.8
НИЙТ ЗАРДЛЫН ДҮН		30,661.7

Нийслэлийн Онцгой комисс нийт 30,661.8 сая төгрөгийн зардлыг төсөвлөн Улсын Онцгой комисст танилцуулж Засгийн газрын хуралдаанд танилцуулан санал оруулсан боловч тодорхой шийд гараагүй байна.

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн 2021 оны 2 дугаар сарын 11-23-ны өдрүүдэд Улсын Онцгой Комиссоос авч хэрэгжүүлэх “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд зарцуулах зардлын төсвийн тооцооллыг нягтлан, шийдвэр гарган баталгаажуулаагүй байгаа нь Гамшгийн тухай хуулийн 51 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт бүлгийн 51 дүгээр зүйлийн 51.4-д “Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах төвлөрсөн арга хэмжээний зардлыг улсын төсвөөс, аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах арга хэмжээний зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээд зардлаа өөрөө хариуцна” гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

“Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээ эхлэхээс өмнө шийдвэр гараагүй байсан хэдий ч 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдөр МУ-ын Засгийн газрын 40 дугаар тогтоол гарч Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг ямар эх үүсвэрээс гаргахыг баталж, тус бүрийн төсөв захирагч нарт зөвшөөрсөн байна.

Хуралдааны тохиролцооны дагуу үйл ажиллагааны чиглэлээр шинжилгээнд шаардагдах хэрэгслийг нөөцөөсөө гарган нөхөн дүүргэлт хийх, ажиллах бүрэлдэхүүний урсгал зардлуудыг Нийслэл, дүүргийн нөөц сангуудаасаа гаргах гэсэн шийдвэрээр:

- ✓ Шинжилгээ авахтай холбоотой зардлыг Эрүүл мэндийн Яам;
- ✓ Эмзэг бүлгийн болон орлого тасарсан иргэдэд хүнсний хангамж олгох зардлыг Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яам;
- ✓ Бусад үйл ажиллагааны зардлыг Нийслэл, дүүргийн Засаг даргын нөөц сангаас;
- ✓ Ажиллах хүчний хоол, шатахууны зардлыг харьяа байгууллагууд нь хариуцахаар болсон байна.

Шийдвэр гаргасан тухайд:

“Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээтэй холбоотой Нийслэлийн Засаг даргын 2021.02.10-ны өдрийн А/88 дугаар захирамж гарсан бөгөөд үүнд үйл ажиллагаанд зарцуулах 2.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулахаар шийдвэрлэсэн байна. Гэвч Төрийн сангийн гүйлгээ хаагдсан тул гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх олгохоор ж эхлээд байна.

Мөн “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээтэй холбоотойгоор НОК болон ДОК-оос гаргасан санхүү төсөв, худалдан авалт, хангалт, халамжийн

үйлчилгээтэй холбоотой гарсан шийдвэрүүдийг нэгтгэж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 8 Захирамжийн судалгаа (сая төгрөгөөр)

д/д	Хаанаас	Захирамжийн			мөнгөн дүн	Тайлбар
		огноо	дугаар	тэргүү		
1	НЗД	2021.02.10	A/88	Хөрөнгө гаргах тухай	2,531.0	
2	БГД	2021.02.10	A/61	Хөрөнгө гаргах тухай	30.6	
3	БЗД	2021.02.10	A/59	Хөрөнгө гаргах тухай	10.5	
4	ХУД	2021.02.10	A/66	Хөрөнгө гаргах тухай	12.3	ХУД нийт 56.4 сая төгрөгийн арга хэмжээтэй холбоотой захирамж гарсан
5	ХУД	2021.02.10	A/67	Хөрөнгө гаргах тухай	10.6	
6	ХУД	2021.02.10	A/68	Хөрөнгө гаргах тухай	33.5	
7	ЧД	2021.02.10	A/63	Хөрөнгө гаргах тухай	87.9	
8	СБД	2021.02.10	A/43	Хөрөнгө гаргах тухай	257.7	
9	СХД	2021.02.10	A/113		Зардлын нэр төрөл, дүнгүй, төсөв гаргаж баталгаажуулаагүй байна.	
ДҮН					2,974.1	

Эх сурвалж: Нийслэл дүүргийн Засаг дарга нарын захирамж

2.3 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд Улсын төсвөөс санхүүжилт олгогдоогүй, Нийслэл, дүүргийн Засаг даргын нөөц сангаас зарцуулсан байна;

Улсын төсвөөс 2021 оны 2 дугаар сарын 11-23-ны өдөр явагдсан “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд тусгайлан санхүүжилт олгох шийдвэр гараагүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 40 дүгээр тогтоолд Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг баталсан байна. Үүнд:

- Засгийн газрын нөөц сангаас Хууль зүй, дотоод хэргийн яаманд Цагдаагийн байгууллагаас нийслэлийн гудамж талбай, тусгаарлах байр, хяналтын цэгүүдэд үүрэг гүйцэтгэх албан хаагчдын халдвар хамгааллын хэрэгсэл, хоол, шатахууны зардалд 484.9 сая төгрөг;
- Улсын нөөцөөс 2,589.1 сая төгрөгийн бараа, материал;
- УОК-т ААНБ, иргэдээс ирүүлсэн хандив, хүмүүнлэгийн тусламжийн эх үүсвэрээс 163.8 сая төгрөгийн бараа материал гаргах гэсэн шийдвэрүүд нь “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд хамааралтай байна.

НЗД-ын нөөц сангаас батлагдсан 2,531.0 сая төгрөгийг бүрэн зарцуулсан, Дүүргүүдийн Засаг дарга нар Засаг даргын нөөц сангаас нийт 443.1 сая төгрөгийн

хөрөнгө гаргахаар захирамж гарсан ба гүйцэтгэлээр 794.0 сая төгрөгийн зардал гарсан гэсэн урьдчилсан мэдээ, судалгаа ирүүлээд байна

Хүснэгт 9 Дүүргийн Засаг даргын захирамжаар олгогдсон санхүүжилтийн гүйцэтгэлийн судалгаа (сая төгрөгөөр)

д/д	Захирамж гаргасан	Захирамжийн дүн	Гүйцэтгэл	Зөрүү
2	Багануур дүүргийн Засаг дарга	-	124.9	(124.9)
3	Баянгол дүүргийн Засаг дарга	30.6	88.5	(-57.9)
4	Баянзүрх дүүргийн Засаг дарга	10.4	46.0	(-35.5)
5	Багахангай дүүргийн засаг дарга	-	0.9	(-0.9)
6	Налайх дүүргийн Засаг дарга	-	31.3	(-31.3)
7	Хан-Уул дүүргийн Засаг дарга	56.4	188.7	(-132.3)
8	Чингэлтэй дүүргийн засаг дарга	87.9	78.3	9.5
9	Сүхбаатар дүүргийн Засаг дарга	257.8	197.1	60.6
10	Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга	-	38.3	(-38.3)
	ДҮН	443.1	794.0	(-350.9)

Эх сурвалж: Нийслэлийн Онцгой комиссоос ирүүлсэн судалгаа

Гүйцэтгэлээр нийт 794.0 сая төгрөгийг зарцуулсан тухай урьдчилсан байдлаар мэдээ судалгааг ирүүлээд байна.

Хүснэгт 10 Захирамжийн судалгаа (сая төгрөгөөр)

Зардлын төрөл	Ариутгал	Тээвэр шатахуун	Хоол	Шуудан холбоо	Хамгаалах хэрэгсэл	Бусад	Нийт дүн
УБ	180.3	894.7	1,045.0	411.0	-	-	2,531.0
БНД	-	7.3	19.4	-	98.2	-	124.9
БХД	-	0.4	0.1	0.2	0.2	-	0.9
НД	-	4.4	3.9	-	23.0	-	31.3
БГД	0.6	13.5	15.5	2.5	47.3	9.0	88.5
БЗД	-	12.5	27.0	6.5	-	-	46.0
СБД	73.9	7.5	32.3	-	73.8	9.7	197.1
СХД	-	9.2	16.2	-	12.9	-	38.3
ХУД	54.2	17.9	20.1	0.3	67.5	28.8	188.7
ЧД	2.4	4.5	15.7	9.5	42.3	4.0	78.3
Дүн	131.1	77.1	150.1	19.0	365.2	51.5	794.0
Нийт дүн	311.4	971.8	1,195.2	430.0	365.2	51.5	3,325.0

Эх сурвалж: Нийслэлийн Онцгой комиссоос ирүүлсэн судалгаа

Нийслэл, дүүргүүд нийт 3,325.0 сая төгрөгийн зардлыг зарцуулсан ба хамгийн их буюу 1,195.2 сая төгрөгийг хоолны зардалд, хамгийн бага буюу 51.5 сая төгрөгийг бусад зардалд тус тус зарцуулсан байна.

Хүснэгт 11 Захирамжийн судалгаа (сая төгрөгөөр)

д/д	Захирамж гаргасан	Захирамж дүн	Гүйцэтгэл	Зөрүү
1	Нийслэлийн Засаг дарга	2531.0	2531.0	-
2	БНД Засаг дарга	-	124.9	(124.9)
3	БГД Засаг дарга	30.6	88.5	(57.9)

4	БЗД Засаг дарга	10.5	46.0	(35.5)
5	БХД засаг дарга	-	0.9	(0.9)
6	НД Засаг дарга	-	31.3	(31.3)
7	ХУД Засаг дарга	56.4	188.7	(132.3)
8	ЧД засаг дарга	87.9	78.3	9.6
9	СБД Засаг дарга	257.8	197.1	60.6
10	СХД Засаг дарга	-	38.3	(38.3)
	ДҮН	2974.1	3325.0	(350.9)

Эх сурвалж: Нийслэлийн Онцгой комиссоос ирүүлсэн судалгаа

2.4 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд үйл ажиллагаанд бусад орлого, хандив, тусламжийг хэрхэн бүрдүүлж зарцуулах талаар зохицуулаагүй байна;

Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үеийн “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд нийт 144.3 сая төгрөгийн хандив, тусламжийн хөрөнгийг зарцуулсан байна. Үүнд:

Хүснэгт 12 Захирамжийн судалгаа (сая төгрөгөөр)

№	Хандив, тусламж нийлүүлэгч	Олгосон		Зарцуулсан		Үлдэгдэл	
		Нэр төрөл	Дүн	Нэр төрөл	Дүн	Нэр төрөл	Дүн
1	Засгийн газрын 2021 оны 40 дүгээр тогтоолоор Улсын хандив, тусламжийн нөөцөөс	4	163.7	4	95.6	2	68.1
2	ОБЕГ-ын хуваарилалтаар	5	7.3	5	7.3	-	-
3	МУЗН /хүнсний багц /	3	41.5	3	41.5	-	-
	Дүн		212.4		144.3	2	68.1

Эх сурвалж: Нийслэлийн Онцгой комиссоос ирүүлсэн судалгаа

МУ-ын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн тогтоолоор байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ирүүлсэн хандив, хүмүүнлэгийн тусламжийн хөрөнгийн эх үүсвэрээс 4 төрлийн 163.8 сая төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгслийг олгохоор шийдвэрлэснийг НОК хүлээн авч Нийслэлийн МХГ, ЦУГ, ОБГ, УБЗАА, дүүргүүдийн ОБГ-т хуваарилалт хийж олгон нийт 68.1 сая төгрөгийн үнэ бүхий 340.0 мянган ширхэг амны хаалт, 10 ширхэг халаадны үлдэгдэлтэй байна.

Мөн ОБЕГ-ын даргын улсын нөөц дэх хандив тусламжийн хөрөнгөөс гамшгаас хамгаалах бэлэн байдлын үед эргүүлийн үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнд олгохоор баталсан барааны хуваарийн дагуу 5 төрлийн 7,250.2 мянган төгрөгийн хүнсний болон нэг удаагийн хэрэглээний зүйлсийг хүлээн авч зарцуулжээ.

МУЗН нь 2021 оны 2 дугаар сарын 11-23-ны өдрүүдэд өөрийн чиг үүргийн дагуу бэлтгэсэн 3 төрлийн нийтдээ 41.5 сая төгрөгийн хүнсний багцуудыг Нийслэлийн 7 дүүргийн хүнс, тэжээлийн дэмжлэгт хамрагдах шаардлагатай зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа 745 иргэн, өрхөд олголт хийжээ.

Нийслэлийн Онцгой комиссоос ирүүлсэн судалгаагаар нийслэлийн хэмжээнд энэ хугацаанд иргэн, ААНБ-аас ямар нэгэн хандив, тусламж өгөөгүй байна.

МУ-ын Засгийн газрын 2020 оны 133 дугаар тогтоолын тавдугаар зүйлийн 5.2-т: “Хүмүүнлэгийн тусламжийн талаарх тайлан, мэдээг улсын хэмжээнд Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллага нэгтгэж, тухайн шатны Онцгой комисст танилцуулна.”; 5.3-т: “Онцгой байдлын байгууллага болон энэ журмын 2.4-т заасан байгууллага нь хүмүүнлэгийн тусламжийн талаарх тайлан, мэдээг тухайн шатны Онцгой комисст ирүүлж, өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэх бөгөөд холбогдох байгууллагын шилэн дансанд байршуулна.” заалтыг УОК, НОК хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.5 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд зориулан 296.0 сая төгрөгийн ПОС машиныг шууд худалдан авсан байна.;

Нийслэлийн эрүүл мэндийн газар “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээнд зориулан Эрүүл мэндийн байгууллага нийт 4 төрлийн 313.1 сая төгрөгийн шууд худалдан авалтыг хийсэн байна.

Хүснэгт 13 Худалдан авалтын судалгаа (сая төгрөгөөр)

№	Барааны нэр	Нэг бүрийн үнэ /төгрөгөөр/	Тоо	Нийт үнэ
1	ЭМЯ Пос машин худалдан авсан	1,500,000.0	80	120.0
2	НЭМГ Пос машин худалдан авсан	880,000.0	200	176.0
3	НЭМГ шинжилгээний арга хэмжээнд зориулан эмнэлгийн хог хаягдал хаях хогийн уут худалдан авсан	300.0	1,600	0.5
		180.0	7,200	1.3
		2,269.0	385	0.9
		2,149.0	149	0.3
4	НЭМГ Пос машины стикер цаас	3,000.0	4,700	14.1
Худалдан авалтын дүн				313.1

Эх сурвалж: Худалдан авалтын гэрээ, холбогдох баримтууд

ЭМС-ын 2021.01.05-ны өдрийн А/05 “Эрх шилжүүлэх” тушаалаар НЭМГ-т N95 маск авахад зориулан 400.0 сая төгрөг, 2021.02.04-ны өдрийн А/35 “Эрх шилжүүлэх” тушаалаар коронавируст халдварыг илрүүлэх шинжилгээний сорьц цуглуулахад зориулж 600.0 сая төгрөгийн эрх шилжүүлсэн боловч санхүүжилтийг олгоогүй ЭМС-ын 2021.02.08-ны өдрийн А/45 тушаал гарч, Нийслэлийн эрүүл мэндийн газарт шилжүүлсэн А/05, А/35 тушаалыг хүчингүй болгож, энэхүү 600.0 сая төгрөгийн худалдан авалтын эрхийг ХӨСҮТ-д шилжүүлсэн байна.

2.6 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг Улсын нөөц, хандив, тусламжийн хөрөнгө, байгууллагын нөөцийн үлдэгдлээс зарцуулсан байна;

НОК “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд Улсын нөөцийн 3 салбараас 10 нэр төрлийн 1,256.4 ширхэг, 2,589.1 сая төгрөгийн үнэ бүхий ариутгалын бодис, хамгаалах хэрэгслийг хүлээн авсан байна.

НЭМГ-ын даргын 2021.02.09-ны өдрийн А/15 тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн УОК-ын нийлүүлсэн нөөц хөрөнгөөс Улсын хоёр дугаар төв эмнэлэгт 4 нэр төрлийн 121,710 ширхэг 1,313.4 сая төгрөгийн,

Дүүргүүдийн Онцгой комисст 2 нэр төрлийн 109.7 сая төгрөгийн, бусад мэргэжлийн байгууллагуудад 9 нэр төрлийн 671,714 ширхэг 561.2 сая төгрөгийн хамгаалах хэрэгслийг хуваарийн дагуу олгож ажилласан байна.

Эрүүл мэндийн яам “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд нийт 16,969.4 сая төгрөгийн нөөцийг 8 эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

Хүснэгт 14 Нөөц бүрдүүлэлтийн судалгаа (сая төгрөгөөр)

№	Байгууллага	Шинжилгээний хэрэгсэл	Хамгаалах хувцас хэрэгсэл	Ариутгал халдваргүйтгэл	Бусад зардал	Нийт дүн
1	НОК	-	1,280.0	9.5	-	1,289.5
2	ЭМЯ	973.8	10,398.0	125.6	-	11,497.4
3	НЭМГ	181.3	-	1.9	-	183.2
4	ДЭМБ	160.0	-	-	-	160.0
5	ЗӨСҮТ	146.8	34.1	1.1	-	182.0
6	НЭМҮТ	1.9	0.2	0.8	-	2.9
7	ХӨСҮТ	3,606.5	33.4	3.3	-	3,643.1
8	ДОК	-	-	-	11.3	11.3
Бүгд		5,070.3	11,745.6	142.1	11.3	16,969.4

Эх сурвалж: ЭМЯ-аас ирүүлсэн дэлгэрэнгүй судалгаа

Арга хэмжээнд зориулсан шинжилгээ, оношилгооны бодис, багаж хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, ариутгалын нөөцөөс шинжилгээний лабораторид 7,762.0 сая төгрөгийн, Түр цэгүүдэд 1,322.0 сая төгрөгийн, 2,291.8 сая төгрөгийн нийт 11,375.7 сая төгрөгийн нөөц хөрөнгийг зарцуулсан байна.

Хүснэгт 15 Нөөц хөрөнгийн зарцуулалтын судалгаа (сая төгрөгөөр)

№	Байгууллага	Лаборатори	Түр цэг	Явуулын тандалтын цэг	Дүн
1	ХӨСҮТ	3,652.7	-	-	3,652.7
2	УНТЭ	908.7	-	-	908.7
3	УХТЭ	954.4	-	-	954.4
4	ЗӨСҮТ	796.8	-	-	796.8
5	НЭМҮТ	634.2	-	-	634.2
6	БГДЭМТ	199.6	291.2	520.9	1,011.7
7	БЗДЭМТ	38.5	282.5	407.3	728.3
8	СБДЭМТ	123.7	20.3	332.1	476.1
9	СХДЭМТ	198.7	306.3	397.0	902.0
10	ХУДЭМТ	129.2	152.7	261.1	543.0
11	ЧДЭМТ	125.4	146.1	246.8	518.4
12	БНДЭМТ	-	35.2	88.8	124.1
13	НАДЭМТ	-	74.5	22.6	97.1
14	БХДЭМТ	-	13.0	15.1	28.1
Нийт дүн		7,762.0	1,322.0	2,291.8	11,375.7

Эх сурвалж: ЭМЯ-наас ирүүлсэн дэлгэрэнгүй судалгаа

2.7 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд нийгмийн халамж үйлчилгээ шаардлагатай айл өрхүүдэд тусламж үзүүлэх ажиллагаа үндэслэлтэй төлөвлөгдөөгүй, урсгалаараа явагдсан байна;

Нийгмийн халамжийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “нийгмийн халамжийн үйлчилгээ нь дараах төрөлтэй байна” гэж заасан байна. Үүнд:

- 17.1.1. олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ;
- 17.1.2. төрөлжсөн асрамжийн үйлчилгээ.

Улмаар олон нийтийн оролцоонд түшиглэсэн үйлчилгээний төрлийг 10, төрөлжсөн асрамжийн үйлчилгээний төрлийг 4 чиглэлтэй байхаар тус тус баталсан байна.

Энэ үйлчилгээний төрлүүдээс аль үйлчилгээг хэрхэн яаж хүргэх тухай МУ-ын Шадар сайд, УОК-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн "Нэг хаалга-Нэг шинжилгээ" арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө"-нд тодорхой тусгаагүй байна.

Харин НЗД бөгөөд Онцгой Комиссын даргын 2021 оны 2 дугаар сарын 9-ны өдөр баталсан "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед 100.000 иргэнийг шинжилгээнд хамруулах арга хэмжээний төлөвлөгөө"-нд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

1. Гуравдугаар бүлгийн (Хязгаарлалтын дэглэм тогтоох, хамгаалалт авах арга хэмжээ) 16-д "Эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх /жирэмсний хяналтад байгаа эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, сүрьеэ, хорт хавдар, мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгасан, дархлаа дарангуйлах, эм хэрэглэдэг болон гемодиализ/ эмнэлгийн тусламж, үйлчилгээнд хамрагдах иргэдийг холбогдох баримт бичгийг үндэслэн зорчих бүсэд саадгүй нэвтрүүлэх" гэж тусган, хүрэх үр дүнг Эрсдэлт бүлгийн хүн ам эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тасралтгүй хамрагдахаар,
2. Тавдугаар бүлгийн (Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар) 20-д Эрсдэлт бүлгийн хүн амд үзүүлэх /5хүртэлх насны хүүхэд, 65 наснаас дээш өндөр настан, жирэмсний хяналтад байгаа эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, сүрьеэ, хорт хавдар, мэс засал, эрхтэн шилжүүлэн суулгасан, дархлаа дарангуйлах эм хэрэглэдэг болон гемодиализ/ эмнэлгийн тусламж, үйлчилгээг тасалдуулахгүй зохион байгуулахаар,
3. Есдүгээр бүлгийн (Нөөц хангалтын талаар) 41-д Халамжийн үйлчилгээг авах иргэдийн судалгаа, зардлын тооцоог дүүрэг тус бүрээр гаргах гээд хүрэх үр дүнг Зорилтот бүлгийн иргэнд тусламж үзүүлнэ,
4. Аравдугаар бүлгийн (Халамжийн үйлчилгээ үзүүлэх талаар) 45-д Нийслэлийн хэмжээнд зорилтот бүлгийн шаардлагатай айл өрхөд хүнсний багц олгох ажлыг зохион байгуулах, 46-д Шахмал түлшний хангалт, түгээх үйл ажиллагааг зохион байгуулах Хязгаарлалтын дэглэмийн үед зорилтот бүлгийн шаардлагатай иргэд хүнсний багцаар хангагдана, Түлшний хомсдол үүсэхээс урьдчилан сэргийлж, тасралтгүй түгээх нөхцөлийг бүрдүүлнэ. гэж тус тус төлөвлөсөн байна.

НОК-ын Санхүүгийн алба Нийслэлийн статистикийн газраас Ковидын үед орлого тасарсан өрхийн тоог дүүрэг тус бүрээр, Нийслэлийн Халамжийн газраас зорилтот бүлгийн өрхийн тоог, Эрүүл мэндийн яамнаас гаргасан Нэг өрхийн өдөрт хэрэглэх хүнсний жишиг үнийг ашиглан хүнсний хэрэглээний тооцооллыг хийсэн байна.

Дээрх тооцоололд дунджаар нэг өрхийн 4 ам бүлийн өдрийн хэрэглээний дунджаар 14 хоногоор бодож нийт 29715 өрхөд 3.6 тэрбум төгрөгийн санхүүжилтийн тооцоолол гаргасан байна. Гэвч уг төлөвлөгөө тооцооллын дагуу хэрэгжилт хэрхэн хийгдэж буй нь тодорхой бус байна.

Эмзэг бүлгийн өрхийн судалгаанд халамжийн үйлчилгээ авдаг болон өдрийн орлогоор амьдардаг өрхийг тусад нь ангилж судалгааг гаргаагүй.

НОК-ын Санхүүгийн алба Орлого тасарсан иргэдэд хүнсний хангамж өгөх төсвийг 2,216.9 сая төгрөгөөр төсөвлөсөн боловч өнөөдрийн байдлаар НОК-оос санхүүжилт олгоогүй байна. Дүүргүүд өөрсдийн нөөц бололцоогоор 5997 багц хүнс, 22 тн түлш бүхий 295.2 сая төгрөгийн нөөц бэлтгэн шаардлагатай иргэдээс ирүүлсэн хүсэлтийг нягтлан тухай бүр шийдвэрлэж ажилласан байна.

Нийслэлийн Халамжийн газраас 2021 оны 01 дүгээр сарын 20-ны байдлаар Хүнс, тэжээлийн дэмжлэгт хамрагдах шаардлагатай зорилтот бүлэг, эрсдэлт нөхцөлд байгаа иргэн, өрхийн судалгааг гаргаж 21188 өрхөд тусламж шаардлагатай гэж НОК-ын хангалтын багт хүргүүлсэн байна.

Арга хэмжээний хүрээнд 201 өрхөд 9.3 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 0.9 хувьд нь тусламж хүргэгдсэн байна.

Энэ нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар 32.1 дэх “.. нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гамшгаас хамгаалах асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 32.1.5.-д “хууль тогтоомж, дээд шатны байгууллага, албан тушаалтны шийдвэрийн дагуу хүмүүнлэгийн тусламжийг нутаг дэвсгэрийн хэмжээнд хуваарилах ажлыг зохион байгуулах, тайлагнах” гэсэн заалт бүрэн хэрэгжүүлээгүй ирүүлсэн хүсэлтийн хүрээнд явагджээ.

Аудитын ажлын хэсгийн гишүүд хүнсний хомсдолд орсон гэж хүсэлт гаргасан, хүнсний хангалт хүргэгдсэн өрхийг түүвэрчлэн газар дээр нь танилцахад 1 өрхийн ам бүлд хамтран амьдарч байгаа ач хүү нь төрийн албан хаагч болох зөрчил илэрсэн. Энэ нь ирүүлсэн хүсэлтийг нягтлах ажил хангалтгүй хийгдэж байгааг харуулж байна.

Харин энэ талаар холбогдох албан тушаалтнуудтай ярилцаж тодруулга авахад Халамжийн чиглэлийн үйл ажиллагааг нийтэд зарлахаар нийт ард иргэдэд буруу зөрүү ойлголт өгөөд хий дэмий хүлээлт, дараалал үүсгэх зэргээр хүндрэлтэй асуудал үүсдэг. Тийм болохоор бид НОК, ДОК дээр шуурхай санал хүсэлтийг хүлээн авч хяналт хийсний үндсэн дээр хоол хүнс түлшээр хангах ажиллагааг явуулж байгаа гэж хариу өгөв.

2.8 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний шийдвэр, хөрөнгө санхүүжилтийн мэдээлэл, олон нийтэд ил тод байдлыг бүрэн хангаагүй байна;

Хөрөнгө санхүүжилтийн ил тод байдлыг хангаж ажилласан эсэх зорилтын хүрээнд НОК-ын холбогдох албадтай ярилцлага хийж бодит байдалтай танилцахад авч хэрэгжүүлж буй арга хэмжээтэй холбоотой шийдвэрүүд шат шатандаа гараагүй, хэрэгжиж эхэлж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг дараа сарын 8-ны дотор ил тод байдлаар мэдээлэхээр төлөвлөж байгаа тухай танилцуулав.

Үйл ажиллагааны явцын мэдээллийг хяналтын өрөөнд нэгтгэгдэж дэлгэцээр ажиглаж байна.

МУ-ын Шадар сайд, УОК-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан "Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн "Нэг хаалга-Нэг шинжилгээ" арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө"-нд Хариуцах байгууллагын жагсаалтад орсон ЭМЯ, ЭТБХЗГ, ЭМСЭЗБХГ, НОК, ДОК, НЭМГ, ДЭМТ, НТТТ, ХӨСҮТ, УБЗАА, ХХМТГ, НМТГ, гэх мэт байгууллагуудын Шилэн дансны мэдээллийг тулгахад арга хэмжээний талаар орсон мэдээлэлгүй байсан бөгөөд аудитын явцад өгсөн зөвлөмжийн дагуу НЭМГ зарим мэдээллүүдийг оруулж эхэлсэн байна.

<https://shilendans.gov.mn/org/698?form=4631840&year=2021&month=1&group=0&task=2814>

НЭМГ-т “Нэг хаалга-Нэг шинжилгээ” үйл ажиллагаатай холбоотой 600.0 сая төгрөгийн эрх шилжин ирж худалдан авах ажиллагаатай холбоотой ТШ НЭМГ/202102004 дугаартай худалдан авах ажиллагааг зарласан байх бөгөөд олон нийтийн Эрүүл мэндийн яамнаас хөрөнгийг буцаан татахтай холбоотой уг худалдан авалтыг цуцалсан байна. Гэтэл уг үйл ажиллагаатай холбоотой нэг ч

мэдээллийг шилэн дансны холбогдох хэсэгт оруулаагүй байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.8. дугаар зүйлд “Энэ хуулийн 3.1.3-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: 6.8.2.худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчдод тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;”, 6.10.Шилэн дансны мэдээлэл, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хуулбар, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргасан байна.” зэрэг заалтуудын дагуу ажиллаагүй байна.

НЭМГ-аас Шилэн дансны мэдээлэлд оруулсан худалдан авалтын төлөвлөлтийн үеийн мэдээлэлд “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдлийг хавсаргаагүй байна.

МУ-ын Шадар сайд, УОК-ын даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө”-нд уг үйл ажиллагаанд шаардагдах санхүү, хөрөнгө, нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлт үр ашигтай удирдах, ил тод мэдээлэх талаар тодорхой тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-д “төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах” гэсэн заалтай нийцэхгүй байна.

БҮЛЭГ 3. ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА ОНОШИЛГОО, ШИНЖИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР ДҮНТЭЙ ОНОВЧТОЙ ХЭРЭГЖИЖ БАЙГАА ЭСЭХ

3.1 “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөөтэй нийслэл, дүүргийн онцгой комиссын төлөвлөгөөг уялдуулан төлөвлөөгүй байна;

Улсын онцгой комиссын 2021 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 04 дүгээр хурлаар “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г Эрүүл мэндийн яам, Шуурхай штаб, Нийслэлийн онцгой комисс хамтран боловсруулж батлуулах үүргийг ЗГХЭГ-ын Тэргүүн дэд дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Нийслэлийн онцгой комиссын дарга нарт үүрэг өгсөн боловч “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг хэрэгжүүлэх дараах 3 төлөвлөгөөг тус тусдаа боловсруулж, батлуулсан байна.

- Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө
- “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд хангалт, зохион байгуулалт хариуцсан ажлын хэсгээс хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө
- Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед нийслэл хотын нутаг дэвсгэрт хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах нэгдсэн төлөвлөгөө

Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2020 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах дээрх 3 төлөвлөгөөнд хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцах байгууллагыг давхардуулсан, судалгаа, тооцооллыг гаргаж хүргүүлэх, нэгтгэх, хянаж хүлээн авах албан тушаалтныг тодорхой тусгаагүй байна.

Мөн дээрх 3 төлөвлөгөө батлагдахаас өмнө Нийслэлийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга Д.Сумъяабазар 2021 оны 2 дугаар сарын 8, 9-ны өдөр 2 төлөвлөгөөг тус тус баталсан нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.1-д “гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хяналт тавих” гэсэн заалтад нийцээгүй байна.

Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө”-нд нийслэлийн төвийн зургаан дүүргийн 100000 иргэнийг шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөн нь Нийслэлийн Засаг даргын дараах захирамж, төлөвлөгөөтэй уялдахгүй байна. Тухайлбал:

- “Ажлын хэсэг байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/85 дугаар захирамжаар “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулахыг дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосон.
- Нийслэлийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 09-ны өдөр баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед 100000 иргэнийг шинжилгээнд хамруулах арга хэмжээний төлөвлөгөө”-нд 2021 оны 2 дугаар сарын 11-13-ны өдөр нийслэлийн 9 дүүрэгт хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Улсын онцгой комиссын даргын 2021 оны 2 дугаар сарын 06-ны өдрийн 12 дугаар тушаалаар “Нэг хаалга-Нэг шинжилгээ”

арга хэмжээг 2021 оны 2 дугаар сарын 11-23-ны өдрүүдэд төлөвлөгөөний дагуу өндөр түвшинд зохион байгуулж, дүнг танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, цагдаагийн хурандаа Ж.Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт үүрэг болгосон боловч Нийслэлийн болон төвийн 6 дүүргийн Засаг дарга нар тус арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг, төлөвлөгөө, хуваарийг батлахдаа хэрэгжүүлэх хугацааг харилцан адилгүй тусгасан байна.

3.2 Шинжилгээнд хамруулах зорилтот бүлгийг оновчтой тодорхойлсон байна;

Улаанбаатар хотод 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулснаас хойш коронавируст халдварын шинээр бүртгэгдэх тохиолдлын тоо нэмэгдсэн¹², эх үүсвэр тодорхойгүй тохиолдлын тоо өссөн, голомтын хүрээ нэмэгдэн идэвхжил өндөр 89 цэг бий болсон тул Улсын онцгой комиссын 2021 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 3 дугаар хуралдаанаар цаг үеийн нөхцөл байдлын талаар хэлэлцэж, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлд¹³ заасны дагуу нийслэлийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн үед дараах зорилгоор “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

- Нийслэлийн хүн амын дунд коронавируст халдварын тохиолдлыг эрт үед нь илрүүлэх, тусгаарлах, хариу арга хэмжээг цаг алдалгүй зохион байгуулах;
- Эрүүл мэндийн байгууллагад гарах хүндрэл¹⁴, эндэгдлийг бууруулах;
- Хүн амын дунд тархалт гарахаас урьдчилан сэргийлэх.

Улсын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу шинжилгээнд хамруулах зорилтот бүлгийг тодорхойлохдоо дараах байгууллагуудын санал зөрүүтэй байсан тул хуралдаанаар хэлэлцэн бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн 2021 оны 2 дугаар сарын 11-нээс 13-ны өдрүүдэд голомтлон гарсан цэгүүдийг блоклон бүх өрхийг хамруулах, голомт гараагүй хэсгүүдэд түүвэрлэн шинжилгээ хийх бэлтгэл ажлын хүрээнд төрийн албан хаагчдыг шинжилгээнд хамруулах шийдвэр гаргаж, нийслэлийн төвийн 6 дүүргийн 100000 өрхийг шинжилгээнд хамруулах төлөвлөгөөг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын дарга баталсан байна.

- Нийслэлийн онцгой комисс нийслэл, дүүргийн хүн амын орон сууцны 2020 оны ээлжит тооллогын тоонд үндэслэн нийт өрхөөс шинжилгээ авахаар төлөвлөн дүүрэг, хороодод хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө гаргах чиглэл өгсөн;
- Эрүүл мэндийн байгууллага нь халдвар илэрсэн цэгүүдэд голомтыг хөөж өргөтгөн шинжилгээ авахаар төлөвлөсөн.

Нийслэлийн эрүүл мэндийн газар шинжилгээ авах үйл ажиллагааг мэргэжил арга зүйн зөвлөмжөөр ханган шаардлагатай зохицуулалт хийх чиг үүргийн хүрээнд халдвар илрээгүй нийслэлийн алслагдсан дүүргийг хамруулахгүй, төвийн 6 дүүргийн голомтын идэвхжил өндөр хэсгийн өрхийг бүрэн хамруулах, голомт илрээгүй хэсгээс түүвэрлэх чиглэлийг баримтлан дүүргүүдэд квот тогтоон 100.0 мянган өрхийг хамруулахаар тооцоолж, шинжилгээнд хамруулах зорилтот бүлгийг оновчтой төлөвлөжээ.

¹²2021 оны 2 дугаар сарын 5-ны өдөр нэг өдөрт бүртгэгдсэн шинэ тохиолдлын тоо хамгийн өндөрт (61) хүрсэн

¹³ 10 дугаар зүйл Гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангах

¹⁴ Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт коронавируст халдвар (КОВИД-19)-ын 7.6 хувь буюу 152 нь эрүүл мэндийн ажилтнууд

Гэвч төлөвлөгөө боловсруулах явцад дараах зөрчилтэй асуудлууд гарсан байна. Тухайлбал, Нийслэлийн онцгой комиссоос нийслэлийн нийт өрхөөс шинжилгээ авах чиглэл өгсний дараа төрийн албан хаагчдыг шинжилгээнд хамруулсан, Эрүүл мэндийн яамнаас 72 цагийн дотор шинжилгээнд хамрагдаагүй иргэнийг хамруулах чиглэл өгсөн нь төрийн захиргааны байгууллага хоорондын мэдээлэл солилцох ажлын уялдаа холбоо хангалтгүйгээс төлөвлөсөн ажил доод шатандаа бүрэн хэрэгжихгүй байх, хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох боломжгүй болох нөхцөлийг үүсгэсэн байна.

Энэ нь Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.3.7-д “салбар дундын төлөвлөгөө, мэдээ, мэдээлэл солилцох, хамтран ажиллах” гэж заасантай нийцэхгүй байна.

3.3 Шинжилгээ авах байнгын цэг, явуулын баг төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулсан боловч цэгүүдийн ажлын ачааллыг жигд зохион байгуулаагүй байна;

Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө”-нд төвийн 6 дүүргийн 100000 өрхөөс 73 байнгын цэг, 137 явуулын баг, нийт 210 цэгт шинжилгээг авахаар төлөвлөсөн боловч Нийслэлийн Засаг дарга бөгөөд онцгой комиссын дарга 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр Улаанбаатар хотын 9 дүүргийн 119000 өрхийг шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөн байна.

Хүснэгт 16 Шинжилгээнд хамруулах өрхийн тоо, шинжилгээ авах цэгийн судалгаа

Д/д	Дүүрэг	Хамруулах өрхийн тоо		Ажиллах багийн тоо			
				Байнгын цэг		Явуулын баг	
		УОК	НОК	УОК	НОК	УОК	НОК
1	Баянгол	23000	20000	19	2	27	25
2	Сүхбаатар	11000	12000	0	0	30	30
3	Чингэлтэй	10000	10000	8	6	12	10
4	Сонгинохайрхан	25000	28000	21	43	30	10
5	Хан-Уул	11000	10000	9	2	13	20
6	Баянзүрх	20000	20000	16	6	25	24
7	Багануур	0	8000		2		12
8	Налайх	0	10000		10		6
9	Багахангай	0	1000		2		0
Нийт		100000	119000	73	73	137	137

Эх сурвалж: Аудитын багийн судалгаа

Хүснэгтээс харахад Улсын онцгой комиссын баталсан төлөвлөгөөгөөр 2021 оны 2 дугаар сарын 11-нээс 13-ны өдөр нийслэлийн төвийн 6 дүүргийн 100000 өрхийг шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөн боловч Нийслэлийн онцгой комисс нийслэлийн 9 дүүргийг хамруулахаар төлөвлөж, шинжилгээнд хамруулах өрхийн тоог Чингэлтэй, Баянзүрх дүүргээс бусад дүүрэгт зөрүүтэй төлөвлөсөн байна.

Мөн шинжилгээ авах байнгын 73 цэг, явуулын 137 баг ажиллуулахаар адилхан төлөвлөсөн боловч Улсын онцгой комисс нийслэлийн төвийн 6 дүүргээр, Нийслэлийн онцгой комисс 9 дүүргээр төлөвлөсөн нь нэгдсэн нэг заавар, төлөвлөгөөний дагуу төлөвлөөгүйтэй холбоотой байна.

“Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд 2021 оны 2 дугаар сарын 11-22-ны өдрийг дуусталх хугацаанд давхардсан тоогоор 9 дүүргийн нийт

490396 иргэнээс шинжилгээ авах ажлыг дараах баг, бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулжээ.

Хүснэгт 17 Шинжилгээ авсан цэг, ажилласан хүний судалгаа

№	Дүүрэг	Нэгтгэл					
		Байнгын цэгийн тоо	Явуулын багийн тоо	Нийт цэг, багийн тоо	Ажилласан хүний тоо		
					Байнгын цэг	Явуулын баг	Нийт
1	Баянгол	32	225	257	330	2137	2467
2	Баянзүрх	67	469	536	274	1407	1681
3	Сонгинохайрхан	122	97	219	650	485	1135
4	Сүхбаатар	21	182	203	203	1154	1357
5	Хан-уул	43	224	267	386	1333	1719
6	Чингэлтэй	46	190	236	436	748	1184
7	Налайх	30	14	44	152	45	197
8	Багануур	0	34	34	0	860	860
9	Багахангай	7	2	9	16	13	17
Нийт дүн		368	1437	1805	2447	8182	10617

Эх сурвалж: Аудитын багийн судалгаа

Аудитын явцад шинжилгээ авах байнгын цэг, явуулын багийн үйл ажиллагаатай танилцах явцад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Лабораторид цэргийн ангийн алба хаагчдаас авсан, орон нутгаас ирсэн гэх мэт олон шалтгаанаар бар кодгүй, пос төхөөрөмжид уншигдаагүй шинжилгээний сорьц хүлээн авсан нь нэгдсэн цахим тоо мэдээлэлд бүртгэгдсэн эсэх нь тодорхойгүй;
- Шинжилгээнд 2021 оны 2 дугаар сарын 14-нөөс 22-ны хооронд 9 дүүргийн шинжилгээнд хамрагдаагүй нийт өрхийг хамруулах ажлыг эхлүүлэн 14,15-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн иргэдийг шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах явцад урьдчилж төлөвлөгөө, хуваарь гаргаж ачааллыг тэнцвэржүүлээгүй, иргэдэд мэдээллийг үнэн зөв хүргээгүйгээс шинжилгээний цэгүүдэд ачаалал үүсэж иргэд олон цагаар дугаарлаж зогсох, шинжилгээ өгөх шаардлагагүй иргэд мэдээлэл дутмагаас очиж ачаалал үүсгэх асуудал түгээмэл байсан.
- Шинжилгээ авах цэг, баг нь шинжилгээ авахдаа нарийн судалгаагаар хангагдаагүй, хороо болон өрхийн эрүүл мэндийн төвүүд нэг аргачлал, нэг зохион байгуулалтаар ажиллаагүй, иргэдэд мэдээлэл хүргэх ажиллагаа харилцан адилгүйгээс иргэд шинжилгээгээ хаана өгөхөө мэдэхгүй байдал үүссэн. Жишээлбэл: Тухайн өрхийн төрийн албан хаагч шинжилгээнд хамрагдсан эсэх талаарх мэдээлэл байхгүйгээс тухайн айлгаар орж цаг алдах, шинжилгээ өгсөн гэсэн тайлбар хэлэхэд тэр хамаагүй шинжилгээгээ дахин өг гэх зэрэг үйлдэл их гарсан.
- Дүүргүүдийн онцгой комисс төлөвлөгөөг загварчилсан нэг маягтаар гаргаагүй, өөр өөрөөр гаргасан. Тухайлбал: Зарим дүүргүүд 11-13-ны өдрүүдэд шинжилгээнд хамрагдах хороо, блок-ыг нарийн төлөвлөсөн байхад зарим нь төлөвлөөгүй.
- Нийслэлийн онцгой комисс мэдээлэл цуглуулах нэгдсэн маягт батлаагүй.
- Лабораторийн хүчин чадалд тохируулан 11-13-ны өдрүүдэд шинжилгээ авахаар төлөвлөсөн ч хэрэгжүүлэхдээ хүчин чадлаас хэт давсан шинжилгээг авсан.
- Лабораториудын үйл ажиллагаатай танилцахад шинжилгээний сорьц хүлээн авсан, хүлээлгэн өгсөн бүртгэлийг албан ёсны нэгдсэн нэг маягтын дагуу хөтлөөгүй, гарын үсэг зурж баталгаажуулдаггүй.
- 2021 оны 2 дугаар сарын 18-ны өдөр хавсралт маягтын дагуу 2 дугаар сарын 8-наас 13-ны хооронд шинжилгээнд хамрагдсан иргэдийн мэдээллийг гаргаж ирүүлэхийг “Мэдээлэл авах тухай” УАГ-ын 2021 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн 01/449 дүгээр албан бичгээр Нийслэлийн эрүүл мэндийн газар, Гэрээг системс ХХК-д хүргүүлсэн боловч 2021 оны 02 дугаар сарын 21-ны өдөр өөр маягтаар ирүүлсэн.
- Баянзүрх дүүргийн 84 дүгээр сургууль дээр ажиллаж байгаа байнгын цэгт 2021 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 14.00 цагт очиход ариутгал хийгдэж байгаа гэсэн шалтгаанаар гадаа 90 орчим иргэний дараалал үүссэн, ажилчид нь ариутгалын материал /саван, угаалгын нунтаг, гар ариутгагч/-ыг хувиасаа авсан, ажилтнуудын хоол цагтаа ирээгүйн улмаас хоол идэлгүй ээлж солилцон ажилласан, хоол идэхдээ нэг удаагийн өмсгөлөө тайлдаг тул өмсгөлийн нөөц хүрэлцээгүйн улмаас хоолоо идэж чадахгүйд хүрдэг зэрэг хүндрэлүүд гарсан.

- Шинжилгээний зарим цэгийн сорьц авах эмчийн тоо цөөн, өглөө цагтаа үйл ажиллагаа эхлэхгүй байх, сорьц багцлах, ариутгал хийгдэх, пос машин гацах шалтгааны улмаас иргэд урт дараалал үүсгэж бухимдах байдал түгээмэл гарсан.
- Шинжилгээний цэгт ажиллаж буй эмч, ажилтнуудын ирж, очих унааны асуудлыг шийдвэрлээгүй, цэгүүдийн ажиллах цаг өдрөөр, 24, 48 цагаар буюу харилцан адилгүй байх, явуулын багийн автобус хүйтэн, угаар ихтэй байх зэрэг хүндрэлүүд гарсан байна.

Шинжилгээнд бүрэн хамрагдах, өрх бүрээс нэг иргэн хамруулах талаарх мэдээллийг иргэдэд хангалттай хүргээгүй байна;

Улсын онцгой комиссын даргын баталсан төлөвлөгөөнд шинжилгээнд бүрэн хамрагдах, өрх бүрээс нэг иргэн хамруулах талаарх мэдээллийг иргэдэд хүргэх арга хэмжээг зөв зохион байгуулсан эсэхийг шалгаж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 18 "Нэг хаалга - нэг шинжилгээ" арга хэмжээний хангалтгүй хэрэгжсэн заалтын судалгаа

Төлөвлөгөө	Заалт	Хэрэгжилт
УОК-ын баталсан Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед нийслэл хотын нутаг дэвсгэрт хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах нэгдсэн төлөвлөгөө	1.10-т Хэвлэл мэдээллийн байгууллагууд багийн зохион байгуулалтад орж, Улсын онцгой комиссын шийдвэрээр иргэд, олон нийтийг үнэн зөв мэдээ, мэдээллээр хангаж ажиллах	Үнэн зөв мэдээллээр хангах бэлтгэл ажил хугацаандаа хийгдээгүй
УОК-ын баталсан Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө	2.3. 9-т Мэдээлэл сурталчилгаа хийх • Өрх бүрээс нэг иргэн зайлшгүй хамрагдах шаардлага, • Шинжилгээнд хэн хамрагдах, • Хэрхэн хамрагдах, • Шинжилгээ өгөхийн өмнө анхаарах асуудал	Зөрүүтэй мэдээллийн улмаас иргэд давтан, нэг өрхөөс 2-оос дээш хүн шинжилгээ өгсөн тохиолдлууд гарсан.
УОК-ын баталсан Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд хангалт, зохион байгуулалт хариуцсан ажлын хэсгээс хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө	1.1-т Нийслэлийн Засаг даргын захирамжаар “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг нийслэлд зохион байгуулах дэд ажлын хэсэг байгуулах 2.1.10-т УОК, НОК, ЭМЯ-аас гаргасан заавар зөвлөгөө, уриалга, бүхий багц мессеж үйлчилгээг үүрэн холбооны оператор компаниар дамжуулан иргэдэд хүргэх	Иргэдэд мэдээлэл хүргэх үйл ажиллагааны чиглэл тодорхойгүй Иргэд мэдээллээр хангагдаж оролцоо нэмэгдэнэ хэрэгжээгүй
НОК-ын баталсан Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед 100.000 иргэнийг шинжилгээнд хамруулах арга хэмжээний төлөвлөгөө	35-т Албан ёсны мэдээний 12 сайт, өдөр тутмын 3 сонин, телевизийн 20 сувгаар НОК-оос гаргасан шийдвэр, шинжилгээний явцын мэдээллүүдийг олон нийтэд түгээх	Иргэд үнэн зөв мэдээллээр хангалттай хангагдаагүй

“Эрсдэлийн мэдээлэл, харилцааны хороо”, Соёлын яамны “Эрсдэлийн үеийн мэдээлэл харилцааг зохицуулах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсэг”, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын “Хэвлэл мэдээлэлтэй харилцах хэлтэс” зэрэг байгууллагууд төлөвлөгөөний дагуу шинжилгээний талаарх мэдээллийг 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн иргэдэд хүргэх үүргийг хүлээсэн боловч гамшиг, цар тахлын үеийн эрт зарлан мэдээлэх болон иргэдийг бодит мэдээллээр хангах төлөвлөгөөгүй, ажил

хариуцсан байгууллагууд уялдаа холбоогүй ажилласнаас шалтгаалан иргэдэд үнэн зөв мэдээ, мэдээллийг цаг тухайд нь хүргэх ажлыг хангалттай зохион байгуулаагүй байна.

Эрсдэлийн мэдээлэл харилцааны түр хороо “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээ эхэлснээс хойш 6 өдрийн дараа буюу 2021 оны 2 дугаар сарын 16-ны өдөр анхдугаар хурлыг зохион байгуулж, иргэдэд мэдээ, мэдээллийг хэрхэн өгөх чиглэлийг төрийн болон төрийн бус байгууллагуудад өгсөн нь иргэдэд хүргэх мэдээлэл цаг хугацаа алдах, шинжилгээнд хамрагдах мэдээллээ бүрэн авч чадахгүй байх, шинжилгээ авч байгаа цэгт бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед бөөгнөрөл үүсгэх эрсдэлд оруулсан байна.

Аудитын явцад дээр дурдсан байгууллагуудаас ирүүлсэн тайлан, мэдээллүүд шаардлага хангахгүй, ирүүлсэн тайлангаас тодруулга хийхэд дургүйцэх, бие бие рүүгээ шилжүүлэх зэрэг хүндрэлтэй байдлыг бий болгосон.

“Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээг нийслэлд зохион байгуулах дэд ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн А/85 захирамжаар байгуулж, хариуцсан албан тушаалтан, зохион байгуулалтын төрөл, чиглэлийг тодорхой болгосон боловч иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах болон эрсдэлийн үеийн мэдээллийг эрт зарлан мэдээлэх төлөвлөгөө байхгүй, ажил хариуцсан ажилтнуудын ажлын зохион байгуулалт хангалтгүй, аудитад ирүүлсэн ажлын тайлан шаардлага хангахгүй, нэмэлт тодруулга өгөх албан тушаалтан тодорхойгүй байсан.

Аудитын явцад “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний мэдээллийг хэрхэн авсан, хангалттай мэдээллээр хангагдсан эсэхийг тандах зорилгоор иргэдээс санал асуулга авахад нийт 9009 иргэд хамрагдсан байна.

Санал асуулгын дүнгээс харахад “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний талаарх мэдээллийг хангалттай авсан уу гэсэн асуултад нийт оролцогчдын 74 хувь буюу 6783 иргэн хангалттай гэж хариулсан бол шинжилгээгээ хаана, хэрхэн өгөхөө огт мэдэхгүй байна гэж судалгаанд оролцогчдын 25 хувь буюу 2273 иргэн хариулжээ.

Санал асуулгад оролцогчдоос шинээр ашиглалтад орсон хотхон, зусланд байгаа өрхүүд, бага насны хүүхдүүдтэй гэрээс гарах боломжгүй эцэг эхүүд, өвчтэй болон өндөр настай хүмүүс хэрхэн шинжилгээнд хамрагдах талаар асуултууд нэмэлт мэдээлэлд зонхилж байсан.

3.4 Шинжилгээ авах үйл ажиллагаанд түр оршин суугч болон бүртгэлгүй өрхийг хамруулсан боловч нэгдсэн тоо мэдээ гаргаагүй, 355 орон гэргүй, тэнэмэл иргэнийг хамруулсан байна;

Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө болон Нийслэлийн онцгой комиссын даргын баталсан 2 төлөвлөгөөнд түр оршин суугч болон бүртгэлгүй өрх, орон гэргүй, тэнэмэл иргэдийг шинжилгээнд хэрхэн хамруулах талаар ямар нэгэн арга хэмжээг төлөвлөөгүй байна.

Нийслэлийн нийгмийн халамжийн газар, Нийслэлийн цагдаагийн удирдах газар, Нийслэлийн нийгмийн хамгааллын тусгай төв, дүүргүүдийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс хамтран орон гэргүй, тэнэмэл амьдралтай, архины хамааралтай иргэдийн бүртгэл судалгааг 2020 оны 12 дугаар сарын байдлаар гарган нийт 850 иргэнийг олж тогтоон мэдээллийн сан үүсгэсэн байна.

Хүснэгт 19 Орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдардаг иргэдийн судалгаа

№	Аймаг/ дүүрэг	Тоо	Хувь
1	Багануур	27	3.18
2	Багахангай	1	0.12
3	Баянгол	91	10.71
4	Баянзүрх	76	8.94
5	Налайх	11	1.29
6	Сонгинохайрхан	354	41.65
7	Сүхбаатар	58	6.82
8	Хан-Уул	21	2.47
9	Чингэлтэй	65	7.65
10	Дүүрэг тодорхойгүй	22	2.59
Улаанбаатар хотын дүн		726	85.41
11	Орон нутгийн хаягтай гэх боловч хаяг тодорхойгүй	6	0.71
12	Орон нутгийн хаягтай	124	14.59
НИЙТ ДҮН		850	100.00

Эх сурвалж: Нийслэлийн нийгмийн халамжийн газар

Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үед нийслэл хотын нутаг дэвсгэрт хязгаарлалтын дэглэм тогтоож, хэв журам сахиулах нэгдсэн төлөвлөгөө”-ний 1.17-д “Орон гэргүй тэнэмэл иргэдийг хяналтад авч, төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучилж, байрлуулах ажлыг зохион байгуулах” ажлыг Цагдаагийн ерөнхий газар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Тус ажлын хүрээнд Улаанбаатар хотод 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Нийслэлийн Цагдаагийн удирдах газрын албан хаагчид “Тэнэмэл” арга хэмжээг зохион байгуулж, орон гэргүй, тэнэмэл байдлаар амьдардаг 107 иргэнийг олж тогтоон PCR шинжилгээнд хамруулж, 77 иргэнийг Нийгмийн хамгааллын тусгай төвд, 30 иргэнийг “Шинэ амьдрал ялагч”, “Өлзийт Асар”, “Тэрэм Уул”, “Титэм констракшн” ТББ-д тус тус хүлээлгэн өгсөн байна.

Улсын онцгой комиссын даргын 2020 оны 20 дугаар тушаал, “Тэнэмэл, оронгүй иргэдийн талаар авах арга хэмжээний тухай” Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн А/1247 дугаар захирамжийн дагуу 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр нийт 248 иргэнийг олж тогтоон түргэвчилсэн оношлуураар шинжилгээ хийж, ар гэрт нь хүлээлгэн өгөх, Нийгмийн хамгааллын тусгай төв, Түр хоноглох үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, ТББ-т байрлуулах ажлыг зохион байгуулсан байна.

Хүснэгт 20 Нийгмийн хамгааллын тусгай төв болон Түр хоноглох үйлчилгээ үзүүлдэг ТББ-д 2020 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр байрлуулсан иргэдийн судалгаа

№	Үзүүлэлт	Тоо
1	Ар гэрт нь хүлээлгэн өгсөн, гэр оронтой /Цагдаагийн байгууллага, Нийгмийн хамгааллын тусгай төв/	10
2	Нийгмийн хамгааллыг тусгай төвд байршуулсан	102
3	Түр хоноглох үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, ТББ-д хүлээлгэн өгсөн	136
Нийт дүн		248

Эх сурвалж: Нийслэлийн нийгмийн халамжийн газар

Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Нийгмийн хамгааллын тусгай төвд нийт 181 иргэн байрладаг бөгөөд “Covid-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд нийслэлийн хэмжээнд 2020 оны 11 дүгээр сард 248, 2021

оны 2 дугаар сард 107 иргэнийг олж тогтоон нийт 536 иргэнийг хяналтад авсан байна.

Улсын болон нийслэл, дүүргийн онцгой комиссын төлөвлөгөөнд түр оршин суугч болон бүртгэлгүй өрхийг шинжилгээнд хамруулах талаар тусгаагүй бөгөөд харьяалал харгалзахгүйгээр шинжилгээнд хамруулсан гэх боловч нийслэлийн хэмжээнд хэчнээн бүртгэлгүй өрх, түр оршин суугч шинжилгээнд хамрагдсан талаарх тоо мэдээ гараагүй байна.

3.5 Улсын болон Нийслэлийн онцгой комиссын удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс дүүргийн онцгой комисс шинжилгээ авах үйл ажиллагааг бодит тооцоо судалгаанд үндэслэхгүйгээр төлөвлөж хэрэгжүүлсэн байна;

Улсын онцгой комиссын даргын 2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын үеийн “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах ерөнхий төлөвлөгөө”-нд нийслэлийн төвийн 6 дүүргийн 100000 өрхийг шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөн.

Нийслэлийн онцгой комиссын даргын 2021 оны 2 дугаар сарын 9-ны өдөр баталсан “Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед 100000 иргэнийг шинжилгээнд хамруулах арга хэмжээний төлөвлөгөө”-нд нийслэлийн 9 дүүргийн 119000 өрхийг шинжилгээнд хамруулахаар төлөвлөснийг үндэслэн Дүүргийн онцгой комиссын дарга нар төлөвлөгөө баталж, тус арга хэмжээг зохион байгуулсан байна.

Дүүргийн онцгой комиссын дарга нарын баталсан шинжилгээ авах үйл ажиллагааны төлөвлөгөөг цахимаар авч, Улсын болон Нийслэлийн онцгой комиссын төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөсөн эсэхийг судалж үзэхэд шинжилгээнд хамруулах өрхийн судалгаа байхгүй, өдөр тутамд шинжилгээ авах төлөвлөгөө, бүртгэлгүй ажилласан байна.

Хүснэгт 21 Covid19.gerege.mn сайтад бүртгэгдсэн шинжилгээ өгсөн иргэдийн тоог нийт өрхийн тоотой харьцуулсан судалгаа (2021.02.24-ний өдрийн байдлаар)

№	Дүүрэг	Нийт өрхийн тоо	2021.2.11-нээс 22-ны хооронд шинжилгээ өгсөн иргэдийн тоо	Зөрүү
1	Баянгол	62976	75274	-12298
2	Баянзүрх	104764	136339	-31575
3	Сонгинохайрхан	93521	88477	5044
4	Сүхбаатар	40061	48396	-8335
5	Хан-Уул	51241	74587	-23346
6	Чингэлтэй	39345	45138	-5793
7	Багануур	8133	9182	-1049
8	Багахангай	1131	1322	-191
9	Налайх	10248	11681	-1433
Нийт		411420	490396	-78976

Эх сурвалж: УСХ-ны дүүргийн өрхийн тоо, Covid19.gerege.mn сайтын мэдээлэл

Хүснэгтээс харахад нийслэлийн хэмжээнд 411420 өрхөөс нэг иргэнийг шинжилгээнд хамруулахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 490396 иргэнийг шинжилгээнд хамруулсан нь нийт 78796 иргэнээр давсан байна.

Төлөвлөгөөний дагуу 2021 оны 2 дугаар сарын 11-ээс 13-ны өдрүүдэд 100000 өрхөөс тус бүр 1 иргэнийг шинжилгээнд хамруулахаас Нийслэлийн эрүүл мэндийн газраас ирүүлсэн covid19.gerege.mn сайт-д бүртгэгдсэн 116303 иргэний мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзэхэд шинжилгээ гараагүй гэсэн утгатайгаар 1 иргэний мэдээлэл 2-6 удаа давхардан бүртгэгдсэн тохиолдлууд цөөнгүй илэрсэн,

нэг хүн 2021 оны 2 дугаар сарын 08-ны өдрөөс хойш 2-оос дээш удаа шинжилгээ өгсөн зэргээс үзэхэд “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний зорилт бүрэн хангагдаагүй байх магадлалтай байна.

Нэг хаалга - Нэг шинжилгээ арга хэмжээний оношилгооны лабораториудын хүчин чадал, сорьц цуглуулах цэгүүд, тээвэрлэлт, шинжилгээний хийж буй нөхцөл байдал.

Тус арга хэмжээнд ажилласан бүх лабораториуд шинжилгээ хийхээр төлөвлөсөн тоогоо харьцангуй давуулан биелүүлж, өндөр ачааллыг бие, сэтгэлийн хүчээр даван туулж, бүхий л нөөц бололцоогоо дайчлан, өндөр зохион байгуулалттай, сайн ажилласан гэж дүгнэхээр байна.

Лабораториуд халдвар хамгаалалтын дэглэм сайтар сахиж, батлагдсан арга зүйг баримтлан, холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг баримтлан ажиллаж байна.

Лабораториудын хүний нөөцийн сургалт хийсэн байдал, мэдлэг мэргэжлийн түвшин зохих хэмжээнд хангалттай сайн байна.

Лабораториудын шинжилгээ хийх бүхий үйл явцад цаашид анхаарах дараах асуудлууд байна гэж аудитын баг, мэргэжлийн шинжээчдийн зүгээс дүгнэн үзлээ. Үүнд:

1. Нэг лабораторид хийгдэж буй шинжилгээнд өөр өөр үйлдвэрлэгчдийн төхөөрөмж болон урвалжуудыг хослуулан ашигласан нь оновчгүй сонголт болжээ.

Аудитын хүрээнд шалгалт хийсэн газруудад нүклейн хүчил (НХ) ялгах шатанд БНХАУ-ын “Sansure Biotech” компанийн “Natch CS” төхөөрөмжийг мөн компанийн “Multi-type Sample DNA/RNA Extraction-Purification Kit (Magnetic beads method)” ялгах урвалжийн цомогтой хамтруулан шинжилгээний голлох Нүклейн хүчил ялгалтын төхөөрөмж болгон ашигласан байлаа. Харин дараагийн буюу полимеразын гинжин урвалын (ПГУ) шинжилгээний шатанд БНСУ-ын Seegene компанийн “Allplex SARS CoV-2 Assay” цомгийг түлхүү ашигласан байна. ПГУ-д ашигласан төхөөрөмжид мөн БНХАУ-ын “Sansure Biotech” компанийн “MA-6000”, АНУ-ын “Thermo Fisher Scientific” компанийн “ABI-7500”, “Biorad” компанийн “CFX-96” зэрэг харилцан адилгүй төхөөрөмжүүдээр тоноглогдсон байв.

Аудит хөтөлбөрийн хүрээнд Зоонозын өвчин судлалын үндэсний төв, СХД-ын эмнэлэг, БГД-н эмнэлэг, 1-р эмнэлэг гэсэн дөрвөн байгууллагад ийм загвараар оношилгооны ажилбарыг явуулахаар тоног, төхөөрөмж, бодис, урвалж, оношлуурын хангамж хийгдсэн байсан. Эндээс дараах асуудлууд гарч ирж байна.

2. ПГУ-н цомог үйлдвэрлэгчээс зөвлөсөн нүклейн хүчил ялгах төхөөрөмж болон нүклейн хүчил ялгахад ашигласан цомгоос өөр цомгоор хийсэн нь олон лабораториудад “хүчингүй”, болон “хуурамч эерэг” гэсэн хариу гарах эрсдэлтэй байна.

Allplex SARS-CoV-2 цомгийн үйлдвэрлэгчийн заавар дээр уг цомгоор ПГУ хийхэд баталгаа өгсөн НХ ялгах төхөөрөмж болон цомгийн жагсаалтыг гаргасны дотор Sansure компанийн дээр дурдсан төхөөрөмж болон урвалжийн цомог заагдаагүй болно (Allplex SARS-CoV-2 Assay – гарын авлага хуудас 12 – 15).

Энэ нь буруу оношлогоо хийгдсэн тохиолдолд үйлдвэрлэгч оношилгооны үнэн зөв байдлын талаар хариуцлага хүлээхгүй гэсэн үг юм. Энэ асуудал нь гүйцэтгэл талаасаа мөн л хүндрэл учруулна.

Нөгөө талаас хэрэв НХ ялгасан төхөөрөмж болон цомгийг үйлдвэрлэсэн Sansure Biotech компанийн “Novel Coronavirus (2019 – nCoV) Nucleic Acid

Diagnostic Kit (PCR – Fluorescence probing)” цомгийг ПГУ-д ашигласан бол, тус компанийн НХ ялгагч Natch CS төхөөрөмж нь өөрийн ялгасан нүклейн хүчлийг мөн өөрийн компанийн ПГУ-н цомогт орох бодис урвалжуудтай мөн л автоматаар хольж, шууд ПГУ-н төхөөрөмжид хийхэд бэлэн ПГУ-н мастер микс буюу холимгийг бэлдэх боломжтой байсан.

Ингэснээр Natch CS -р ялгасан нүклейн хүчлийг машин дотроос нь гарган авч, ПГУ- кабинетэд зөөвөрлөн аваачиж, Allplex SARS-CoV-2 цомогт орсон бодис урвалжтай хольж 96-н нүхтэй ПГУ-н таваг руу юүлэх байдлаар гар ПГУ мастер холимгийг бэлдэх ажилбарыг хийсэн нь дараах дутагдалтай талуудыг бий болгосон. Үүнд:

- Гараар найруулахад цаг хугацаа орох тул оношлогооны явц удааширна.
- Алдаа гарах эрсдэл өндөр жишээ нь ПГУ-д орох урвалын холимог болон сорьцын хэмжээ нэг ПГУ-н тавагны нүхэнд хуваарилагдах нарийвчлал буурснаас invalid буюу хүчингүй хариу гарах магадлал нэмэгдэнэ.
- Шинжилж буй сорьцууд хоорондоо холилдсоноор шинжилгээний хариуны үнэн зөв байдал алгадах магадлал их
- Оношлогооны багийн ажилтнуудын ажлын ачаалал нэмэгдэнэ.

Эдгээр асуудлуудыг бүхэлд нь нэгтгэн дүгнэхэд нэг хаалга нэг өрх шинжилгээний ажилбарыг илүү төвөгтэй, хүнд болгож байгаа болно.

Бидний шалгасан нэлээд лабораторид зарим шинжилгээний хариу Invalid (хүчингүй) гэсэн үр дүн гарч байсан. Тухайлбал Баянгол дүүргийн эмнэлгийн лабораторид 2-р сарын 18-ны байдлаар нийтдээ 9524 шинжилгээ хийсний нь 95 нь Invalid гарсан бол Сонгино хайрхан дүүргийн эмнэлгийн лабораторид 2-р сарын 18-ны байдлаар 9483 шинжилгээ хийсний 347 нь Invalid гэсэн үр дүнтэй гарсан байлаа.

ПГУ явуулсан Seegene компанийн Allplex SARS-CoV-2 assay оношлогооны цомгийн гарын авлагаас харахад:

- ПГУ-н дотоод хяналтын материалыг огт нэмээгүй буюу зохих хэмжээнд нь нэмээгүй.
- Нүклейн хүчил ялгах аргачлал амжилттай явагдаагүй буюу ялгасан нүклейн хүчил дотор ПГУ-г дарангуйлагч бодисууд их байсан.

зэрэг шалтгаанаас үүдэлтэй бөгөөд үүний тулд ПГУ-г давтан хийх, нүклейн хүчил ялгалтын шатнаас давтах эсвэл бүр сорьцыг давтан авах хүртэл хүндрэлтэй ажлууд урган гарч байна.

Allplex SARS-CoV-2 ПГУ цомгийн гарын авлагад заагдсан нүклейн хүчил ялгах цомгуудын тоонд Sansure Biotech компанийн Natch – CS төхөөрөмж өөрийн НХ ялгах урвалжтайгаа багтаагүй бөгөөд эндээс Natch – CS төхөөрөмжийн нүклейн хүчил ялгахдаа хэрэглэх сорьцын эзлэхүүн Seegene компанийн ашигласан цомгуудын эзлэхүүн зөрүүтэй бөгөөд эдгээр сорьцын эзлэхүүн, нэгж сорьцод дусаах дотоод хяналтын эзлэхүүн хоорондын зөрүүнээс үүдэн invalid шинжилгээний үр дүн гарч байх магадлал өндөртэй юм.

Энэ хоёр лабораторийг дундажлаж үзэхэд алдааны хувь 2.3% байна. Хэрэв нэг хаалга нэг өрх хөтөлбөрийн хүрээнд 420 гаруй мянган өрхийн шинжилгээг хийх 84 мянган (5-р багцлахад гарах тоо) шинжилгээнд ийм хувийн алдаа гарч байгаа гэж үзвэл 1680 гаруй оношлуур дэмий үрэгдэх асуудал гарч байна. Иймд цаашдаа дотоод хяналтын хэмжээг ихэсгэж, хүчингүй гарах хариуны тоог бууруулахын тулд шаардлагатай арга хэмжээг авах нь чухал байна.

3. ПГУ-н цомог үйлдвэрлэгчээс зөвлөсөн ПГУ-н төхөөрөмжийг ашиглаагүй.

Allplex SARS-CoV-2 цомгийн үйлдвэрлэгчийн заавар дээр ямар төхөөрөмж ашиглан хийх ПГУ-ын төхөөрөмжид зөвхөн Biorad компанийн CFX-96 төхөөрөмжийг зөвлөсөн байсан. (эх сурвалж хавсаргасан материалууд дотроос Allplex SARS-CoV-2 цомгийн үйлдвэрлэгчийн гарын авлагыг харна уу) Гэтэл зарим лабораториуд MA-6000 гэсэн өөр үйлдвэрлэгчдийн төхөөрөмжийг ашиглаж байгаа нь өмнөх зүйлтэй адил асуудал үүсгэх юм. Тухайлбал, ЗӨСҮТ-ийн лаборатори.

Цаг хугацаа, мөнгө санхүүгийн хувьд хүндрэлтэй өнөөгийн нөхцөлд богино хугацаанд олон хүн хамарсан шинжилгээ хийхэд байгаа боломжоо дайчлах нь зүйтэй боловч энэ нь шинжилгээний үнэн зөв байдалд нөлөөлөх нөлөөлөл байж болно. Иймээс эдгээр төхөөрөмжид Allplex SARS-CoV-2 цомгийг ашиглахад боломжтой гэсэн баталгаажуулах шинжилгээг урьдчилан хийсэн байх шаардлага гарсан.

4. Seegene компанийн Allplex SARS-CoV-2 Assay цомгийг сонгон авсан нь ПГУ-н мэдрэг чанарыг сайжруулах боломж байсныг алджээ.

Аливаа оношлуурын чадавхийг дүгнэхдээ өвөрмөгц болон мэдрэг чанар хэмээх хоёр үзүүлэлтийг голлож хардаг. Өвөрмөгц чанар гэдэг нь тухайн оношилгоогоор зөвхөн тухайн өвчин үүсгэгчийг зөв зүйтэй оношилж, өөр өвчин үүсгэгчтэй эндүүрэхгүй байх нөхцөлийг хэлдэг. Allplex SARS-CoV-2 цомог нь SARS-CoV-2 вирүсийн 4 геныг, мөн ПГУ-н дотоод хяналтын 1 геныг олшруулж илрүүлдэг бол, Sansure компанийн Novel Coronavirus (2019 - nCoV) оношлуурын хувьд 2 геныг 1 ПГУ-н дотоод хяналттай цуг илрүүлж байна (эх сурвалж эдгээр хоёр ПГУ-н оношлуурын цомгуудын гарын авлагыг харна уу).

4 ген олшруулж байгаа нь хэдийгээр өөр организмтай андуурах эрсдэлийг бууруулж шинжилгээний өвөрмөгц чанарыг сайжруулж байгаа хэдий ч нөгөө талаас мэдрэг чанарын асуудал тавигдана.

Мэдрэг чанар гэдэг нь тухайн шинжилгээгээр илрүүлэх боломжтой хамгийн бага вирүсийн хэмжээг хэлдэг. Энэ чанар нь янз бүрийн үйлдвэрлэгчдийн бүтээсэн ПГУ-н цомог тус бүрт харилцан адилгүй байх бөгөөд тухайн цомог хэдий чинээ бага хэмжээтэй вирүс илрүүлж байна төдий хэмжээгээр мэдрэг чанар сайтай байна гэсэн үг.

Энэ нь практик ажилбар дээр тухайн өвчтөн халдвар аваад удаагүй, вирүсийнх нь хэмжээ бага байхад илрүүлэх боломжийг нөхцөлдүүлдэг тул хэдий чинээ мэдрэг чанар өндөртэй оношлуур ашиглана тэр хэмжээгээр вирүсийн хэмжээ багатай олон хүнийг илрүүлэх боломж хангагдана гэсэн үг.

Энэ асуудал нь хүн амын насны бүтцэд 40-өөс доош насныхан эзлэх хувь өндөртэй, үүнийг дагаад өвчний явц хөнгөнтэй манай орны нөхцөлд чухлаар тавигдах асуудал юм.

Одоо эргээд ашигласан Allplex SARS-CoV-2 assay болон Novel Coronavirus (2019-nCoV) цомгуудын мэдрэг чанарууд буюу илрүүлэх доод хязгаарыг харьцуулая. Allplex SARS-CoV-2 цомгийн хувьд хэрэв мэдрэг чанар нь өөрийн компанийн Seegene Nimbus IVD төхөөрөмжийг өөрийн компанийн нүклеин хүчил ялгах STARMag 96 X 4 урвалжийн цомгоор ялган илрүүлэг хийхэд 1000 копи/мл (1 мл эзлэхүүнтэй сорьцонд 1000 вирүсийн копи байхад илрүүлэх боломжтой гэсэн үг) байсан бол Sansure компанийн Novel Coronavirus (2019-nCoV) цомгийг өөрийн НХ ялгах төхөөрөмж, цомгоор ялгаж ашиглахад 200 копи/мл буюу 5 дахин илүү мэдрэгээр илрүүлэх боломжтой.

Нэгэнт НХ ялгах шатанд Sansure компанийн төхөөрөмж болон цомог ашигласантай адилаар ПГУ-н шатанд мөн тус компанийн цомгийг ашигласан бол илүү мэдрэг чанартай оношлогоог хийх боломж байгааг онцлох хэрэгтэй.

5. Нэг дор 96 сорьцоос нуклейн хүчил ялгадаг багаж худалдан авах боломжтой байтал нэг дор 48 сорьц ялгадаг төхөөрөмж худалдан авч ашигласан нь ПГУ-ийн багажны хүчин чадлаасаа дутаж оношлогооны хөтөлбөрийг бүхэлд нь удаашруулжээ.

Нэг хаалга нэг өрх ажилбарын хүрээнд нуклейн хүчил ялгах ажилбарын үнэмлэхүй дийлэнх хэсгийг БНХАУ-ын Sansure компанийн Natch – CS бүрэн автомат нуклейн хүчил ялгах төхөөрөмжөөр гүйцэтгэсэн байна. Энэ төхөөрөмж нь нэг доор дээд тал нь 48 сорьцоос вирүсийн нуклейн хүчил ялгах чадалтай бөгөөд үүндээ ойролцоогоор 2.5 – 3 цаг хэрийн хугацаа зарцуулдаг.

Тэгвэл тус компани нь мөн “Natch–S” болон “Natch–CS2” төхөөрөмжүүдийг үйлдвэрлэдэг. Эдгээр төхөөрөмжүүд нь нэг дор 2 дахин их буюу 96 сорьцоос ойролцоо хугацаанд ялгах чадвартай бөгөөд ингэснээр ажлын хурдыг 2 дахин хурдасгах боломж байсан. Иймд эцсийн дүндээ нэг хаалга 1 өрх шинжилгээний нэг өдрийн гарц, цаашлаад нийт шинжилгээ хийх хөтөлбөрт ажлын хугацааг мэдэгдэхүйц бууруулах боломж байсан.

Цаашлаад нэг хаалга нэг өрх шинжилгээг 2 удаагийн давталттайгаар авснаар нууц (латент) үедээ байсан халдваруудыг нэмж илрүүлэх боломж гарч ирэх юм.

Эсвэл нуклейн хүчил ялгах шатандаа БНСУ-н Seegene компанийн “STARlet IVD” нуклейн хүчил автоматаар ялгах төхөөрөмжийг ашигласан бол нэг дор 96 сорьцоос нуклейн хүчил ялгах боломжтой бөгөөд энэ тохиолдолд нэг компанийн 1 нуклейн хүчил ялгах төхөөрөмж болон цомгийг ПГУ-тай хоршуулан хэрэглэснээр илүү баталгаажсан шинжилгээнүүдийг богино хугацаанд их хэмжээтэйгээр явуулах боломж байв.

Нөгөө талаас ПГУ-д ашигласан ABI-7500, CFX-96, MA-6000 зэрэг төхөөрөмжүүд нь бүгдээрээ нэг дор дээд тал нь 96 хүртэл сорьцыг олшруулж шинжилгээ хийх боломжтой. Эндээс нэгж ПГУ-д Natch–S төхөөрөмжөөр ялгасан 48 сорьцыг олшруулж үлдсэн 48 нүхэндээ хоосон явуулах нөхцөл бий болж байсан. Үүнийг шинжилгээний зарим лабораториуд хоосон явуулж байсан бол зарим нь янз бүрийн үйлдвэрлэгчийн ашигласан гараар нуклейн хүчил ялгах цомгийг ашиглаж гараар ялган дүүргэлт хийж байсан.

Үр дүнд нь лабораторийн ажиллагсдын ачаалал нэмэгдэж, алдаатайгаар ялгалт хийх, машинаар ялгасан сорьцуудын ариун байдал алдагдах гэх мэтээр төрөл бүрийн асуудал гарах эрсдэл үүссэн.

6. Нэг хаалга нэг өрх шинжилгээнүүдийн бүртгэл хангалтгүй байсан

Шинжилгээ хийж байсан лабораториудад нэг хаалга-нэг өрх шинжилгээнээс гадна гэрээт байгууллагууд (тухайлбал ЗӨСҮТ өөрийн хамгаалалтыг хариуцсан дотоодын цэргийн нэгтгэлийн шинжилгээг POS машины бүртгэлгүй хийж байсан) мөн дотоодын ажилчдын шинжилгээ, өмнө илэрсэн тохиолдлуудын хяналтын шинжилгээ зэрэг өөр шинжилгээнүүдийг мөн хийж байв.

Харин шинжилгээ хийж байгаа лабораторийн ажилтнуудын хувьд эдгээр сорьцууд хооронд ялгасан бүртгэлийг цаанаас өгөөгүй байсан бөгөөд оношлогооны ажилбарыг тал бүрээс ирсэн сорьцуудтай хамтад нь хийж байв.

Эндээс эерэг гарсан сорьцын аль нь хяналтынх вэ, аль нь нэг хаалга нэг өрх шинжилгээнийх вэ гэдгээ шууд хэлэхэд хүндрэлтэй байсан.

Цаашид эдгээр шинжилгээнүүдийн бүртгэлийг лаборатори тус бүрт ялган өгч, тусад нь бүртгэлжүүлэх нь нэг хаалга- нэг өрх хөтөлбөрийн биелэлтийг бодитойгоор хянахад нэмэртэй болно.

7. Үндэсний хэмжээнд чанарын хяналт тавьж буй ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн үйл ажиллагааны нөхцөл байдал хангалтгүй байна.

ХӨСҮТ-ийн вирус судлалын лаборатори нь үндэсний хэмжээнд Ковид-19-ийн оношлогооны чанарын хяналтыг тавьж ажиллаж байна.

Энэ зорилгын хүрээнд бусад лабораториудаас эерэг гарсан сорьцыг хүлээн авч баталгаажуулах, 4-н өдөрт нэг удаа 10 ширхэг сөрөг сорьцуудыг хүлээн авч баталгаажуулах, чанарын хяналтын материал тарааж өгөөд чанарын гадаад үнэлгээ зохион явуулах, лабораторид асуудал үүссэн үед газар дээр нь очиж экспертэй хийж асуудлыг шийдвэрлэх зэрэг үйл ажиллагааг хариуцаж байна.

Гэвч ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн ашиглаж буй багаж тоног төхөөрөмж, урвалж бодисууд нь улсын хэмжээний бусад бүх лабораториудаас эрс өөр байна. Энэ байдал нь бусад лабораториудын үр дүнг ижил арга зүйгээр нарийн хянах боломжгүй болгож, зөвхөн эцсийн үр дүнд буруу эсвэл зөв гэсэн дүгнэлт өгөх л боломжтой болгож байна.

Ялангуяа ХӨСҮТ-ийн вирус судлалын лабораторийн арга зүй нь бусад лабораториудын нуклейн хүчил ялгаж буй арга зүйд хяналт тавих ямар ч техникийн боломжгүй байна.

Мөн ХӨСҮТ-ийн вирус судлалын лаборатори нь бусад лабораториудаас технологийн хувьд эрс өөр учраас бусад лабораториудад үүссэн асуудлыг газар дээр нь очиж шийдвэрлэх, арга зүйн туслалцаа үзүүлэх, өөрсдийн тэргүүн туршлагыг хуваалцах боломжгүй байдалтай байна.

8. ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн ажлын байрны талбай, хүний нөөц хангалтгүй байна.

ХӨСҮТ-ийн Вирус судлалын лаборатори нь үндэсний хэмжээнд Ковид-19-ийн оношлогооны чанарын хяналтыг тавьж ажиллах нэгж мөн боловч түүний ажлын байрны талбай, хүн хүчний тоо хангалтгүй байна.

Нэг хаалга-нэг шинжилгээ компанит ажлын хүрээнд уг лабораторийн ажлын ачаалал хэтэрч зай талбай, хүний нөөцийн хүчин чадлыг давсан ачаалал үүсжээ.

Энэ байдал нь уг лабораторийн үндэсний хэмжээнд чанарын хяналт хийх чиг үүргээ хангалттай хэмжээнд биелүүлэх боломжгүй байдалд оруулсан байна. Жишээлбэл ЭМЯ-ны А50 тоот тушаалын хавсралтаар батлагдсан хуваарийн дагуу лабораториуд бүрээс 10 ширхэг сөрөг сорьцыг хүлээн авч (лабораториуд бүгд хуваарийн дагуу явуулсан) баталгаажуулан хянаж, тухай бүрд нь эргэж мэдээлж байх байнгын үйл ажиллагаа алдагдсан байна.

Зөвхөн зарим лабораториудад хуваарийн эхний удаагийн 10 сорьцын баталгаажсан хариу ирээд дараагийн 2 удаагийн баталгаажуулалтын хариунууд ирээгүй байна.

Мөн угаасаа хүний тоо цөөхөн боловч 2-р сарын 20-нд 3-н хүнийг Япон улсад секвенсийн сургалтад явуулахаар болж ажлаас түр чөлөөлсөн нь хүний тоог улам багасгасан байна. 2 сарын 19-ны өглөөний 9 цагийн байдлаар ХӨСҮТ-ийн Вирус судлалын лаборатори нь 4003 сорьцын үлдэгдэлтэй байлаа.

9. ЭМЯ-аас баталсан А49, А50 тоот тушаал зааврын зарим зүйлүүд бодит байдал, газар дээрх техникийн хүчин чадалтайгаа нийцэхгүй байна.

ЭМЯ-ны А49 тоот тушаалаар батлагдсан зааврын 8.7 ба 8.8-р зүйлд тусгагдсан сөрөг сорьцуудыг бүгдийг нь хасах 70-80 градуст 1-2 сар хадгалах, нийт сорьцуудын 5-10 хувийг ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторид илгээх гэсэн заалтууд нь Улсын 1-р төв эмнэлэг, Улсын 2-р төв эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн төв зэрэг их хэмжээгээр шинжилгээ хийж байгаа лабораториудад хэрэгжихэд туйлын хүндрэлтэй, одоогийн техникийн хүчин чадлаас хэтэрхий давсан ачааллыг үүсгэхээр байна.

Ийм учраас эдгээр томоохон лабораториудад энэ заалт бүрэн хэрэгжээгүй, хэрэгжих бололцоогүй байна.

Хэрвээ хэрэгжсэн тохиолдолд ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн аль хэдийн хэтэрсэн ачааллыг улам их нэмж угаасаа амьдралд хэрэгжих боломжгүй байна. Иймд дээрх дурдсан зааврууд нь хэтэрхий хийсвэр, хүчин чадлаасаа давсан заавар болжээ.

10. Лабораториудад ирж буй өдөр өдрийн сорьцын тоо харьцангуй их хэлбэлзэж, 16, 17, 18-нд огцом өсөж ачаалал хэт ихсэж, шинжлэгдээгүй сорьцын хүлээгдэл ихэссэн байна.

Лабораториуд нь хоногт хэдэн шинжилгээ хийх хүчин чадлаа тодорхойлсон байгаа боловч шинжилгээ хийж байгаа лабораториудын сорьц хүлээн авч байгаа болон шинжилж байгаа тоо нь төлөвлөсөн тооноос өндөр байна.

ХӨСҮТ-ийн лабораторид 2021 оны 2 сарын 16,17,18-ны өдөр шинжлүүлэхээр ирж байгаа сорьцын тоо өмнөх өдрүүдээс нэмэгдсэн байгаа нь шинжилгээний сорьц цуглуулах, лабораториудад хуваарилалт хийх ажил дээр зохион байгуулалт тааруухан байгааг илтгэж байна.

Мөн лабораторид ирж байгаа сорьц нь Нэг хаалга -Нэг шинжилгээний сорьц уу эсвэл тандалтын сорьц уу гэдгийг хянаж байгаа болон ялгах боломж байхгүй байна.

11. Лабораториудын хүний нөөцийн тоо хангалтгүй, ХӨСҮТ-ийн Вирус судлалын лаборатори чанарын хяналт хийх чадавхи хангалттай бүрдүүлэх боломжгүй байна.

Лабораториудын хүний нөөцийн тоо нь харилцан адилгүй буюу УХТЭ-т 41 ажилтан 3 ээлжээр ажиллаж, УНТЭ-т 30 хүн 3 ээлжээр ажиллаж байхад ХӨСҮТ-ийн 3 лаборатори тус бүрт 15 хүн 3 ээлжээр ажиллах зэрэг хүний нөөцийн ачааллын хуваарилалт ялгаатай байгаагаас болж ачаалал тэнцүү бус байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Нэг. Төлөвлөлт, зохион байгуулалттай холбоотойгоор:

- Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27¹.1.1-д “гамшгаас хамгаалах үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, шийдвэр гаргах, хэрэгжилтийг шуурхай зохион байгуулах, гамшгийн эрсдэлийг бууруулах, хор уршгийг арилгах, хяналт тавих” гэсэн заалттай нийцэхгүй, Улсын онцгой комиссын даргын баталсан “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний төлөвлөгөөтэй уялдуулахгүйгээр Нийслэлийн онцгой комиссын дарга 2021 оны 2 дугаар сарын 08, 09-ны өдөр 2 төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн байна.;
- Улсын болон Нийслэл онцгой комиссын удирдлага зохион байгуулалт хангалтгүйгээс Дүүргийн онцгой комисс шинжилгээ авах үйл ажиллагааг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, шинжилгээ авах байнгын болон явуулын багийн ажлын ачааллыг жигд зохион байгуулаагүй, өдөр тутмын шинжилгээ авах ажлын төлөвлөгөө, бүртгэлгүй ажилласан;
- Засгийн газрын 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 29 дүгээр тогтоолоор байгуулсан “Эрсдэлийн мэдээлэл харилцааны Түр хороо”-ны ажиллагааны чиглэл, ажил үүргийн хуваарь, Ажлын шуурхай хэсгийн ажиллах журмыг батлан гаргаагүй, Түр хорооны үйл ажиллагаа эхлэлгүй хоног хугацаа алдсанаас МУ-ын Засгийн газар болон УОК-оос гаргасан шийдвэр, “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээний цаг үеийн мэдээллийг иргэд олон нийтэд түгээх ажил хангалтгүй хэрэгжсэн байна;
- Засгийн газар, УОК-ын холбогдох шийдвэрт салбар дундын эрсдэлийн үнэлгээний тайлангаас гаргасан саналуудыг тусгасан хэдий ч Эрдэмтдийн зөвлөлийн зөвлөмжийг бүрэн тусгаагүй байна;
- Гамшиг тохиолдсон үед шат, шатны төсвийн санхүүжилт хийхэд төсвийн хуваарийн хүрээнд баригдаж төсөвлөгдөж буй байдал ажиглагдлаа. Энэ нь шуурхай ажиллах боломжийг бууруулж байна;

Хоёр. Хэрэгжилтийн үе шаттай холбоотойгоор:

- УОК, НОК болон холбогдох төрийн байгууллагуудын батлан гаргасан төлөвлөгөөнүүдэд “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулах хариуцан, зохион байгуулах ажлын хэсэг, байгууллага нэгжийг томилохдоо Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5 дугаар бүлэгт заасан гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, удирдлагын зохицуулалт, чиг үүрэгтэй уялдуулаагүй, хуулийн этгээд, иргэний оролцоог тусгаагүй, Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд суурилаагүйгээс уг арга хэмжээний хэрэгжилт доод болон дунд шатанд хэрэгжүүлэх, биелэлтийг тооцоход хүндрэлтэй байдлыг үүсгэсэн байна;
- УОК-ын ажлын алба батлагдсан орон тоогоор ажиллаагүйгээс холбогдох байгууллагуудаас ирүүлж буй тайлан мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, үүрэг даалгаврын биелэлт бодитой эсэхийг хянах боломж бүрдээгүй байна;
- “Нэг хаалга-Нэг шинжилгээ” арга хэмжээг зохион байгуулсан төрийн байгууллагуудын уялдаа холбоо хангагдаагүйгээс Гамшгаас хамгаалах тухай хуульд заасны дагуу өмнө хийгдсэн байх ёстой судалгаа, мэдээллийг дахин гаргах чиг үүргийг бий болгож холбогдох төрийн байгууллагуудын

ажлын ачаалал нэмэгдүүлэх, тус арга хэмжээний зохион байгуулалтад оролцож байгаа төрийн албан хаагчид, шинжилгээ авч байгаа эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудын үйл ажиллагаанд хүндрэлийг үүсгэжээ;

- “Нэг хаалга-нэг шинжилгээ” арга хэмжээний хэрэгжилтэд МХЕГ, ЭМЯ, НЗДТГ-ын ХШҮХ-ээс хяналт тавьж, тодорхой зөрчлүүдийг арилгаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна;
- Төлөвлөгөөний дагуу тус арга хэмжээний эхний 3 хоногт зорилтот 100000 өрхийг хамруулна гэж төлөвлөсөн ч тухайн өрхүүд хамрагдсан эсэхийг тогтоох нарийвчилсан судалгаа, нэгдсэн бүртгэлгүй байгаа нь голомтот хэсгүүд бүрэн хязгаарлагдсан гэдгийг дүгнэх бололцоогүй байна;
- Нэг лабораторид хийгдэж буй шинжилгээнд өөр өөр үйлдвэрлэгчдийн төхөөрөмж болон урвалжуудыг хослуулан ашигласан нь оновчгүй сонголт болсон;
- ПГУ-н цомог үйлдвэрлэгчээс зөвлөсөн нуклейн хүчил ялгах төхөөрөмж болон нуклейн хүчил ялгахад ашигласан цомгоос өөр цомгоор хийсэн нь олон лабораториудад “хүчингүй”, болон “хуурамч эерэг” гэсэн хариу гарах эрсдэлтэй байна;
- ПГУ-н цомог үйлдвэрлэгчээс зөвлөсөн ПГУ-н төхөөрөмжийг ашиглаагүй;
- Seegene компанийн Allplex SARS-CoV-2 Assay цомгийг сонгон авсан нь ПГУ-н мэдрэг чанарыг сайжруулах боломж байсныг алджээ;
- Нэг дор 96 сорьцоос нуклейн хүчил ялгадаг багаж худалдан авах боломжтой байтал нэг дор 48 сорьц ялгадаг төхөөрөмж худалдан авч ашигласан нь ПГУ-ийн багажны хүчин чадлаасаа дутаж оношлогооны хөтөлбөрийг бүхэлд нь удаашруулжээ;
- ЭМС-ын 2020 оны 12-р сарын 22-ны өдрийн А/606 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Коронавируст халварын вирусн нуклейн хүчилд суурилсан бодит хугацааны урвуу транскриптазаат ПГУ-ын шинжилгээ хийх түр заавар” ДЭМБ, АНУ-ын CDC зэрэг байгууллагуудаас гаргасан зөвлөмжтэй нийцээгүй байна.
- 2021 оны 02 сарын байдлаар Израйль, Америкийн Нэгдсэн Улс, Арабын Нэгдсэн Эмират зэрэг улс орнууд иргэдээ богино хугацаанд КОВИД-19 өвчний эсрэг вакцинжуулалтыг хийж байна. Эдгээр улс нь ард иргэдээ вакцинжуулалтад хамруулах үйл ажиллагааг хянах зорилгоор нөхцөл байдалд тохируулан гар утасны аппликейшнууд гарган ажиллаж байна.

Гурав. Тайлагналын үе шаттай холбоотойгоор:

- “Нэг хаалга - Нэг шинжилгээ” арга хэмжээний хүрээнд бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт хэсэгчлэн шилжүүлсэн үед тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 94.5%, нийтийн тээврийн хэрэгслээр зорчсон иргэдийн хөдөлгөөнийг 96.5% хүртэл хязгаарлан дэглэмийг сахиулж ажилласан байна;
- Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжин ажиллах үед дайчлан ажиллуулах албан хаагчдыг холбогдох тооцоо судалгаанд үндэслэн хуваарилсан ч цагдаа хүчний байгууллагаас бусад төрийн албан хаагчдын нэгдсэн мэдээллийн сан шинэчлэгдээгүйгээс зохион байгуулалт нь төлөвлөлтийн дагуу хэрэгжээгүй байна;
- Бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлэхээс өмнө хязгаарлалт тогтоох, шинжилгээ авахтай холбоотой ерөнхий мэдээллийг иргэдэд өгсөн ч зохион

байгуулалтын талаарх нарийвчилсан, системтэй мэдээллээр бүрэн хангаагүй байна;

- Цагдаагийн байгууллагаас хөл хорио, хязгаарлалтын үед гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, хэв журам сахиулах үүргээ хэрэгжүүлэн ажиллажээ;
- Халдвар авсан иргэд, ойрын хавьтлыг олж тогтоох ажлыг хэрэгжүүлж ажилласан байна;
- Арга хэмжээтэй холбоотой санхүүгийн ил тод байдлыг бүрэн хангаагүй, хандив тусламжаар хэдэн төгрөг цугласан, түүний зарцуулалт, Улс, Нийслэл, Орон нутгийн төсвөөс хэдэн төгрөг зарцуулсан талаарх нэгдсэн мэдээлэлгүй байна;
- Улсын болон нийслэл, дүүргийн онцгой комиссын төлөвлөгөөнд түр оршин суугч болон бүртгэлгүй өрхийг шинжилгээнд хамруулах талаар тусгаагүй бөгөөд харьяалал харгалзахгүйгээр шинжилгээнд хамруулсан гэх боловч нийслэлийн хэмжээнд хэчнээн бүртгэлгүй өрх, түр оршин суугч шинжилгээнд хамрагдсан талаарх тоо мэдээ гараагүй байна.;
- Санхүү төсвийн төлөвлөлт, нөөц, хуваарилалт хийхтэй холбоотой суурь судалгаанууд бэлэн бус, тооцоо судалгаагүйгээс шалтгаалж үйл ажиллагааг явуулахад урсгал зардал дутах хүндрэл учирч албан хаагчид хувиасаа гаргах бэрхшээл учирч байна;
- Энэхүү арга хэмжээ нь төлөвлөгөө, гүйцэтгэл нь зэрэгцэж явагдсанаас хяналт, үнэлгээ хийхэд ихээхэн хүндрэлийг учруулсан арга хэмжээ болсон;

ЗӨВЛӨМЖ

Аудитаар илрүүлсэн зүйл, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

- Гамшиг тохиолдсон үед шат, шатны төсвийн санхүүжилт хийхэд төсвийн хуваарийн хүрээнд баригдаж төсөвлөгдөж буй байдлыг шийдвэрлэх талаар холбогдох хуульд өөрчлөлт оруулах саналыг бэлтгэж, УИХ-д өргөн мэдүүлэх;
- Олон нийтийг хамарсан халдварт өвчний чиг үүргийн байгууллагуудын эрх зүйн байдал үүрэг чиглэлийн давхардал хийдлийг гаргахгүй байхад чиглэсэн хууль эрх зүйг боловсронгуй болгох.

Монгол Улсын Шадар сайдад:

- Засгийн газрын 2021 оны 29 дүгээр тогтоолын 6-д заасны дагуу Эрсдэлийн мэдээлэл харилцааны Түр хорооны үйл ажиллагааны чиглэл, ажил үүргийн хуваарь, Ажлын шуурхай хэсгийн ажиллах журмыг Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, Гамшгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 -д заасантай уялдуулан яаралтай батлан мөрдүүлэх;
- Цаашид ковид-19 цар тахалтай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар болон УОК-оос гаргах шийдвэр, цаг үеийн мэдээлэл, мөн иргэд олон нийтэд хүргэх шаардлагатай заавар, зөвлөмж, уриалга зэргийг түгээх асуудлыг агуулгаар нь ангилан авч үзэх, хариуцан хэрэгжүүлэх байгууллага албан тушаалтны чиг үүргийг холбогдох хууль тогтоомж¹⁵-д нийцүүлж нарийвчлан журамлах;
- УОК, НОК болон холбогдох төрийн байгууллага хооронд мэдээлэл солилцох, мэргэжлийн анги, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд дайчлагдах хүн хүч, авто машин, техник хэрэгслийн дата, мэдээллийн сан, цахим системийг улсын хэмжээнд бүрдүүлэх, хуулийн этгээд, иргэдийн оролцоог хангаж, нэгтгэн зохион байгуулах;
- Хязгаарлалтын дэглэм тогтоохдоо зохион байгуулалттай холбоотой эрсдэлүүдийг урьдчилан тооцоолж төлөвлөх, уялдаа холбоог хангах;
- УОК-ын дэргэдэх эрдэмдтийн зөвлөлд төрөөс шууд хамааралгүй, хөндлөнгийн хараат бус вирүс-судлаач, молекул биологич, тархвар судлаач, генетикч, халдвар судлаач, халдвартын эмч биофизикч, математикч зэрэг эрдэмтдийг нэмж оруулах;
- Гамшгийн үеийн бэлэн байдлын нэгдсэн стратегид халдварт өвчин тархвар зүйтэй холбоотой эрүүл мэндийн салбарын асуудлыг нэмж тусгах, УОК-ийн бүрэлдэхүүнд тухайн салбарын багийг оруулж шийдвэр гаргах;
- Анхан шатны бүртгэлийг УБЕГ, дүүргийн засаг захиргааны нэгж, өрхийн эмнэлгийн эрүүл мэндийн салбарын бүртгэлийг уялдуулах, шинэчлэлтийг тухай бүрд хийж байх;
- Өрх бүрийн хаалганд QR код эсвэл зураасан кодыг олгож, орон зайн байршилд тулгуурласан бүртгэл, мэдээллийн нэгдсэн өгөгдлийн санг бий болгох;

¹⁵ Тухайлбал, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан зохицуулалтыг хэрэгжүүлэх асуудлаар “Хэвлэл мэдээллээр цар тахлаас урьдчилан сэргийлэх чиглэлийн заавар, зөвлөмж, уриалгыг тогтмол түгээх хариуцлагын гэрээ” байгуулж үүргийн хэрэгжилтийг хангуулах боломжтой.

- Вакцинжуулалтын мэдээллийн санг гар утасны аппликейшн болон цахим бүртгэл ашиглан бодитоор бүрдүүлэх, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх лавлагааг олгох;
- Цахим технологи (Google, Apple-ийн “Expose Notifications” функци гэх мэт) ашиглаж хавьтал тодорхойлох.

Эрүүл мэндийн сайдад:

- Оношилгооны лабораториудын хүчин чадал, сорьц хадгалах байрны нөхцөлийг сайжруулах, лавлагаа лаборатори бий болгох талаар арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Гамшгийн үеийн арга хэмжээний үед баримтлах, бодлого, заавар, тушаал шийдвэрүүдийг бодит байдалтай нийцүүлэн шинэчлэх, олон нийтийг хамарсан халдварт өвчний үеийн менежмент явуулах бүтэц үйл ажиллагааг боловсронгуй болгох;
- ЭМС-ын 2020 оны А/606 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан “Коронавируст халдварын вирусын нуклейн хүчилд суурилсан бодит хугацааны урвуу транскриптазаг ПГУ-ын шинжилгээ хийх” түр зааврыг ДЭМБ, АНУ-ын CDC зэрэг байгууллагуудаас гаргасан зөвлөмжид нийцүүлэн шинэчлэх;
- ХӨСҮТ-ийн лабораториудын хүчин чадлыг сайжруулж, хүний нөөцийг тусгайлан бэлтгэх, тус байгууллагыг гамшгийн үед чанарын хяналт, баталгаажуулалтын үндсэн үүргээ хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах;
- Цаашид өдөрт хийх шинжилгээний тоог 100 мянга орчимд хүргэхийн тулд нэг дор 384 дээж дээр ПГУ хийх боломжтой технологийг нутагшуулж, одоо байгаа хүчин чадлыг 3 дахин өсгөх боломжийг бий болгох;
- Монгол Улсын хүн амын дунд илэрч буй коронавирүсийн геномын судалгааг тасралтгүй тогтмол хийж, мутацид орж буй байдлыг нуклейн хүчлийн дараалал тогтоох замаар хянах;
- “Нэг хаалга-Нэг шинжилгээ” хөтөлбөрт оролцсон лабораториудад чанарын гадаад үнэлгээг дахин хийж бага вирүсийн ачаалал бүхий сорьцод вирүс илрүүлж чадаж байгааг шалгах.

Нийслэлийн онцгой комисст:

- Нийслэлийн онцгой комиссоос гамшгийн үеийн төлөвлөлтийг боловсруулж нэгдсэн арга зүйгээр дүүргүүдийг хангаж, хяналт тавих, үйл ажиллагааны үр дүнг нэгтгэхэд анхаарч ажиллах.

Шалгагдагч байгууллагаас ирүүлсэн санал

Аудитын хугацаанд буюу 2021 оны 2 дугаар сарын 11-ээс 23-ны хооронд аудитаар илэрсэн асуудлуудад өдөр бүр завсар үеийн зөвлөмжийг УОК, Шадар сайдын ажлын алба, НОК-т хүргүүлж ажилласан бөгөөд аудитын явцад НОК-с 2 удаа зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажилласан тухай саналаа ирүүлсэн.

Аудитын тайлангийн эцсийн төсөлд санал авах талаар уулзалтыг 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдөр МУ-ын Шадар сайд, УОК-ийн дарга С.Амарсайхантай хийж тайланг хүргүүлсэн боловч тодорхой санал ирүүлээгүй болно.

ИТ "НЭГ ЛГА-НЭГ ИЛГЭЭ"-ТЭЙ БООТОЙ ДЛЫН ДҮН	28,338,920,478.69	11,375,726,930.96	5,921,919,263.00	794,046,546.00	312,176,043.00	18,403,868,782.96	9,935,051,695.73	64.
лого сарсан гэдэд сний нгамж сний нгамжийн вэрлэлтийн дал	2,216,908,624.00			9,294,000.00		9,294,000.00	2,207,614,624.00	0.
	105,940,000.00					-	105,940,000.00	-
үнсний гамжийн длын дүн	2,322,848,624.00	-	-	9,294,000.00		9,294,000.00	2,313,554,624.00	0.
ЗАРДЛЫН ДҮН	30,661,769,102.69	11,375,726,930.96	5,921,919,263.00	803,340,546.00	312,176,043.00	18,413,162,782.96	12,248,606,319.73	65.
г хаалга-нэг нжилгээнд мрагдсан ний тоо	411,000.00					442,303.00		107.
г хаалга-нэг нжилгээний длын дүн өгрөгөөр/	30,661,769,102.69					18,413,162,782.96		60.
г хүнд гдох нжилгээний ндаж өртөг өгрөгөөр/	74,602.84					41,630.20		55.

Хавсралт 2.

ХУДАЛДАН АВАЛТ			
Барааны нэр	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
Худалдан авалт Пос Машин ЭМЯ	1,500,000.00	80.00	120,000,000.00
Худалдан авалт Пос Машин НЭМГ	880,000.00	200.00	176,000,000.00
Хогийн уут НЭМГ	300.00	1,600.00	480,000.00
	180.00	7,200.00	1,296,000.00
	2,269.00	385.00	873,565.00
	2,149.00	149.00	320,201.00
Пос машины стикер цаас НЭМГ	3,000.00	4,700.00	14,100,000.00
Худалдан авалтын дүн			313,069,766.00

Хавсралт 3